

**ДЭЛХИЙ ДАХИНЫ**

**ХҮНИЙ ЭРХИЙН**

**ТӨЛӨВ БАЙДАЛ**

**2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САР**



**ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ**



**Эмнести Интернэшнл нь хүн бүрд эрхийг нь эдлүүлэхийн төлөө хүмүүсийн хүнлэг сэтгэлд тулгуурлан кампанит ажил өрнүүлдэг 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн дэлхий даяарх хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөн юм.**

**Бид эрх баригчид олон улсын эрх зүй, хэм хэмжээг хүндэтгэдэг, хариуцлагаа хүлээдэг, амлалтдаа хүрдэг дэлхий ертөнцийг бий болгохын төлөө ажилладаг.**

**Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл суртал, эдийн засгийн ашиг сонирхол, шашин шүтлэгээс ангид бие даасан, хараат бус бөгөөд гишүүд дэмжигчдийнхээ хандив тусламжаар санхүүждэг. Хүмүүс эв санааны нэгдэлтэй, хүмүүнлэг энэрэнгүй байснаар илүү сайхан нийгмийг бий болгож, өөрчилж чадна гэдэгт бид итгэдэг.**

© Эмнести Интернэшнл 2026

Энэ баримт бичгийн агуулга нь Creative Commons лицензтэй болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг вэб сайтаас үзнэ үү:

[www.amnesty.org](http://www.amnesty.org)

Анхны хэвлэлт 2026 он

Эмнести Интернэшнл

Peter Benenson House, 1 Easton Street, London WC1X 0DW, UK

**Индекс: POL10/0320/2026**

**ISBN: 978-0-86210-512-9**

**Эх хэл: Англи**

**amnesty.org**

**amnesty.mn**

# ГАРЧИГ

<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР</b>	<b>2</b>
<b>ӨМНӨТГӨЛ</b>	<b>5</b>
<b>ДЭЛХИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ</b>	<b>12</b>
Олон улсын эрх зүйн гэмт хэргүүд	13
Шийтгэх болон дарангуйлах үйл ажиллагаа	16
Ялгаварлан гадуурхалт	18
Эдийн засаг, уур амьсгалын шударга бус байдал	21
Технологи ба хүний эрхэд учруулах хор уршиг	24
<b>АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ</b>	<b>27</b>
<b>АМЕРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ</b>	<b>37</b>
<b>АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ</b>	<b>46</b>
<b>ЕВРОП, ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ</b>	<b>58</b>
<b>ОЙРХ ДОРНОД БОЛОН ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ</b>	<b>69</b>

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

### **AI – ЭйАй/ЭИ**

Artificial intelligence  
Хиймэл оюун ухаан

### **ASEAN – АСЕАН**

Association of Southeast Asian Nations  
Зүүн өмнөд Азийн орнуудын хамтын  
нийгэмлэг

### **AU – АХ**

African Union  
Африкийн холбоо

### **CEDAW – ЭАБХУК**

UN Convention on the Elimination of All  
Forms of Discrimination against Women  
Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг  
устгах тухай НҮБ-ын конвенц

### **CEDAW Committee –ЭАҮУХ**

UN Committee on the Elimination of  
Discrimination against Women  
Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгах  
НҮБ-ын хороо

### **CERD – АҮАҮБХҮОУК**

International Convention on the Elimination  
of All Forms of Racial Discrimination  
Арьс үндсээр алагчлах үзлийн бүх  
хэлбэрийг устгах тухай олон улсын  
конвенц

### **CERD Committee – АҮАҮУ хороо**

UN Committee on the Elimination of  
Racial Discrimination  
Арьс үндсээр алагчлах үзлийг устгах  
НҮБ-ын хороо

### **COP30 – COP30**

The 30th Conference of the Parties (COP)  
to the UN Framework Convention on  
Climate Change  
НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн  
суурь конвенцийн Талуудын 30 дугаар  
Бага хурал

### **DRC-БНАКУ**

The Democratic Republic of the Congo  
Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс

### **ECOWAS –БАҮЭЗХН**

Economic Community of West African States  
Баруун Африкийн улсуудын Эдийн  
засгийн хамтын нийгэмлэг

### **Escazú Agreement –Эсказугийн хэлэлцээр**

Regional Agreement on Access to  
Information, Public Participation and

Justice in Environmental Matters in Latin  
America and the Caribbean  
Латин Америк ба Карибын тэнгисийн  
орнуудын хүрээлэн буй орчны  
асуудлаарх мэдээллийн хүртээмж, олон  
нийтийн оролцоо, шударга ёсны тухай  
бүс нутгийн хэлэлцээр

### **EU – ЕХ**

European Union -Европын холбоо

### **European Committee for the Prevention of Torture**

#### **Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын хороо**

European Committee for the Prevention  
of Torture and Inhuman or Degrading  
Treatment or Punishment

Эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар буюу  
хүний нэр төрийг доромжлон харьцаж,  
шийтгэхээс урьдчилан сэргийлэх  
Европын хороо

### **European Convention on Human Rights**

#### **Европын Хүний эрхийн конвенц**

(European) Convention for the Protection of  
Human Rights and Fundamental Freedom  
Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах  
Европын конвенц

### **GDP-ДНБ**

Gross Domestic Product  
Дотоодын нийт бүтээгдэхүүн

### **ICC – ОУЭШ**

International Criminal Court  
Олон улсын Эрүүгийн Шүүх

### **ICCPR – ИУТЭОУП**

International Covenant on Civil and  
Political Rights

Иргэний болон улс төрийн эрхийн тухай  
олон улсын пакт

### **ICESCR – ЭЗНСЭОУП**

International Covenant on Economic, Social  
and Cultural Rights

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн  
тухай олон улсын пакт

### **ICRC – ОУУЗХ**

International Committee of the Red Cross  
Олон улсын Улаан Загалмайн Хороо

### **ILO – ОУХБ**

International Labour Organization  
Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага

**International Convention against enforced disappearance**

Хүчээр алга болгохын эсрэг олон улсын конвенц

International Convention for the Protection of All Persons from Enforced Disappearance

Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц

**INGO – ОУТББ**

International non-governmental organization  
Олон улсын төрийн бус байгууллага

**Istanbul Convention**

**Истанбулын Конвенц**

Council of Europe Convention on preventing and combating violence against women and domestic violence

Гэр бүл дэх хүчирхийлэл ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай Европын зөвлөлийн Конвенц

**LGBTI – ЛГБТИ**

Lesbian, gay, bisexual, transgender and intersex

Лесбиан, гей, бисексуал, трансжендэр, интерсекс

**Ljubljana – The Hague Convention**

Любляна-Гаагийн конвенц

Ljubljana–The Hague Convention on International Cooperation in the Investigation and Prosecution of the Crime of Genocide, Crimes against Humanity, War Crimes and Other International Crimes  
Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенц

**MP – ПГ**

Member of parliament  
Парламентын гишүүн

**NATO –НАТО**

North Atlantic Treaty Organization  
Умард Атлантын Гэрээний Байгууллага

**NDC –ҮТХН**

Nationally determined contribution  
Үндэсний тодорхойлсон хувь нэмэр

**NGO – ТББ**

Non-governmental organization  
Төрийн бус байгууллага

**OAS – АУБ**

Organization of American States  
Америкийн улсуудын байгууллага

**ООНА – ХХЭГ**

United Nations Office for the Coordination of Humanitarian Affairs  
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүмүүнлэгийн хэрэг эрхлэх газар

**ОНЧР the UN human rights office– ХЭДКГ**

Office of the United Nations High Commissioner for Human Rights  
НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газар

**OSCE – ЕАБХАБ**

Organization for Security and Co-operation in Europe  
Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага

**УК-ИБУИНВУ**

United Kingdom of Great Britain and Northern Ireland  
Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс

**UN – НҮБ**

United Nations  
Нэгдсэн Үндэстний Байгууллага

**UN Convention against Torture НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц**

Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment  
Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц

**UN Refugee Convention НҮБ-ын Дүрвэгсдийн тухай конвенц**

Convention relating to the Status of Refugees  
Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц

**UN Special Rapporteur on climate change Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч**

UN Special Rapporteur on the Promotion and Protection of Human Rights in the Context of Climate Change  
Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд хүний эрхийг дэмжих, хамгаалах асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

**UN Special Rapporteur on extrajudicial executions Шүүхээс гадуур цаазлах асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч**

UN Special Rapporteur on Extrajudicial, Summary or Arbitrary Executions

Шүүхээс гадуур буюу дур мэдэн цаазлах асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

**UN Special Rapporteur on extreme poverty  
Нэн ядуурлын асуудлаарх НҮБ-ын  
Тусгай илтгэгч**

UN Special Rapporteur on Extreme Poverty and Human Rights

Нэн ядуурал ба хүний эрхийн асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

**UN Special Rapporteur on freedom of  
expression**

**Үзэл бодлоо илэрхийлэх эрх  
чөлөөний асуудлаарх НҮБ-ын Тусгай  
илтгэгч**

UN Special Rapporteur on the Promotion and Protection of the Right to Freedom of Opinion and Expression

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, хамгаалах асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

**UN Special Rapporteur on human  
rights defenders**

**НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын  
асуудлаарх Тусгай Илтгэгч**

UN Special Rapporteur on the Situation of Human Rights Defenders

НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай Илтгэгч

**UN Special Rapporteur on racism**

**Арьс үндсээр алагчлах үзлийн  
асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч**

UN Special Rapporteur on Contemporary

Forms of Racism, Racial Discrimination, Xenophobia and Related Intolerance  
Ялгаварлан гадуурхах, арьс өнгөөр алагчлах, жигших, үл тэвчих орчин үеийн хэлбэрийн асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

**UN Special Rapporteur on truth, justice  
and reparation**

UN Special Rapporteur on the Promotion of Truth, Justice, Reparation and Guarantees of Non-Recurrence

НҮБ-ын Үнэн, шударга ёс болон эрх сэргээх асуудал хариуцсан Тусгай илтгэгч

**UN Special Rapporteur on torture  
Эрүүдэн шүүхийн асуудлаарх НҮБ-  
ын Тусгай илтгэгч**

UN Special Rapporteur on Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний

нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

**UN Special Rapporteur on violence  
against women and girls**

**Охид, эмэгтэйчүүдийн эсрэг  
хүчирхийллийн асуудлаарх НҮБ-ын  
Тусгай илтгэгч**

UN Special Rapporteur on Violence Against Women and Girls, Its Causes and Consequences

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дагаврын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

**UNDP – НҮБХХ**

UN Development Programme  
НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр

**UNESCO – ЮНЕСКО**

United Nations Educational, Scientific and Cultural Organization

НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага

**UNHCR, the UN refugee agency**

**ДДКГ, Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн  
НҮБ-ын Дээд комиссар**

Office of the United Nations High Commissioner for Refugees

Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Дээд Комиссарын Газар

**UNICEF – ЮНИСЕФ**

United Nations Children’s Fund  
НҮБ-ын Хүүхдийн сан

**UPR – ЭДХ**

UN Universal Periodic Review  
НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлэг

**US-HY**

United States (adjective)  
Нэгдсэн Улсууд

**USA-АНУ**

United States of America  
Америкийн Нэгдсэн Улс

**USAID –АНУОУХА**

United States Agency for International Development  
АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг

**WHO – ДЭМБ**

World Health Organization  
Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

# ӨМНӨТГӨЛ

2025 онд газар сайгүй араатнууд хөлхөж олз хайн ангуучлав. АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трамп, ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путин, Израилийн ерөнхий сайд Беньямин Нетаньяху зэрэг олон улс төрчид дарангуйлал, түрэмгийлэл, хүчирхийллийг ашиглан эдийн засаг, улс төрийн ноёрхлоо тогтоохыг оролдож байна.

Дэлхий ертөнц ийм харгис балмад орчин руу аажмаар шилжиж байгааг Эмнести Интернэшнл эртнээс анхааруулан хэлж ирсэн. Харин 2025 он бол Холокост, дэлхийн дайны аймшигт сүйрлээс хойш өнгөрсөн 80 жилийн хугацаанд сургамж авч, хангалттай бэхжүүлж чадаагүй ч аажим аажмаар, арай ядан бий болгосон олон улсын дэг журмыг дарин дээр давс нэмсэн мэт эрс үгүйсгэсэн, их ухралтын жил боллоо.

Харамсалтай нь олон улсын дэг журмыг эвдэж буй араатнуудтай нүүр тулан сөрөн зогсохын оронд ихэнх засгийн газрууд, тэр дундаа Европын улс орнууд буулт хийж, тохиролцоонд хүрэхийг илүүд үзэж байв. Зарим нь тэднийг аялдан дагалдаж, нөгөө хэсэг нь тэдний сүүдэрт нуугдан хоргодлоо. Маш цөөн улс л тэдний эсрэг сөрөн зогсож чадсан.

Төрлөөр устгах болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг дуугүй хүлцэн тэвчих, эсхүл хамжин дэмжих, мөн шударга ёсыг тогтоохын төлөө ажиллаж буй хүмүүст хатуу хориг арга хэмжээ авах зэргээр хүний эрхийн хамгаалалтуудыг нэг нэгээр нь эвдэж байна.

Ийнхүү 2025 он харгис дээрэлхэгч, араатнууд ноёлсон; олон улсын хүний эрх үүрэг, хариуцлагаас урван тэрсэлж, улс төрийн тохиролцоогоор хүчирхийллийн галыг улам өрдсөн; өөрсдийн сул дорой байдлыг хамгаалсан; өөрсдийгөө төдийгүй ирээдүй хойчийн олон үеийг ноцтой аюулд хүргэх сүйрлийн галаар наадсан жил болон түүхэнд тэмдэглэгдэн үлдлээ.

## ХИЙ ХООСОН ЗҮЙЛ ОГТ БИШ

Зарим нэг нь 2025 онд нураагаад байх зүйл бараг үлдээгүй, аль хэдийн хэврэгшсэн олон улсын дэг журам нь Барууны хүчирхэг орнуудад илүү давуу байдал олгохоос цаашгүй болсон хэмээн үзэж магадгүй. Зарим нь 2025 он өмнө нь таатай мэт харагдаж байсан хуурмаг ойлголтыг бүрэн илчилж, түүний жинхэнэ мөн чанарыг ил гаргасан жил болсон хэмээн үзэж болох юм.

Энэ мэт тайлбарууд нь Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш бүрэлдэн тогтсон дүрэмд суурилсан дэг журмын түүхийг гажуудуулан гуйвуулж буй хэрэг юм. Энэ нь дэлхийн өнцөг булан бүрд хүчирхэг тоглогчдын эсрэг сөрөн зогсож, дүрэмд суурилсан олон улсын дэг журмыг төсөөлөн урлаж, бэхжүүлж, хамгаалан тэмцсээр ирсэн, дүрэмд суурилсан дэг журмыг үндсэн зорилгодоо нийцэн ажиллахыг тасралтгүй шаардсаар ирсэн үе үеийн дипломатчид, иргэний нийгмийн зүтгэлтнүүдийн үнэлж баршгүй хөдөлмөрийг үгүйсгэж байна.

1948 онд Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Төрлөөр

устгахын эсрэг конвенцыг баталж, улмаар дараагийн 80 жилийн хугацаанд хэлэлцэн баталсан олон улсын бусад баримт бичгүүд нь хийсвэр зүйл огт биш. Эдгээр нь дэлхийн дайны дараа жигшүүрт харгислал дахин давтагдахгүй байх зорилготой, түгээмэл хүний эрхийг суурь зарчим болгосон, тэгш эрхтэй улс орнуудын олон талт тогтолцоонд тулгуурласан дэг журмын бодит биелэл юм.

Энэхүү тогтолцооны амлалт бүрэн биелээгүй хэвээр байгааг бид бүгд мэднэ. Гэхдээ үүрэг амлалтаа зөрчигчид үүнийг хий хоосон зүйл хэмээн зарлах эрхгүй.

Түүнчлэн энэхүү тогтолцоо хэзээ ч зөвхөн хүчирхэг улс орнуудын гарт байгаагүй. Харин ч энэхүү тогтолцоог анх хүн төрөлхтөн өлгийдөн авахад жижиг гэгдэх улс орнууд томоохон гүрнүүдийг давж чадсан. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд ялгаварлалгүйгээр, бүх хүнд, мөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрхийг тэгш байдлаар хүлээн зөвшөөрөх заалтуудыг тусгасан нь чухам тэдний гавьяа юм.

Түүнээс хойш колоничлолын эсрэг тэмцэл, чөлөөлөх хөдөлгөөнүүд эдгээр зарчмаас эрч хүчийг авч, хууль ёсны үндэслэлээ бататгасан бөгөөд эдгээрийн ихэнх нь Европын гүрнүүдийн хүсэл зоригоос гадуур байсан. Африк, Карибын тэнгисийн орнууд, Латин Америк, Азийн шинэ улсууд, мөн дэлхий даяарх иргэний нийгмийн байгууллагууд АНУ-ын хүсэл зоригийг үл харгалзан хамтын хүчээр Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Арьс үндсээр ялгаварлан гадуурхалтыг устгах тухай конвенц зэрэг баримт бичгүүдийг хөгжүүлэх үйл явцыг манлайлсан.

Олон улсын хүний эрхийн баримт бичгүүдийн нөлөөгөөр сүүлийн 80 жилийн хугацаанд дэлхий ертөнц асар их зэрэгээр өөрчлөгдсөн. Улсууд хоорондын эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг бууруулах, арьс үндсээр ялгаварлагдсан болон уугуул хүмүүс, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эрхийг хүлээн зөвшөөрч хамгаалах, бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, хөдөлмөрлөх эрхийг үндэсний хууль тогтоомжид тусган, тэгш эрхийг хангах зэргээр илүү шударга байдал руу чиглэж ирсэн.

Эндүүрэх хэрэггүй: дүрэмд суурилсан олон улсын дэг журам мөхсөн гэх яриа үлэмж хэтрүүлэг юм. Ийнхүү мөхсөн гэх яриа нь уг тогтолцоо үр ашиггүй, чадваргүй, эсвэл хэт удаан байгаатай холбоогүй. Харин улс төр, эдийн засгийн хувьд ноёрхогч хүчнүүд болон тэднийг аялдан дагалдагч нарын ашиг сонирхолд нийцэхээ больсонтой холбоотой юм. Одоо тэд энэ тогтолцоог анхнаасаа бодит бус, цаг үеэ өнгөрөөсөн хий хоосон зүйл байсан мэт ойлгуулахыг оролдож байна.

Үүнийг бид хүлцэн тэвчиж, эвлэрч хэрхэвч болохгүй. Ингэхдээ хэм хэмжээний суурь хамгаалалтуудыг бат найдвартай хамгаалж, 1948 оноос эхлэлтэй дүрэмд суурилсан дэг журмын эсрэг ноцтой халдлагуудыг таслан зогсоож, түүний амлалтыг бүрэн хэрэгжүүлэх чиглэлд өөрчлөлт шинэчлэлт хийх шаардлагатай.

Гэхдээ энэ нь уг тогтолцооны хэрэгжилтэд тулгарч байгаа давхар стандартыг нуун халхавчлах, эсхүл түүний үр нөлөө муутай байдлыг өөгшүүлэн хамгаална гэсэн уг биш. Мөн түүний түгээмэл гэх амлалт олонтоо зөрчигдөж, сая сая хүн хамгаалалтаас гадуур үлдэж байгаа бодит байдлыг үл ойшоох ёсгүй. Израилын төрлөөр устгах гэмт хэрэг, апартейд, эзлэн түрэмгийллийн хохирогч болсон палестинчууд, улс орон нь нээлттэй хорих газар мэт болсон Афганистаны эмэгтэйчүүд,

мөн 2026 оны эхээр орчин үеийн түүхэнд хараар тэмдэглэгдэн үлдэх үй олноор хөнөөх ажиллагаанд өртсөн Ираны эсэргүүцэгчид эдгээр түүхийн гэрч юм.

Дүрэмд суурилсан дэг журам руу чиглэсэн Дональд Трамп, Владимир Путин нарын халдлагыг эсэргүүцнэ гэдэг нь Хятадын үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрнө гэсэн үг биш. Дүрэмд суурилсан дэг журмаас өөр хувилбар гэж байхгүй. Хятад улс мөн адил хүний эрхийг тууштай үгүйсгэж, олон улсын конвенцуудын хяналтаас татгалзаж ирсэн. Хятад өөр арга өөр хэрэгслээр ноёрхолоо тогтоох гэж эрмэлзэж болох ч эцсийн үр дүн нь адилхан мөн л тэгш бус байдал, дарангуйлал юм.

## **ШИНЭ ДҮРЭМ ЖУРАМ БИЙ БОЛОХ УУ?**

1948 онд эхлэл нь тавигдсан, төгс бус ч гэсэн дэлхийд туршигдсан энэ дэг журмыг орлох ямар нэгэн хувилбар байгаа юу? Олон улсын эрх зүйг доройтуулах, Олон улсын эрүүгийн шүүх рүү дайрах, гэрээ конвенцоос гарах, Нэгдсэн Үндэстний Байгууллагын агентлагуудаас гарах явдал газар авсаар байна. Тэдгээр араатнууд өөрсдөө хориг тавих эрхээ зүй бусаар хэтрүүлэн ашиглаж, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийг саажилтад оруулчихаад, энх тайван, аюулгүй байдлын механизм ажиллахгүй байна хэмээн зарлаж, өөрсдөд ашигтай “хувилбар”-аар солихыг эрмэлзэж байна.

Тэдний хүсч буй дэг журам нь арьс үндэс болон жендэрийн шударга ёсыг үгүйсгэж, эмэгтэйчүүдийн эрхийг доромжилж, иргэний нийгмийг нийгмийн дайсан мэтээр тодорхойлж, олон улсын эв санааны нэгдлийг няцаадаг. Энэ нь цэргийн зардал, хөрөнгө оруулалтыг урьд өмнө байгаагүй хэмжээнд нэмэгдүүлэх, хууль бус зэвсгийн наймааг өөгшүүлэх, олон улсын тусламжийн төсвийг огцом танах, ингэснээр урьдчилан сэргийлэх боломжтой олон сая хүний амь насыг эрсдэлд оруулж, хүний эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, хэвлэлийн эрх чөлөөний төлөө ажилладаг мянга мянган байгууллагыг үгүйрүүлж байна.

Араатнуудын боловсруулсан дэлхийн дэг журмын өөр хувилбар нь эсэргүүцэл, шүүмжлэлийг дарангуйлж, эсэргүүцлийн жагсаалыг хүчээр тарааж, хүн ёсноос гажууд суртал ухуулгыг түгээж, үзэн ядалтын гэмт хэргийг өөгшүүлэн, хуулийг зэвсэг болгон ашиглах нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ нь хүмүүнлэг ёсонд бус, харин худалдааны давамгайл байдал, технологийн ноёрхолд тулгуурлаж байна.

2026 оны эхээр энэхүү “шинэ дэг журам”-ын үзэл баримтлалыг Америкийн Нэгдсэн Улсын Төрийн нарийн бичгийн дарга Марко Рубио тодорхой илэрхийлсэн бөгөөд тэрээр АНУ-аар удирдуулсан, Христийн шашинт Барууны холбоотон улс орнуудын нийтлэг өвд тулгуурласан тогтолцоог хайрын холбоо мэт танилцуулсан юм. Гэвч ямар ч үг хэллэг бодит үнэнийг нууж чадахгүй: энэ нь мөн ноёрхол, колониал, боолчлол, төрлөөр устгах үйл ажиллагааны түүх билээ.

Энэхүү “шинэ” гэгдэх үнэндээ аль хэдийн танил болсон тогтолцоонд араатнууд болон тэдний дагагчид улс дотроо болон улсууд хоорондын тэгш эрх, шударга ёсыг эрэлхийлэгчдийг зэмлэн буруушааж, айлган сүрдүүлж, хавчин мөрдөж байна.Түүхэн шударга бус явдалд хариуцлага хүлээж, засах оролдлогыг үл тоомсорлож,

тохуурхаж байна. Энэхүү тогтолцоонд дипломат арга ухаан бус, дайн түрэмгийлэл ноёрхож байна. Газын зурвас дахь Палестинчуудын эсрэг Израилын үйлдэж буй төрлөөр устгах гэмт хэрэг “гал зогсоо” нэрийн дор үргэлжилсээр; Украинд Оросын хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг улам даамжирч; АНУ-аас Венесуэл, Ираны нутагт хил дамнанас, шүүхээс гадуурх аллага явуулж; мөн Гринландыг булаан авах тухай сүрдүүлгээ үргэлжлүүлсээр байна. Мьянмар, Судан, Конгын Ардчилсан Бүгд Найрамдах Улсад олон тооны гэмт хэрэг хяналтгүй үргэлжилсээр; Ойрх Дорнод эмх замбараагүй байдалд дахин автаж, улам олон улсыг хамран өргөжих аюултай нөхцөл үүсээд байна.

Энэ бол ёс суртахууны чиг баримжаагүй илт ноёрхлын төлөөх эрмэлзэл юм.

## **2026 ОНД ЧИГ ХАНДЛАГА ӨӨРЧЛӨГДӨХ ҮҮ?**

Цөөн тооны улс л дипломат яриа хэлэлцээр бус их бууны нүргээг сонгож байгаа явдлыг эсэргүүцэх зориг гаргалаа. Зарим нь олон улсын эрх зүйг хамгаалах, Палестинчуудтай эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлэх зорилгоор “хууль эрх зүйн болон дипломат арга хэмжээний зохицуулалт”-г хэрэгжүүлэхээр зорьсон улс орнуудын эвсэл болох “Гаагийн бүлэг”-т нэгдээд байна. Зарим улс Израилын эсрэг Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын гаргасан төрлөөр устгах хэргийн талаарх гомдлыг дэмжсэн. Канад улс Дунд Гүрнүүдийг хамтран ажиллаж, хамтдаа сөрөн тэсвэрлэхийн төлөө ажиллахыг уриалжээ. Харин Испани зэрэг цөөн хэдэн улс хэм хэмжээний хамгаалалтын суурь зарчмуудыг бутарган сулруулж буй явдлыг тогтмол шүүмжлэн буруутгаж байна.

2026 оны эхээр зарим Европын улс орон эрсдлийг бүрэн ухамсарлаж, АНУ болон Израилын Иран руу чиглэсэн халдлагад нэгдэхээс татгалзан, стратегийн тусгаар тогтнолоо хамгаалах амлалт өгсөн боловч Европын Холбоо олон улсын эрх зүй болон түгээмэл хүний эрхийг дээдлэх зарчмыг дахин баталгаажуулж чадсангүй.

## **ДЭЛХИЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ТҮҮШТАЙ ХАМГААЛАХ НЬ**

Эрх мэдэлтнүүдийн эсрэг дуугарсны төлөө өс хонзонд өртөх вий гэсэн айдас дэлхий дахиныг нөмөрчээ. Гэвч 2025 оны туршид “хий хоосон” хэмээн нэрлэгдэж буй олон улсын дүрэмд суурилсан дэг журмын суурийг үргэлжлүүлэн бэхжүүлэх засгийн газруудын үйл ажиллагаа, даян дэлхийн хүний эрхийн хэм хэмжээг хамгаалах иргэний нийгмийн байгууллагуудын тууштай, шийдэмгий байдал мөн өргөжин тэлсээр байна.

Европын Зөвлөл Украинд үйлдэгдсэн түрэмгийллийн гэмт хэргийг шүүх Тусгай шүүхийг байгууллаа. Олон улсын эрүүгийн шүүхээс Афганистан улсын Талибаны хоёр удирдагчийг жендэрт суурилсан хавчлагын хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутган баривчлах тушаал гаргасны зэрэгцээ Ливийн иргэдийн эсрэг үйлдэгдсэн дайны болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт холбогдогчдыг баривчлах тушаалуудыг ил болгосон. Төв Африкийн Бүгд Найрамдах Улсад үйл ажиллагаа явуулдаг холимог эрүүгийн шүүх зэвсэгт бүлэглэлийн зургаан гишүүнийг дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт ялласан. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл Афганистаны нөхцөл байдлыг шалгах бие даасан мөрдөн хяналтын механизм

байгуулсан. Филиппиний ерөнхийлөгч асан Родриго Дутерте-ийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт холбогдуулан баривчлах тушаалын дагуу Олон улсын эрүүгийн шүүхэд шилжүүлсэн. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Нэгдүгээр хорооны хуралдаанаар 156 улс хүний оролцоогүйгээр зорилтод объектод халдах чадвартай зарим төрлийн зэвсгийн системийг хориглох олон улсын эрх зүйн баримт бичиг боловсруулах хэлэлцээг дэмжсэн. Долдугаар сард Европын Холбоо Эрүү шүүлтэд ашиглагдах бараа бүтээгдэхүүний худалдааг хязгаарлах Эрүү шүүлтийн эсрэг зохицуулалтын хамрах хүрээг өргөжүүлсэн. 2025 онд НҮБ-ын татварын конвенц батлах чиглэлд чухал ахиц гарлаа. COP30 хурлын үеэр иргэний нийгэм болон үйлдвэрчний эвлэлийн шахалт нь улс орнууд цэвэр эрчим хүч болон уур амьсгалд дасан зохицох ирээдүй рүү шилжих явцдаа ажилтнууд болон орон нутгийн иргэдийг хамгаалах “Шударга шилжилтийн механизм”-ыг батлахад хувь нэмэр оруулсан. Олон улсын шүүх болон Америк хоорондын Хүний эрхийн шүүхээс уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн хохиролд хариу арга хэмжээ авах нь төрийн хүний эрхийн үүрэг мөн болохыг баталгаажуулсан зөвлөх дүгнэлтүүд гаргасан. Колумб болон Нидерланд улсууд 2026 оны дөрөвдүгээр сард Чулуужсан түлшнээс татгалзах шилжилтийн тухай Олон улсын анхны бага хурлыг хамтран зохион байгуулахаар тохиролцлоо. Франц, Грек, Итали, Марокко, Испани, Швед зэрэг улсад өрнөсөн боомтын ажилтнуудын өргөн хүрээний ажил хаялт, эсэргүүцлийн хөдөлгөөнүүд Израил руу чиглэсэн зэвсгийн тээвэрлэлтийг тасалдуулсан. 2025 онд Бельги, Боливи, Канад, Колумб, Куба, Гондурас, Малайз, Намиби, Словени, Өмнөд Африк болон Испани зэрэг улсууд Израилтай хийх зэвсгийн худалдаагаа өөрчлөх эсвэл зогсоохоор амлалаа. Дани, Фарерын арлууд, Норвеги, Люксембург болон Малави зэрэг улс эмэгтэйчүүдийн үр хөндөлтийн эрхийн хамгаалалтыг өргөжүүлсэн. Непалд залуучуудын манлайлсан авлигын эсрэг бослого хөдөлгөөн засгийн газрыг огцруулахад хүргэв.

## **Бид эсэргүүцсэн.Бид эсэргүүцэх ёстой. Бид эсэргүүцэн сөрөн зогссоор байх болно.**

Энэ бол зүгээр нэг “сорилттой үе” биш. Энэ бол өнгөрсөн 80 жилийн турш бүтээн босгосон бүхнийг сүйтгэхээр аюул заналхийлж буй түүхэн сорилтын үе юм. Ард иргэд бид энэхүү түүхэн мөчид босон тэмцэх ёстой. Бид энэхүү цаг үеийн шаардлагад нийцсэн томоохон зорилго эрмэлзэлтэй байж, мөн түүнтэй зэрэгцэн өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан өөрчлөгдөх эр зоригтой байх ёстой. Бид үүнийг улс төрчид, дипломатчидын хувьд; идэвхтнүүд, хэрэглэгчдийн хувьд; ажилтнууд, үйлдвэрлэгчдийн хувьд; сонгогчид, хөрөнгө оруулагчдын хувьд; мөн итгэл үнэмшилтэй болон өөрсдийн итгэлдээ бат зогсох хүний хувиар хийх ёстой. Бид хамтдаа олон талт оролцоонд тулгуурласан хүчирхэг эвсэл, нэгдлүүдийг байгуулж, улс орнуудыг ч мөн адил тийм чиглэлд уриалах ёстой.

“Бид одоо ч сөрөн тэмцээр байгаа” гэдэг нь зөвхөн өөрсдийн хүний эрхийн төлөө бус, харин ирээдүй хойч үеийн эрхийн төлөө хамаг хүчээрээ хамгаалан үлдэх ёстой үнэт зүйлсэд анхаарал төвлөрүүлэхийг хэлнэ. Ингэхдээ бид түрэмгийлэгч төр болон төрийн бус оролцогчдын гаргаж буй асар олон хууль, бодлого, практикийн дундаас мөн ямар зүйлсийг нэн тэргүүнд, ямар ч нөхцөлд таслан

зогсоох ёстойг тодорхой ялгаж харах шаардлагатай. Түүнчлэн эсэргүүцнэ гэдэг нь мөн юуг үндсээр нь өөрчлөх ёстойг тодорхой ойлгохыг хэлнэ. Өөрчлөлт урьд өмнө байгаагүй хурдаар, асар өргөн цар хүрээнд өрнөж буй энэ цаг үед бид мөрөөдлийн хүч, бүтээлч эр зоригтой байдлаа дахин ашиглах шаардлагатай болно. Бид зөвхөн өнгөрсөн үеийн хүний эрхийн зорилгыг хамгаалаад зогсохгүй, ирээдүйн дэлхий ертөнцөд тохирсон шинэ хүний эрхийн өөрчлөлтийг төсөөлөн харах ёстой. Бид хамтдаа бүтээлч, шийдэмгий, тэсвэр хатуужлаараа энэхүү өөрчлөлтийг манлайлан хэрэгжүүлэх ёстой.

Түүх гэдэг нь зөвхөн бидэнд тохиолддог зүйл биш. Түүхийг бид өөрсдөө бүтээдэг. Хүн төрөлхтний төлөө, хүний эрхийн түүхийг өөрчлөх цаг хэдийнэ болсон байна.

**Агнес Калламард**  
**Ерөнхий нарийн бичгийн дарга**  
2026 оны 4 дүгээр сар

**ДЭЛХИЙ ДАХИНЫ**

**ХҮНИЙ ЭРХИЙН**

**ТӨЛӨВ БАЙДАЛ**

**ДЭЛХИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ,  
БҮС НУТГИЙН ТОЙМ**



# ДЭЛХИЙ ДАХИНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эмнести Интернэшнл 2025 онд засгийн газрууд болон бусад оролцогч талуудын үйлдсэн өргөн хүрээний хүний эрхийн зөрчил, хариуцлагын механизмын доголдол, тогтолцооны шударга бус байдлыг баримтжуулсан. Зарим салбарт багахан боловч ахиц гарсан. Энэ дүр зураг 2026 онд ч үргэлжилсээр байх бөгөөд дүрэмд суурилсан олон улсын дэг журам байнгын халдлагад өртсөн хэвээр байна.

Олон улсын эрх зүйн гэмт хэрэг өргөн хүрээнд үйлдэгдсэн. Эдгээрт, Газын зурвас дахь палестинчуудын эсрэг Израилын үйлдсэн төрлөөр устгах гэмт хэрэг, Украинд үйлдсэн Оросын хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, Мьянмар, Судан болон бусад мөргөлдөөний үед үйлдэгдсэн дайны гэмт хэрэг болон олон улсын эрх зүйн бусад гэмт хэргүүд багтсан. Үр дагаварыг үл тоомсорлосон зэвсэг нийлүүлэлт нь харгислал, ноцтой зөрчлүүдийг өдөөсөн хэвээр байсан боловч иргэдийн хөдөлгөөн, хууль зүйн шахалт үзүүлсний үр дүнд зарим улс Израил руу зэвсэг экспортлохыг хязгаарлах, хориглох арга хэмжээ авсан. АНУ болон ОХУ 2025 онд олон улсын хариуцлагын механизм, ялангуяа Олон улсын эрүүгийн шүүхийг сулруулахад нөлөөлсөн бол хэд хэдэн улс Ромын дүрмээс гарахаа мэдэгдсэн. Үүнийг үл харгалзан Олон улсын эрүүгийн шүүх болон бусад механизмууд тодорхой баривчилгаа явуулж, ял шийтгэл оногдуулж, Украинд үйлдсэн түрэмгийллийн гэмт хэргийг шалгах тусгай шүүх зэрэг шинэ мөрдөн шалгах байгууллагуудыг бий болгосон.

Дэлхий даяар дарангуйлагч арга барил эрчимжсэн. Афганистан, Хятад, Египет, Энэтхэг, Иран, Кени, Нэгдсэн Вант Улс, АНУ, Венесуэл зэрэг улсын засгийн газрууд 2025 онд эсэргүүцлийн жагсаал цуглааныг хүчээр тараах, терроризм болон аюулгүй байдлын хууль тогтоомжийг ашиглан эсэргүүцэл, шүүмжлэлийг гэмт хэрэгт тооцох, хүчээр алга болгох, цаазлах, хүчирхийлэлд суурилсан цагдаагийн арга тактик ашигласан. Цахилгаан гүйдлээр цохигч зэвсэг ашиглах зэргээр эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах явдал өргөн тархсан хэвээр байсан боловч Эрүү шүүлтээс ангид худалдааны тухай НҮБ-ын гэрээг байгуулах чиглэлд зарим ахиц гарсан.

Ялгаварлан гадуурхалт нь үндсэн тулгамдсан асуудал хэвээр байв. Дүрвэгсэд болон цагаач иргэдийг олноор нь албадан гаргах болон арьс үндсээр ялгаварласан бодлогод өртсөн бол уур амьсгалын өөрчлөлтийн улмаас олон улсын хил дамнан шилжин суурьшсан хүмүүс ихэнхдээ хамгаалалтгүй хэвээр үлдсэн. Колоничлол болон байгалийн баялгийг олборлох үйлдвэрлэлтэй холбоотой арьс үндсээр ялгаварлах шударга бус байдал өргөн тархаж, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага нэмэгдсэн. Жендэрт суурилсан хүчирхийлэл болон эмэгтэйчүүдийн эрхийн хязгаарлалт өргөн тархсан хэвээр байв. 2025 онд цөөн тооны улсад үр хөндөхийг зөвшөөрөх, хүүхдийн гэрлэлтийг хориглох чиглэлд хууль эрх зүйн ахиц дэвшил гарсан боловч үр хөндөлт болон үр хөндөлтийн дараах эмчилгээ үйлчилгээ авахад тулгардаг саад бэрхшээлүүд хэвээр үлдсэн. Үүний зэрэгцээ ЛГБТИ хүмүүсийн, ялангуяа трансжендэр хүмүүсийн эрхийн эсрэг халдлагууд дэлхий даяар нэмэгдсэн.

Засгийн газрууд чулуусан түлшний хэрэглээг үе шаттай зогсоох чиглэлд хангалттай арга хэмжээ авч чадаагүй бөгөөд уур амьсгалын санхүүжилт болон дасан зохицох дэмжлэг шаардлагатай түвшинд хүрээгүй. Өрийн дарамт, гадаад тусламжийн бууралт болон дэлхийн эдийн засгийн шударга бус бүтэц нь эдийн засаг, нийгмийн эрхийг доройтуулсан. Байгаль орчинд учруулсан хор хохирол, хөдөлмөрлөх эрхийн зөрчил, шүүхийн маргаан ашиглан дарамт шахалт үзүүлэх зэрэг компанийн хүчирхийлэл 2025 онд үргэлжилсэн хэвээр байсан хэдий ч Европын Холбооны бизнесийн буюу корпорацуудын магадлан шинжилгээг шинэ журмаар сулруулан баталсан.

Эцэст нь, засгийн газрууд дарангуйлагч арга барилыг улам бүр бэхжүүлэхэд технологийг ашигласан. Засгийн газрууд корпорацуудын дэмжлэгтэйгээр хууль бус тандалтыг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах, эсэргүүцлийн хөдөлгөөнийг нухчин дарах зорилгоор хэрэглэсэн. 2025 онд нийгмийн сүлжээний платформуудтай холбоотой хүний эрхийн сөрөг нөлөөлөл үүсгэгч хиймэл оюуны хэрэгслүүдийн эрсдэл илүү тодорхой болсон боловч зохицуулалт нь хоцрогдсон хэвээр байв.

## ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ГЭМТ ХЭРГҮҮД

### ТӨРЛӨӨР УСТГАХ, ХҮМҮҮНЛЭГИЙН ЭСРЭГ БОЛОН ДАЙНЫ ГЭМТ ХЭРГҮҮД

Израил улс Газ дахь Палестинчуудын эсрэг төрлөөр устгах гэмт хэрэг болон мөн бусад олон тооны дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн; 2025 оны 10 дугаар сарын 9-нд Хамастай гал зогсоох хэлэлцээр байгуулсан хэдий ч төрлөөр устгалт үргэлжилсээр байв. Түүнчлэн Палестинчуудын эсрэг апартеидын тогтолцоо нь Зүүн Иерусалим зэрэг эзлэгдсэн Баруун эрэгт өндөр түвшний эрчимжүүлсэн цэргийн ажиллагаа болон Израилын оршин суурьшигчдын үйлдсэн төрийн дэмжлэгтэй хүчирхийлэл огцом өсөлтийн улмаас ноцтой хор уршиг учруулсан. Израилын төрлөөр устгах гэмт хэргийн эсрэг олон нийтийн эсэргүүцлийн жагсаал дэлхий даяар өрнөв. Олон улсын байгууллагууд, улс орнууд, олон төрлийн байгууллагууд Израил улс төрлөөр устгах гэмт хэрэг үйлдсэн болохыг хүлээн зөвшөөрсөн. Гэвч дэлхийн хамгийн хүчирхэг засгийн газрууд төрлөөр устгах гэмт хэргийг зогсоох, Израилын хууль бус эзлэн түрэмгийлэл болон апартеидыг эцэс болгох чиглэлд бодитой, үр дүнтэй арга хэмжээ авсангүй.

ОХУ хүчээр алга болгох, эрүүдэн шүүх, Украины энгийн иргэдийн эсрэг дрон ашиглан халдлага үйлдэх зэргээр хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэрэг үйлдсэн. Мөн Украинд энгийн иргэдийн амьдралд чухал ач холбогдолтой дэд бүтцийг онилж агаараас довтлох ажиллагаагаа эрчимжүүлсэн. Оросын цэргүүд Украины дайнд олзлогдогсдыг шүүхээс гадуур цаазаар авсан тухай мэдээлэл нэмэгдсээр байсан. Орос улс эзлэн авсан нутаг дэвсгэрийн үндэстний ялгарах онцлогийг үгүй хийх арга хэмжээ авсан. Зэвсэгт мөргөлдөөнөөс гадна Венесуэлд сөрөг хүчнийхэн, шүүмжлэгчид болон бусад хүмүүсийг хүчээр алга болгох, дур зоргоор саатуулах, цагдан хорих, эрүүдэн шүүх зэрэг өргөн тархсан үйлдлүүд нь мөн хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцогдох хэмжээнд хүрсэн.

Бусад олон улс оронд үргэлжилж буй мөргөлдөөнд оролцогч талууд дайны гэмт хэрэгт тооцогдох үйлдлүүдийг хийсэн. Засгийн газрын цэргүүд, тэдний холбоотон зэвсэгт бүлэглэлүүд болон эсрэг талын зэвсэгт бүлгүүд мянга мянган энгийн иргэдийг хөнөөсөн. Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс (БНАКУ)-д хэд хэдэн зэвсэгт бүлэглэл хууль бусаар хэдэн зуун энгийн иргэдийг хөнөөсөн; мөн нэгэн зэвсэгт бүлэглэл эмнэлгүүд рүү халдаж, өвчтөн болон асран хамгаалагчдыг хүчээр авч явсан. Мьянмарт цэргийнхэн моторт параглайдер ашиглан тосгон болон бусад газрууд руу тэсрэх бөмбөг хаяж, олон арван энгийн иргэд, түүний дотор хүүхдүүдийг хөнөөсөн; мөн сөргөлдөгч зэвсэг бүлэглэлийн хяналтад байсан бүс нутгуудад хүмүүнлэгийн тусламжийг хаасан. Судан улсын засгийн газрын зэвсэгт хүчин болон тэдний холбоотнууд мөргөлдөгч нөгөө тал болох Шуурхай Дэмжих Хүчнийг дэмжиж, хамтран ажилласан хэмээн сэжиглэсэн хэдэн арван энгийн иргэдийг хөнөөсөн бол Шуурхай Дэмжих Хүчин Хойд Дарфурт хийсэн довтолгооны үеэр энгийн иргэдийг олноор хууль бусаар хөнөөсөн. Африкт удаан хугацаанд үргэлжилж байгаа мөргөлдөөний үеэр Буркина Фасо, Камерун, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс (ТАБНУ), Мали, Мозамбик, Нигер, Нигери, Сомали болон Өмнөд Судан зэрэг улсын засгийн газрын цэргүүд болон зэвсэгт бүлэглэлүүд энгийн иргэд

рүү хууль бусаар халдаж, хөнөөсөөр байв. Сири улсын засгийн газартай холбоотой зэвсэгт бүлэглэлүүд шашны үзлээр ялгаварлан олон зуун энгийн иргэдийг бөөнөөр нь хөнөөсөн.

НҮБ болон бусад байгууллагууд ТАБНУ, БНАКУ, Сомали, Өмнөд Судан, Судан зэрэг улсад зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн хүчирхийлэл, жендэрт суурилсан хүчирхийллийн мянга мянган тохиолдлыг бүртгэсэн. Суданд Шуурхай Дэмжих Хүчин эмэгтэйчүүдийг доромжлох, шийтгэх, орон гэрээ орхиход хүргэх зорилгоор бэлгийн хүчирхийллийг өргөн хүрээтэй, системтэйгээр ашигласан.

**Засгийн газрууд төрлөөр устгах үйл ажиллагааг зогсоохын тулд бодитой, үр дүнтэй арга хэмжээ авах, НҮБ болон бусад олон улсын байгууллагын хүрээнд хамтран ажиллаж, олон улсын эрх зүйн дагуух бүх төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах шаардлагатай.**

## **ХАРИУЦЛАГАГҮЙ ЗЭВСГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ШИЛЖҮҮЛЭГ**

Хамтран буруутгагдах эрсдэлийг үл харгалзан, улс орнууд үр дагаврыг нь үл хайхран зэвсэг нийлүүлэлтээ үргэлжлүүлж, зарим тохиолдолд олон улсын эрх зүйн гэмт хэрэг үйлдсэн хэрэгт холбогдсон этгээдүүдэд ч шилжүүлж байв. АНУ нь Израил улсад өргөн хүрээний цэргийн дэмжлэг үзүүлж, тэргүүлэв.

Арабын Нэгдсэн Эмират Улс Хятадад үйлдвэрлэсэн дэвшилтэт зэвсэг болон хуягт тээвэрлэгч зэргийг Суданы Шуурхай Дэмжих Хүчинд нийлүүлснийг тус бүлэг Дарфурт ашигласан.

Улс орнууд, зэвсгийн компаниудад үзүүлэх дарамт шахалт нэмэгдсэн нь зарим үр дүнд хүрсэн.

2025 оноос өмнө Бельги, Канад, Итали, Япон, Нидерланд, Испани, Их Британи зэрэг улс Израилд зэвсэг нийлүүлэхийг бууруулах зарим арга хэмжээ авч байсан ч ихэнхдээ зөвхөн зэвсгийн экспортын лицензийг шинээр олгохоос татгалзаж, хуучин лицензийн хүрээнд зэвсэг нийлүүлсээр байв. 2025 онд зарим ахиц гарсан. Бельги Улсын шүүхээс Фландерс бүс нутгийг Израил руу зэвсэг дамжуулан тээвэрлэх бүх ажиллагааг зогсоох шийдвэр гаргасан бөгөөд үүнээс өмнө Валлония бүс нутгаас Израилд зэвсэг экспортлохыг хориглоод байсан юм. Герман улсын Засгийн газар Газад ашиглаж болзошгүй зэвсгийн шинэ экспортын лицензийг Израилд олгохгүй хэмээн мэдэгдсэн боловч дараа нь Израил руу зэвсэг экспортлох хоригийг цуцалсан. Хэрэгжилтийн зарим асуудал байсан ч Словени улс Израилтай хийх бүх зэвсгийн худалдаа, дамжин өнгөрүүлэлт болон импортыг хориглоно гэж мэдэгдсэн. Испани улс Израилд зэвсэг нийлүүлэхийг бүрэн хориглох шийдвэрийг хуульчилсан. Олон улсын эрх зүйг хамгаалах, Палестины ард түмэнтэй эв санааны нэгдлээ илэрхийлэх зорилгоор “хууль эрх зүй, дипломат арга хэмжээг уялдуулан хэрэгжүүлэх”-д чиглэсэн Болив, Колумб, Куба, Гондурас, Малайз, Намиб, Сенегал, Өмнөд Африк зэрэг улсаас бүрдсэн Гаагийн бүлгийн улс орнууд Израилтай хийх бүх төрлийн зэвсгийн худалдааг зогсоох амлалт өгсөн. Израил руу зэвсэг нийлүүлэх урсгалыг эсэргүүцсэн дэлхий дахины иргэний хөдөлгөөн өргөжсөн. Итали улсад улс даяар ажил хаялт зохион байгуулагдсан бол Франц, Грек, Итали, Марокко, Испани, Шведын боомтын ажилтнууд Израил руу нийлүүлэх зэвсгийн тээвэрлэлтийн замыг тасалдуулах зорилготой арга хэмжээ зохион байгуулсан.

Гэвч 2025 онд зарим улс зэвсгийн хориглолттой холбоотой үүрэг амлалтаа цуцлах, эсхүл тийнхүү цуцлахаар төлөвлөж байгаагаа илэрхийлсэн. Литва улс Кластер зэвсгийн конвенцоос гарсан нь 2008 онд уг конвенц батлагдсанаас хойш гарсан анхны улс болсон. Мөн Эстони, Финланд, Латви, Литви, Польш зэрэг улсууд Оросын аюул заналхийлэлтэй холбоотойгоор Явган цэргийн эсрэг мина хориглох Оттавын гэрээнээс гарахаар төлөвлөж байгаагаа НҮБ-д мэдэгдсэн. Финланд, Польш

улсын албан тушаалтнууд явган цэргийн эсрэг мина дотооддоо дахин үйлдвэрлэж эхэлнэ хэмээн мэдэгдсэн. Украин улс Оттавын гэрээний үйлчлэлийг түр зогсоох хүсэлтэй байгаагаа НҮБ-д мэдэгдсэн нь уг конвенцын заалтуудтай зөрчилдөж байгаа юм. Гэвч ихэнх улс орнууд хиймэл оюун болон зэвсгийн системийн автоматжуулалттай холбоотой хүмүүнлэгийн, эрх зүйн, ёс суртахууны асуудлуудыг хүлээн зөвшөөрсөн. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Нэгдүгээр хорооны хуралдаанаар хүний оролцоогүйгээр зорилтод объектод халдах чадвартай зэвсгийн системийн талаар олон улсын эрх зүйн баримт бичиг боловсруулах ажлыг урагшлуулах тухай тогтоолд 156 улс дэмжиж санал өгсөн.

**Улс орнууд, компаниуд хариуцлагагүй зэвсгийн бүх дамжуулалт, түүний дотор Израил улс руу зэвсэг нийлүүлэхээ зогсоох шаардлагатай. Улс орнууд "Кластер зэвсгийн конвенц болон Оттавагийн гэрээг хэрэгжүүлэх чиглэлд дахин хүчин чармайлт гаргаж, хүний оролцоогүйгээр зорилтод объектод халдах чадвартай зарим төрлийн зэвсгийн системийн хориглох гэрээг хэлэлцэн батлах, мөн хууль ёсоор ашиглах боломжтой системүүдийн хэрэглээг сайтар хянах шаардлагатай.**

## ЯЛ ЗАВШИХ

ОХУ, АНУ зэрэг зарим улс 2025 онд олон улсын хариуцлагын механизмд халдаж, үл ойшоов. Хамгийн хор хөнөөлтэй нь АНУ Олон улсын эрүүгийн шүүхийн үйл ажиллагаанд саад учруулах, Израил болон АНУ-ын иргэдийг хариуцлагаас хамгаалах зорилгоор Олон улсын эрүүгийн шүүхийн прокурор, шүүгчид, мөн Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэрийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч болон хэд хэдэн Палестины хүний эрхийн байгууллагуудын эсрэг хориг арга хэмжээ авсан. ОХУ-ын дотоодын шүүхүүд Олон улсын эрүүгийн шүүхийн ажилтнуудыг баривчлах шийдвэр гаргасан. Бусад улс орнууд эдгээр хувь хүмүүс, байгууллагууд болон Олон улсын эрүүгийн шүүхийг хамгаалах хүчин чармайлт гаргасангүй. Европын Холбоо гадаад улсын хууль тогтоомж ЕХ-ны компани, байгууллагуудад нутаг дэвсгэрээс гадуур үйлчлэхийг эсэргүүцэх өөрийн хамгаалалтын хуулийг ашигласангүй. Олон улсын эрүүгийн шүүхийн гишүүн Буркина Фасо, Мали, Нигер зэрэг улс Ромын дүрмээс гарахаар төлөвлөж байгаагаа мэдэгдсэн бол Унгар улс 2026 онд Ромын дүрмээс гарах албан ёсны мэдэгдлээ хүргүүлсэн. Унгар, Итали, Тажикстан зэрэг Олон улсын эрүүгийн шүүхийн гишүүн улс орнууд тус шүүхийн баривчлах тушаалыг хэрэгжүүлсэнгүй.

Гэсэн хэдий ч олон улсын механизмууд хариуцлага хүлээлгэх чухал чиг үүргээ үргэлжлүүлсээр байв. Олон улсын Эрүүгийн шүүхээс 2021 онд Афганистанд дахин засгийн эрхэнд гарснаас хойш охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эсрэг жендэрт суурилсан хавчлага, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэнтэй нь холбогдуулан Талибаны хоёр удирдагчийг баривчлах шийдвэр гаргасны зэрэгцээ дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт холбогдуулан Ливийн иргэдтэй холбоотой өмнө нь нууцалж байсан баривчлах захирамжуудыг ил болгосон. Филиппин улсын өмнөх ерөнхийлөгчийг "хар тамхины эсрэг дайн"-тай холбоотой аллагын хүрээнд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт холбогдуулан гаргасан баривчлах захирамжийг хэрэгжүүлсний дараа Олон улсын эрүүгийн шүүхэд шилжүүлэн өгсөн. Арванхоёрдугаар сард Олон улсын эрүүгийн шүүхийн Урьдчилсан шатны хуралдаанд прокурорын газраас Уганда дахь Лордын эсэргүүцлийн Армийг үүсгэн байгуулагч, удирдагч Жосеф Конид холбогдуулан гаргасан 39 зүйл анги бүхий яллах дүгнэлтийг баталгаажуулсан. Мөн тухайн сард Герман улс Ливи улсын нийслэл Триполи хотын Митига хорих газарт үйлдэгдсэн ноцтой зөрчилд холбогдуулан хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэрэгт буруутгагдсан Ливийн хүчирхэг зэвсэгт бүлэглэлийн ахлах гишүүн Халед Мохамед Али Эль Хишриг баривчлах шийдвэр гарсныг хэрэгжүүлж, Олон улсын эрүүгийн шүүхэд шилжүүлэн өгсөн. Олон

улсын эрүүгийн шүүх Суданы Дарфур бүс нутагт 2003–2004 онд болсон харгис халдлагуудын үеэр үйлдэгдсэн дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт холбогдуулан Жанжавид зэвсэгт бүлэглэлийн нэгэн удирдагчийг ялласан. Түүнчлэн ТАБНУ дахь хайбрид шүүх болох Тусгай Эрүүгийн Шүүхээс 2020 онд хэдэн арван хүнийг хөнөөж, хэдэн зуун хүнийг орон гэрээс нь дайжихад хүргэсэн хэрэгт холбогдуулан зэвсэгт бүлэглэлийн зургаан гишүүнийг дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутган ялласан.

Тайлангийн хугацаанд шинэ төрлийн механизмууд бий болсон. Европын Зөвлөл Украины эсрэг түрэмгийллийн гэмт хэргийн Тусгай шүүхийг ОХУ болон бусад улсын энэ хэрэгт хариуцлага хүлээвэл зохих засгийн газрын болон цэргийн өндөр албан тушаалтнуудыг мөрдөн шалгаж, хариуцлага хүлээлгэх зорилгоор байгуулсан. Олон улсын эрүүгийн шүүхээс ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин зэрэг зургаан албан тушаалтныг дайны болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт холбогдуулан баривчлах шийдвэр гаргасан. НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөл Афганистан улсад бие даасан мөрдөн шалгах механизм байгуулсан.

**Засгийн газрууд Олон улсын эрүүгийн шүүхийн ажилтнууд болон Олон улсын эрүүгийн шүүхтэй холбоотой ажилтнуудыг заналхийлэл, хориг арга хэмжээнээс хамгаалахын тулд хууль тогтоомжийг батлах, хэрэгжүүлэх зэргээр Олон улсын шүүхийг дэмжиж, хамгаалах шаардлагатай. Түүнчлэн засгийн газрууд Олон улсын эрүүгийн шүүхийн баривчлах шийдвэрийг хэрэгжүүлэхдээ холбогдох албан тушаалтнууд үйлдсэн гэмт хэрэгтээ шүүхээс халдашгүй байх эрх эдлэх талаарх үндэслэлийг хүлээн зөвшөөрөхгүй байхыг баталгаажуулж, бүрэн хэрэгжүүлэх ёстой.**

## **ШИЙТГЭХ БОЛОН ДАРАНГУЙЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭСЭРГҮҮЦЭЛ, ШҮҮМЖЛЭЛИЙГ ДАРАНГУЙЛАХ**

Дэлхий даяар төрийн албан тушаалтнууд болон бусад хүчирхэг оролцогчид иргэний нийгмийн дуу хоолойг нухчин дарж, хариуцлагаас мултрахын тулд олон төрлийн дарангуйллын аргыг ашигласан. Олон тооны улс 2025 онд улс төр, нийгэм-эдийн засгийн шаардлага бүхий эсэргүүцлийн жагсаал, цуглааныг дарангуйлахын тулд хууль бус хүч хэрэглэсэн. Танзани улсад сонгуулийн дараа явагдсан эсэргүүцлийн жагсаалыг тараах үеэр хэдэн зуун хүн нас барсан. Непал улсад авлига, нийгмийн цахим сүлжээг хориглосны эсрэг залуучуудын удирдсан жагсаалыг тараах үеэр жагсагчид болон цагдаагийн албан хаагчид нийлсэн 76 хүн нас барсан. Иран улсын нийслэл Тегран хотод эхэлж улмаар улс орон даяар хурдан хугацаанд тархсан эсэргүүцлийн жагсаалуудын үеэр аюулгүй байдлын хүчнийхэн хууль бусаар галт зэвсэг хэрэглэсний улмаас хүний амь нас хохирсон, гэмтсэн тохиолдлууд гарсан. Мөн Ангола, Камерун, Эквадор, Индонези, Кени, Мадагаскар, Пакистан, Перу, Турк зэрэг улсад хууль бус хүч хэрэглэсний улмаас жагсагчид нас барсан тохиолдол бүртгэгдсэн. Зарим улсад цагдаа нар хангалттай зохицуулалтгүй зэвсгийн төрлүүдийг ашигласан. Серб улсад холын зайн акустик төхөөрөмж ашигласан бол бусад олон улсад хортой нулимс асгаруулагч хий ашигласан.

Афганистан, Беларусь, Буркина Фасо, Хятад, Куба, Мали, Мьянмар, Никарагуа, Хойд Солонгос, Орос, Уганда, Венесуэл зэрэг олон улс оронд хүний эрх хамгаалагчид, идэвхтнүүд, сэтгүүлчдийг хүчээр алга болгох хүчирхийллийг айдас төрүүлэх хэрэгсэл болгон ашигласан. Иран, Саудын Араб зэрэг бусад улс цаазаар авах ялыг айдас төрүүлэх, аюулгүй, хүчирхэг төрийн дүр төрхийг харуулах хэрэгсэл болгон ашиглав.

2025 онд зарим улсын засгийн газар терроризмтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах хуулийг сөрөг хүчин, хүний эрх хамгаалагчид, идэвхтнүүдийг

шийтгэх зорилгоор ашигласан. Египет улсын эрх баригчид терроризмтой холбоотой гэмт хэрэгт олон мянган хүнийг ялласан бөгөөд тэдгээрийн ихэнх нь зөвхөн тайван замаар хүний эрхээ хэрэгжүүлснийхээ төлөө ийнхүү шийтгүүлсэн. Энэтхэг болон Хятадын засаг захиргааны бүсүүд болох Хонгконг, Макаоод эрх баригчид үндэсний аюулгүй байдал, терроризмын хуулийг өргөжүүлэн хэрэглэж хүний эрх хамгаалагчид, идэвхтнүүдийг саатуулан, цагдан хорьсон. Венесуэл улсад хамгийн багадаа 806 хүнийг дур зоргоор цагдан хорьсон бөгөөд тэдгээрийн ихэнхийг бодит эсвэл таамаглалд үндэслэн эсэргүүцэл, шүүмжлэлийг нухчин дарах Засгийн газрын бодлогын хүрээнд хүчээр сураггүй алга болгожээ. Тунис улсын эрх баригчид улс төрийн өрсөлдөгчдөө терроризмтой тэмцэх болон цахим гэмт хэрэгтэй холбоотой хууль зөрчсөн гэх үндэслэлээр улс төрийн зорилгоор олноор нь шүүж, 45 хүртэлх жил хорих ялаар шийтгэсэн. Их Британи улсын эрх баригчид тодорхой бус зохицуулалттай терроризмтой тэмцэх хуулиудыг үндэслэн Палестин Акшныг Израилын цэргийн ажиллагаанд Их Британийн оролцоог эсэргүүцдэг шууд үйлдлийн сүлжээ хэмээн үзэж албан ёсоор хориглосон бөгөөд зөвхөн тухайн хоригийг тайван замаар эсэргүүцсэнийх нь төлөө Их Британи даяар 2,000 гаруй хүнийг баривчилсан. Мөн байгаль орчны идэвхтнүүдийн нэгдэл болох “Газрын тосны олборлолтыг зогсоо” хөдөлгөөний 16 идэвхтнийг чулуужсан түлш олборлолтыг зогсоход чиглэсэн олон төрлийн иргэний үл захирагдахуйн үйл ажиллагаанд оролцсоных нь төлөө таван сараас таван жил хүртэл хорих ял оноосон. АНУ-д эрх баригчид Палестиныг дэмжиж байгаагаа илэрхийлсэн гадаад оюутнуудыг баривчилж, тус улсаас албадан гаргахаар онилж, бичиг баримтгүй цагаачдад чиглэсэн Цагаачлал, гаалийн хяналтын албаны хатуу арга хэмжээг эсэргүүцэн жагссан хүмүүсийг баривчилсан.

**Засгийн газрууд эсэргүүцэл, шүүмжлэл, түүний дотор тайван жагсаал, иргэний үл захирагдахуйг нухчин дарах, гэмт хэрэгт тооцохоо зогсоох шаардлагатай. Засгийн газрууд эсэргүүцлийн жагсаалын үеэр хүний эрхийг зөрчсөн бүх тохиолдолд хариуцлага хүлээлгэж, хохирогчдын зөрчигдсөн эрхийг үр дүнтэй сэргээх баталгааг хангах шаардлагатай.**

## **ХҮЧИРХИЙЛЛЭЭР ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛЛАГАА**

2025 онд олон улс орон хууль сахиулах үйл ажиллагаанд олон улсын хүний эрхийн эрх зүйг зөрчсөн. Зарим нь төрийн дэмжлэгтэйгээр хүний амь насыг хөнөөсөн. Есдүгээр сард АНУ-ын зэвсэгт хүчин Латин Америк, Карибын тэнгис болон Номхон далайн бүс нутагт завь, хөлөг онгоцуудыг бөмбөгдөж, хүний амь насыг үндэслэлгүйгээр хөнөөсөн бөгөөд тэдгээр хүмүүсийг хар тамхи зөөвөрлөсөн ‘нарко-террористууд’ байсан хэмээн буруутгасан. Аравдугаар сард Бразил улсын Рио-де-Жанейро хотод мөрдөгч болон цэргийн цагдаа нар ядуусын хороололд хар тамхины эсрэг ажиллагаа явуулсны улмаас 120 гаруй хүн амиа алдсан. Тэдний олонх нь ядуу амьдралтай хар арьст иргэд байсан бөгөөд хууль бусаар шүүхийн шийдвэргүйгээр цаазалсан олон тохиолдол бүртгэгдсэн. Хар тамхитай холбоотой гэмт хэрэгт оноох цаазаар авах ялын тоо нэмэгдэж буй нөхцөлд аюулгүй байдлыг хангах нэрийдлээр цаазаар авах ялыг хэрэглэхтэй холбоотой олон улсын хамгаалалтын баталгаа, хязгаарлалтыг үл тоомсорлосон.

Дэлхий даяар хууль сахиулах байгууллагууд эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах арга техникийг ашигласан. Зарим нь шууд хүрэлцэх цахилгаанаар цохих хэрэгслүүдийг, тухайлбал цахилгаан буу болон цахилгаан борооной гудамж талбай, улсын хил, цагаач болон дүрвэгсдийн саатуулах төв, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, цагдаагийн хэлтэс, хорих анги болон бусад саатуулах газруудад хэрэглэсэн. Уг чанараараа хүчирхийллийн зорилгоор ашиглагддаг эдгээр хэрэгслийг жагсагчид, оюутнууд, улс төрийн өрсөлдөгчид, охид, эмэгтэйчүүд (жирэмсэн эмэгтэйчүүдийг оролцуулан), хүүхдүүд, хүний эрх хамгаалагчид болон бусад хүний эсрэг хэрэглэсэн. Амьд үлдэгсэд нь түлэгдэж, бие нь мэдээ алдаж, зулбаж, шээсний

үйл ажиллагаа нь алдагдаж, нойргүйдэж, ядарч туйлдан, сэтгэл зүйн гүн дарамтад орсон. Улс орнууд болон компаниуд ийм төрлийн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, сурталчлах, худалдаалах үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн.

Түүнчлэн хууль сахиулах ажиллагаанд хууль ёсны үүрэгтэй байж болох цахилгаан гүйдлээр цохигч тусгай хэрэгслийг ихэнхдээ эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцахад ашиглах зэргээр өргөн хүрээнд хүчирхийллийн зорилгоор ашиглаж байгаа нь хууль сахиулах стандарт хэрэгсэлд хүний эрхэд суурилсан, хатуу чанга худалдааны хяналт хэрэгжүүлэх шаардлагатай болохыг илтгэж байна.

Гэхдээ ч 2025 онд НҮБ-ын Эрүүдэн шүүхээс ангид худалдааны тухай гэрээ бий болгохыг шахаж, шаардах нь нэмэгдсэн нь урамтай байлаа. Зургаадугаар сард НҮБ-ын эрүүдэн шүүхийн эсрэг дөрвөн механизм эсэргүүцлийн тайван жагсаал цуглааны үеэр цагдаагийн үйл ажиллагааг илүү хариуцлагатай, хяналттай байлгахыг уриалж, дээрх гэрээг боловсруулах саналыг дэмжсэн. Мөн Европын Зөвлөлийн Сайд нарын Хороо өөрийн 46 гишүүн улсыг эрүүдэн шүүхээс ангид худалдааны талаарх олон улсын заавал биелэх баримт бичиг боловсруулах үйл явцыг дэмжихийг уриалсан шийдвэр гаргасан. Долдугаар сард Европын Холбоо эрүүдэн шүүхийн эсрэг зохицуулалтынхаа хамрах хүрээг өргөжүүлж, хууль сахиулах хэрэгслийг дэлхий даяар эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцахад ашиглах эрсдэлтэй этгээдүүдэд шилжүүлэхээс сэргийлэх бүс нутгийн арга хэмжээг улам бэхжүүлсэн.

**Засгийн газрууд төрийн дэмжлэгтэйгээр үйлдэгдэж буй аллага, тэр дундаа аюулгүй байдлыг хангах нэрийдлээр хэрэгжүүлж буй үйлдлүүдийг нэн даруй зогсоох шаардлагатай. Түүнчлэн НҮБ-ын Эрүүдэн шүүхээс ангид худалдааны гэрээг хэлэлцэх үйл явцыг дэмжих замаар уг чанараараа хүчирхийллийн зорилгоор ашиглагддаг хууль сахиулах хэрэгслийг хориглох, хууль сахиулах стандарт тоног төхөөрөмжийн худалдаанд хүний эрхэд суурилсан хяналт тогтоох чиглэлд хүчин чармайлтаа эрчимжүүлэх шаардлагатай.**

## ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

### ДҮРВЭГСЭД, ЦАГААЧДЫН ЭРХИЙН ЗӨРЧИЛ

Дэлхийн улс орнуудын засгийн газрууд орогнол, цагаачлалын харилцаанд дарангуйллын үйл ажиллагааг хэрэгжүүлсээр байв. Зарим улс хууль бус арга хэмжээг зөвшөөрөх, эсхүл асуудлыг хууль батлах замаар шийдвэрлэх үйл явцаас зайлсхийхийн тулд ноцтой хор уршиг бүхий цагаачлалын бодлогыг нэвтрүүлсэн. 2025 онд АНУ болон Кипр, Финланд, Грек, Унгар, Итали, Польш зэрэг Европын улс орнууд, түүнчлэн бусад улсууд дүрвэгсэд, цагаачдыг албадан гаргах, бусад арга хэлбэрээр буцаах, хууль бусаар нэвтрэхийг таслан зогсоох зорилгоор олон улсын хүний эрхийн үүргээ зөрчсөн туйлын хатуу арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн. Талибанд хүчирхийлэл үргэлжилсээр байгааг үл харгалзан Иран улс 1.8 сая гаруй, Пакистан улс 990,000 гаруй афган иргэдийг албадан гаргах, буцаах арга хэмжээг явуулсан. 2024 оны арванхоёрдугаар сараас 2025 оны хоёрдугаар сарын хооронд Этиопын эрх баригчид 600 гаруй эритрей иргэнийг орогнол хүсэх нь эх орноосоо урвасанд тооцогддог Эритрей улс руу албадан буцаасан.

Засгийн газрууд цагаачлалын бодлого, орогнолын тогтолцоогоо ихэвчлэн төрийн бүрэн эрхт байдлыг хэрэгжүүлэх, үндэсний аюулгүй байдал болон эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах, нийтийн нөөцөд ирэх ачааллыг хязгаарлахад чиглэсэн хэрэгсэл хэмээн тайлбарладаг. Гэвч колоничлол, боолчлолын уламжлал нь дэлхий даяар арьс үндсээр гадуурхагдсан хүмүүсийн эсрэг шууд, шууд бус ялгаварлан гадуурхалтын тогтолцоо, хууль, бодлого, үйл ажиллагааны дур зургийг өнөөг хүртэл тодорхойлсоор байна. 2025 онд Эмнести Интернэшнл Канад, Доминиканы Бүгд Найрамдах Улс, Франц, Ливи, Саудын Араб, Тунис, АНУ, түүнчлэн Шенгений

бүсийн Европын улс орнуудын орогнол, цагаачлалын бодлогод нүүрлэсэн арьс үндсээр ялгаварлан гадуурхах тогтолцооны шинжтэй практикийг хатуу шүүмжлэсэн. Зарим тохиолдолд засгийн газрууд арьс үндэс, үндэс угсаа, гарал үүсэл, үндэстний шинжээр ялгаварлан гадуурхсан хилийн шалганы дэглэмийг хэрэгжүүлэхэд дижитал технологийг ашигласан. Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт нь зарим талаар уг асуудлыг улам хүндрүүлсэн. Тухайлбал, Доминиканы Бүгд Найрамдах Улсад жирэмсэн болон хөхүүл Гаитийн эмэгтэйчүүдийг эмнэлгээс нь шууд гаргаж албадан нутаг буцаасан.

Дэлхийн улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас нутаг орноосоо дүрвэн олон улсын хил дамнан шилжин суурьшиж байгаа хүмүүсийг хамгаалах чиглэлээр хангалттай арга хэмжээ авч чадсангүй. Уур амьсгалын өөрчлөлтийн ноцтой нөлөөлөлд өртсөн бүс нутгаас ирж байгаа иргэдэд аюулгүй цагаачлах боломж олгох тусгай визийг бараг ямар ч улс санал болгосонгүй. Харин үүний эсрэгээр ялгаварлан гадуурхаж, хязгаарласан одоогийн журамд үндэслэн асуудлыг шийдвэрлэсэн. Арьс үндсээр ялгаварлагдсан болон ядуу иргэд, эмэгтэйчүүд болон бусад эмзэг бүлгүүд үүнд хамгийн ихээр өртсөн. Ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон эрүүл мэндийн асуудалтай хүмүүс визийн шаардлагыг хангахгүйн улмаас ихэвчлэн орхигддог бөгөөд үүнийг Тувалу болон Кирибати арлуудаас Аотеароа Шинэ Зеланд руу шилжин суурьшиж буй хүмүүсийн жишээ харуулж байна.

**Засгийн газрууд ялгаварлан гадуурхалт, мөлжлөгийн шинжтэй визийн тогтолцоо, оршин суух зөвшөөрлийн тогтолцоог халж шинэчлэх, дижитал технологийг ялгаварлан гадуурхсан хилийн дэглэмийг сахиулахад ашиглахаас сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас шилжин суурьшсан хүмүүсийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.**

## **АРЬС ҮНДСЭЭР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ**

Бүс нутаг даяар улс орнууд орогнол, цагаачлалын хүрээнд дарангуйлагч арга барилыг хэрэгжүүлэх, эсэргүүцэл шүүмжлэлийг нухчин дарах, хууль сахиулах үйл ажиллагаанд арьс үндсээр ялгаварлан гадуурхсан, үзэн ядалтыг өдөөсөн үг хэллэгийг ашигласан. Улс орнуудад үзэн ядалтад суурилсан гэмт хэргийн тоо өссөн. Арьс үндсээр ялгаварлан гадуурхаж байгаа суурь шалтгаан болон колоничлол, боолчлолын уламжлалаас үүдсэн шударга бус байдлыг шийдвэрлэж, үр дагаврыг арилгах чиглэлээр нөлөөлөлд өртсөн нийгмийн бүлгүүд кампанит ажил өрнүүлсээр байна. 2025 онд Африкийн Холбооноос “Нөхөн төлбөрийн жил” болгон зарласантай холбогдуулан Вакати Вэту наадам зохион байгуулж, уран бүтээлчид, хөгжимчид, бодлого боловсруулагчид, хандивлагч хүмүүнлэгийн байгууллагын төлөөлөгчид, идэвхтнүүд, соёлын боловсролын ажилтнууд зэрэг олон зуун оролцогчдын хүрээнд боолын худалдаа, колоничлолын зүй бус уламжлал, хохирлыг барагдуулах шударга ёсны талаарх яриа хэлэлцээрт ахиц гаргасан. Түүнчлэн 2025 онд Франц улсаас Гаити улсад тулгасан колоничлогч улсад боолын хөдөлмөрөөс алдагдсан ашгийг нөхөн төлүүлэхийг шаардаж ногдуулсан “тусгаар тогтнолын өр”-ийн 200 жилийн ой тохиосонтой холбогдуулан Гаити болон түүний диаспорагийн идэвхтнүүд, байгууллагууд Франц улсыг нөхөн төлбөр олгож, мөн тухайн улсад холбогдох колоничлолын түүхийг хүлээн зөвшөөрч, хариуцлага хүлээхийг уриалсан.

2025 онд Боливи, Канад, Эквадор зэрэг улсын засгийн газрууд уугуул хүмүүсийн нутаг дэвсгэрт олборлох салбарын төслүүдийг чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэйгээр зөвшөөрөл авах талаарх олон улсын хэм хэмжээнд нийцсэн зөвшилцөх ажиллагаа явуулахгүйгээр өргөжүүлсэн. Соёл, амьжиргааны хувьд экосистемээс ихээхэн хамааралтай уугуул хүмүүс газар нутгийг нь булаан эзэмшиж, колоничилж, устгалт явуулсны улмаас зөрчигдсөн эрхийг сэргээлгэх зорилгоор хууль зүй, улс төрийн аргаар тэмцсээр байна. Авб Гуарани Паранаэнсэ уугуул хүмүүс 40 гаруй жил тэмцсэний эцэст газар нутгаа алдаж, усанд автуулсны улмаас учирсан хохирлын

талаарх зарим гомдлоо шийдвэрлүүлж чадсан нь 2025 онд онцлох шүүхийн маргааны нэг юм. Шүүхийн шийдвэрээр дээрх хохиролд хүргэсэн усан цахилгаан станцын далан барьж, ажиллуулах зорилгоор Бразил болон Парагвай улсын засгийн газраас үүсгэн байгуулсан компанийг хохирогч иргэдэд 3,000 гектар газар худалдан авах санхүүжилтийг шийдвэрлэхийг үүрэг болгожээ.

**Колоничлол, боолын худалдаа, боолчлол зэрэг түүхэн шударга бус үйлдэлд оролцсон эсвэл ашиг хүртсэн улс орнуудын засгийн газрууд нөхөн төлбөрт суурилсан шударга ёсны зохих арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр арга хэмжээ нь зөвхөн өнгөрсөн шударга бус явдлын хохирлыг барагдуулахаас гадна өнөөг хүртэл үргэлжилж буй арьс үндсээр ялгаварлан гадуурхах, тэгш бус байдлын бүтэц, тогтолцоог үгүй хийхэд чиглэх учиртай.**

## **ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ, ХҮЧИРХИЙЛЭЛ**

Дэлхий даяар охид, эмэгтэйчүүд жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн бөгөөд хамгаалалт, шүүхэд хандах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломж нь цагаачлалын эрх зүйн байдал, нийгмийн анги давхарга, хөдөлмөр эрхлэлт, шашин шүтлэгт суурилсан ялгаварлан гадуурхалтын улмаас улам хүндрэв. Афганистан улсад Талибанууд эмэгтэйчүүдийн боловсрол, хөдөлмөр эрхлэх, чөлөөтэй зорчих эрхийг хориглосон тогтоол гаргаж, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн гэрлэлтийг улам гүнзгийрүүлсэн. Непал улсад далит эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийллийн хэргийг мөрдөн шалгаагүй. Сирид, зэвсэгт этгээдүүд охид эмэгтэйчүүдийг хулгайлж, хүчээр авч авсан талаарх Алавит гэр бүлүүдийн мэдээллийг үл хэрэгсэв. Латин Америкийн улс орнуудад охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, тэр дундаа эмэгтэйчүүдийг хүйсийн шинжид үндэслэн хөнөөх гэмт хэрэг түгээмэл байсаар байв. Аргентин улсад цаг тутамд нэг эмэгтэй бусдын гарт амь насаа алдаж байгааг үл хайхран засгийн газар жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хариу арга хэмжээ авах 13 үндсэн хөтөлбөрийг хүчингүй болгов. Гүрж улсын зарим өндөр албан тушаалтнуудын эмэгтэйчүүдийн эсрэг үзэн ядалт, сексист үг хэллэг нь эмэгтэй жагсагчдын эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэх, нүцгэлж шалгах зэрэг жендэрт суурилсан хүчирхийлэлд хүргэсэн. Болив, Буркина Фасо улсын шинээр баталсан хуулиар эрэгтэй, эмэгтэй хүүхдийн гэрлэлтийг хориглосон нь эерэг алхам юм.

2025 онд өмнөх жилүүдийн адил хэд хэдэн улсад үр хөндүүлэх эрхийг өргөжүүлэх чиглэлд зарим дэвшил гарсан. Дани, Фарерийн арлууд, Норвеги улсын хууль тогтоох байгууллагаас үр хөндүүлэх эрхийг хуулиар хүлээн зөвшөөрсөн бол Люксембургт үр хөндүүлэх эрхийг үндсэн хуулиар баталгаажуулсан. Малави улсын дээд шүүхээс бэлгийн хүчирхийллийн хохирогч охид, эмэгтэйчүүдийн үр хөндүүлэх эрхийг баталгаажуулсан. Харин Доминиканы Бүгд Найрамдах Улсын шинэ хуулиар үр хөндүүлэхийг бүрэн хориглосон. Дэлхийн олон улсад үр хөндүүлэх, эсхүл өр хөндөлтийн дараах эмчилгээ авах боломжийг хязгаарласан саад бэрхшээл байсан хэвээр байв.

ЛГБТИ хүмүүс, ялангуяа трансжендэр хүмүүсийн эрхийн эсрэг халдлага дэлхий даяар эрчимжсэн бөгөөд жендэрийн эсрэг янз бүрийн бүлэглэлүүд чухал нөлөө үзүүлсэн. Буркина Фасо улсын шинээр баталсан хуулиар ижил хүйстний харилцан зөвшилцсөн бэлгийн харилцааг гэмт хэрэгт тооцсон. Унгар, Словак улсын үндэсний парламент Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж зөвхөн хоёр хүйсийг (эрэгтэй, эмэгтэй) хүлээн зөвшөөрч, ижил хүйстэн хосуудын эсрэг ялгаварлан гадуурхалтыг баталгаажуулсан. Канад, Парагвай, Перу, Пуэрто Рико, АНУ-д трансжендэр хүмүүсийн эрхийг хязгаарласан хууль, бодлого хэрэгжүүлсэн. Хятад улсад төрөөс баталсан хяналт хэрэгжүүлэх зааварт нийцүүлэн олон төрлийн цахим платформ, вэбсайт, хэлэлцүүлгийн порталууд ЛГБТИ хүмүүс, эмэгтэйчүүдийн эрхийн талаарх хувийн болон бүлгийн хэлэлцүүлгийг хаасан. Ойрх Дорнод болон Хойд Африкийн олон улс оронд хүмүүсийг бэлгийн чиг баримжаа, хүйсийн шинжид үндэслэн

баривчилж, ялласан бөгөөд ижил хүйстний харилцан зөвшилцсөн бэлгийн харилцаанд хатуу ял шийтгэл оногдуулсан. Харин Япон, Мексик улсын шүүхээс трансгендэр хүмүүсийг эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрсөн.

**Засгийн газрууд хүйс болон жендэрт суурилсан бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг зогсоож, бүхий л охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эрх, түүний дотор бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг бүрэн хүлээн зөвшөөрч, баталгаажуулах хууль, бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн бүх хохирогч, амьд үлдсэн хүмүүст хамгаалалт, шударга ёс, зөрчигдсэн эрхийг сэргээх механизмд цаг тухайд нь хандах баталгааг хангах үүрэгтэй.**

## **ЭДИЙН ЗАСАГ, УУР АМЬСГАЛЫН ШУДАРГА БУС БАЙДАЛ**

### **УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ХОЙРГО ХАНДСАН НЬ**

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн ган гачиг, үер, хар салхи, хэт халалт, ой хээрийн түймэр зэрэг гамшгийн улмаас үүссэн хоол хүнсний аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулж, нутаг орноосоо дурвэх, амьдрах орчин, амьдралын эх үүсвэрийг алдах зэрэг үзэгдэл бүх улс орнуудад огцом нэмэгдсэн. Урьдын адил уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн бага хувь нэмэр оруулсан бүс нутгийн иргэд хор уршгийг хамгийн ихээр амслаа.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс 2025 оны арваннэгдүгээр сард мэдээлснээр улс орнууд одоо мөрдөж буй бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн тохиолдолд дэлхийн дулаарлын төвшин энэ зууны төгсгөл гэхэд аж үйлдвэржилтийн өмнөх төвшнөөс ойролцоогоор 3°C хүртэл нэмэгдэнэ. Гэхдээ уур амьсгалын өөрчлөлтийг тогтоон барих нь улам бүр боломжгүй болж байна. Сүүлийн жилүүдэд засгийн газрууд чулуужсан түлшийг үе шаттай халах, уур амьсгалын өөрчлөлтийн суурь шалтгааныг шийдвэрлэх чиглэлд хүчин чармайлт гаргасангүй. 2025 онд Бразил, Канад зэрэг хэд хэдэн улсын засгийн газар чулуужсан түлш үйлдвэрлэл, экспортын хэмжээгээ огцом нэмэгдүүлэх арга хэмжээ авсан бөгөөд ихэнхдээ татвар төлөгчдийн санхүүжилтээр дээрх үйл ажиллагааг дэмжсэн. АНУ-аас Европын Холбооны гишүүн улс орнуудыг чулуужсан түлшний импорт, хэрэглээг дэмжих шахалт үзүүлсэн. Парисын хэлэлцээрт оролцогч талуудын ердөө гуравны нэг нь 2025 онд багтаан Уур амьсгалын эсрэг үйл ажиллгааны төлөвлөгөө (Үндэсний тодорхойлсон хувь нэмэр)-г ирүүлсэн.

Чулуужсан түлш нь уур амьсгалын өөрчлөлтөд шууд нөлөөлөхийн зэрэгцээ дэлхийн 170 улсад үйл ажиллагаа явуулж буй 18,000 гаруй чулуужсан түлшний дэд бүтцийн байгууламжийн 5 км-ийн радиуст оршин суугаа дор хаяж 2 тэрбум хүний эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулж байна. Эдгээрийн 520 сая орчим нь хүүхэд байна хэмээн тооцоолжээ. Түүнчлэн хамгийн багадаа 463 сая хүн эдгээр дэд бүтцийн байгууламжийн 1 км орчимд амьдарч, эрүүл мэнд болон хүрээлэн буй орчны өндөр эрсдэлд өртөж байна.

2025 оны арван нэгдүгээр сард Бразилд болсон COP30 уур амьсгалын чуулганд оролцогч удирдагчид COP28-д зөвшилцсөн “чулуужсан түлшнээс үе шаттай татгалзах” үүрэг амлалтыг баталгаажуулах, нэмэлт алхам хийх чиглэлд ахиц гаргаж чадсангүй. Түүнчлэн бага орлоготой улс орнуудад шаардлагатай дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх санхүүжилтийн үүргээ биелүүлсэнгүй. Уур амьсгалын санхүүжилтийг бүрдүүлэх нь өндөр орлоготой орнуудын үүрэг бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн болон ирээдүйн ноцтой сөрөг нөлөөлөлд өөрсдийн хувь нэмэр, оролцооноос үл хамааран өртөж байгаа бага орлоготой орнуудад дасан

зохицоход нь дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ. Засгийн газрууд шударга татварын бодлого хэрэгжүүлэх, чулуужсан түлшинд олгож буй их хэмжээний татаасыг дахин чиглүүлэх замаар нэг жилд зарцуулах Уур амьсгалын санхүүжилт болох 300 тэрбум ам.долларыг бүрдүүлэх боломжтой.

Ийм нөхцөлд Олон Улсын Шүүх болон Америк хоорондын Хүний Эрхийн Шүүх гэсэн олон улсын хоёр шүүхээс боловсруулсан хүн төрөлхтөн болон экосистемийг уур амьсгалын хямралаас хамгаалах үүрэг, түүний дотор чулуужсан түлшнээс үе шаттай татгалзах үүргийг баталгаажуулсан зөвлөмж (advisory opinion) чухал ач холбогдолтой. Мөн COP30-ийн үеэр Колумби, Нидерланд улсын засгийн газрууд 2026 оны дөрөвдүгээр сард Чулуужсан түлшнээс шударгаар шилжих анхны олон улсын чуулга уулзалтыг хамтран зохион байгуулах болсон тухайгаа мэдэгдсэн.

**Засгийн газрууд чулуужсан түлшний хэрэглээг үе шаттай зогсоох шуурхай, шударга бөгөөд санхүүжилтийн тогтолцоог бий болгож, чулуужсан түлшний олборлолт, хэрэглээг үл дэлгэрүүлэх гэрээг дэмжих, Колумби, Нидерландын засгийн газруудын удирдсан олон талт хүчин чармайлтад нэгдэх зэргээр шударга шилжилт хийх хүчин чармайлтыг нэмэгдүүлэх шаардлагатай.**

## **ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ**

Удаан хугацаанд үргэлжилсэн эдийн засгийн хямрал, дэлхий дахины мөргөлдөөн болон уур амьсгалын хямралтай зэрэгцэн эдийн засаг, нийгмийн эрхэд ноцтой нөлөөлсөн. Олон улсын валютын сан болон Дэлхийн банканд төвлөрсөн, зорилгодоо нийцэхээ больсон, шударга бус дэлхийн эдийн засгийн засаглалын тогтолцоо болон өндөр орлоготой улс орнуудын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах тусламжийн санхүүжилтийг их хэмжээгээр танаж, зогсоосон нь нөхцөл байдлыг улам хүндрүүлсэн.

Инфляц нь өрийн хүүгийн төлбөрийн өртгийг улам бүр нэмэгдүүлснээр бага, дунд орлоготой олон тооны улс тогтворгүй өрийн түвшинд хүрч, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал зэрэг эдийн засаг, нийгмийн эрхийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийх боломжгүй болсон. Шударга бус татварын тогтолцоо, мөн корпорациуд болон чинээлэг хувь хүмүүсийн татвараас зайлсхийх, зугтах боломжийг хязгаарлаж чадаагүй нь эдийн засаг, нийгмийн эрхийг хангахад шаардлагатай төсвийн орлогыг бүрдүүлэх боломжийг улам хязгаарласан.

АНУ олон улсын хөгжлийн тусламжаа эмх замбараагүй, гэнэтийн байдлаар зогсоосон нь бага орлоготой улс орнуудын эрүүл мэндийн хөтөлбөрүүд тасалдах, хаагдах, хүний амь насыг аврах эм, эмчилгээний хүртээмж тасалдахад хүргэж, эмзэг бүлгүүдэд ноцтой сөрөг нөлөө үзүүлсэн. Энэхүү таналт нь Европын улс орнууд зэрэг өндөр орлоготой улс орнуудын олон улсын тусламжийг бууруулах өрсөн хүрээний хандлагын илрэл бөгөөд хэрэгцээтэй байгаа санхүүжилт болон бодит санхүүжилтийн хооронд нэгэнт бий болсон 25 орчим тэрбум ам.долларын зөрүүг улам нэмэгдүүлсэн. Олон Улсын Аврах Хорооны 2025 оны тавдугаар сард гаргасан дүн шинжилгээгээр яаралтай хүмүүнлэгийн тусламж шаардлагатай, ялангуяа зэвсэгт мөргөлдөөний бүс нутагт амьдарч буй ойролцоогоор 300 сая хүн энэ санхүүжилтийн дутагдлын хор хөнөөлийг хамгийн ихээр амсаж байна. Гаити, Өмнөд Судан, Судан, Йемен зэрэг улсын хүн амын бараг тал хувь нь ноцтой өлсгөлөнд нэрвэгдэж, олон сая хүн хүнс тэжээлийн дутагдалд орсон.

Эдгээр нь 5 хүрэхгүй жилийн дараа дуусгавар болох Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилт хангалтгүй байгаатай давхцаж байна. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2025 оны долоодугаар сард гаргасан тайланд дурдсанаар Тогтвортой хөгжлийн зорилтуудын ердөө гуравны нэг орчим (35%) нь төлөвлөгөөний дагуу буюу дунд зэрэг ахицтай хэрэгжиж байгаа бол бараг тал хувь (48%) нь зогсонги байдалд, 31% нь багахан ахиц гарсан бол 17% нь огт ахицгүй

байна. Хамгийн ноцтой нь зорилтуудын 18% нь ухарч, 2015 оны суурь түвшнээс буурчээ.

НҮБ-ын заавал мөрдөх татварын конвенцын талаар үргэлжилж буй хэлэлцээ нь дэлхийн татварын тогтолцоонд оршиж буй тэгш бус байдлыг засах боломжийг бүрдүүлж, татварын зүй бус ашиглалт, зөрчлийг таслан зогсоох, бохирдуулагчдад татвар ногдуулах, бүх хүний эрхийг санхүүжүүлэхэд шаардлагатай орлогыг бүрдүүлэх зарчмууд дээр тохиролцоход чиглэж байна. 2025 онд уг конвенцын хүрээг тодорхойлох чиглэлд мэдэгдэхүйц ахиц гарсан бөгөөд эцсийн гэрээ нь улс орнуудын одоогийн хүний эрхийн үүрэгтэй нийцсэн байх шаардлагыг багтаасан. Үүнтэй адил өрийн асуудлаарх ижил төрлийн үйл явц, механизм яаралтай шаардлагатай байна.

**Засгийн газрууд боломжтой тохиолдолд үндэсний нийт орлогын хамгийн багадаа 0.7 хувийг олон улсын тусламжид ялгаварлан гадуурхалгүйгээр зориулах үүрэг амлалт өгөх; өрийн хямралыг бүх улс орон, ялангуяа өрийн дарамтад орсон болон орох эрсдэлтэй орнуудад цаг тухайд нь хөнгөлөлт үзүүлэх замаар шийдвэрлэх; мөн Олон улсын татварын хамтын ажиллагааны талаарх НҮБ-ын конвенцыг дэмжих шаардлагатай.**

## КОРПОРАЦУУДЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ

Корпорацын оролцогчид дэлхийн хямралаас ашиг олсоор байна. Эдгээрт Газа, Судан, Мьянмар дахь зэвсэгт мөргөлдөөн, дэлхийн уур амьсгалын хямрал, биологийн олон янз байдлын алдагдал, мөн компаниудын үйл ажиллагааны нөлөөллөөс үүдсэн ажилтнууд, орон нутгийн иргэдийн эрхийн зөрчил зэрэг олон тохиолдол багтана. Гэвч улс орнууд корпорацуудын хүний эрхийн зөрчлөөс хохирогчдыг хамгаалж чадсангүй. АНУ-д зохицуулалтыг бууруулж, чухал агентлагуудыг сулруулсан.

АНУ-ын чулуужсан түлшний салбарыг өргөжүүлэхэд чиглэсэн дэмжлэг, олон талт хамтын ажиллагааг үл ойшоох, дэлхийн тэргүүлэх удирдагчдын дайснагасан үг хэллэг, мөн Хятад улстай хийх эдийн засгийн өрсөлдөөн нь эрчим хүчний шинэ эх үүсвэрт шилжих, цэргийн олон төрлийн хэрэглээнд шаардлагатай эрдэс баялгийн аюулгүй байдлын өрсөлдөөнийг нэмэгдүүлсэн. Энэхүү өрсөлдөөн нь байгалийн баялгийн эрчимтэй олборлолтыг нэмэгдүүлж, компаниуд ашиг орлогоо дээд хэмжээнд хүргэхийн тулд хүний эрхийг үл тоомсорлоход хүргэсэн. Үүний уршгаар албадан нүүлгэн шилжүүлэлт, хөдөлмөрлөх эрхийн зөрчил, ус, хөрс, агаарын бохирдол, хүн амын эрүүл мэнд, хөдөө аж ахуйд учирсан хохирол нэмэгдсэн.

Европын холбоо Корпорацын Тогтвортой Байдлын Магадлан Шинжилгээний Удирдамжийг баталсан нь корпорацууд хүний эрх, байгаль орчны нөлөөлөл, уур амьсгалын талаарх шинэ дүрэм, журмыг хүндэтгэх шаардлагыг тодорхойлсон чухал зохицуулалт бөгөөд дэлхийн бусад олон улс оронд үйл ажиллагаа явуулдаг корпорацууд ЕХ-тай худалдаа хийхийн тулд энэхүү дүрмийг дагаж мөрдөх шаардлагатай. Энэхүү зохицуулалт нь олон нийтийн дэмжлэгийг авсан. Эмнести Интернэшнл болон Глобал Витнесс байгууллагын 2025 онд явуулсан судалгаагаар судалгаанд оролцсон Европын 10 улсын 10,000 гаруй оролцогчийн дөрөвний гурав нь энэхүү удирдамжийг дэмжсэн. Энэхүү удирдамж нь Индонези, БНСУ, Тайланд зэрэг улсад ижил төстэй журам батлах санаачилгыг идэвхжүүлсэн. Гэвч олон улсын корпорацууд, АНУ зэрэг бусад улсын шахалтаас болж Европын парламент 2025 оны 11 дүгээр сард удирдамжийн хүрээг ихээхэн хязгаарлахаар шийдвэрлэсэн.

Түүнчлэн иргэдийн оролцооны эсрэг стратегийн шүүхийн маргаан эрчимжсэн нь иргэний нийгмийн байгууллагууд хүчирхэг компаниудын эсрэг байгаль орчны доройтол, бусад зөрчилтэй тэмцэх хүчин чармайлтад сөргөөр нөлөөлсөн. Тухайлбал, нэгэн шүүхийн маргаанд АНУ-ын шүүх Грийнпийс олон улсын төрийн бус байгууллагаас 660 сая ам.долларын төлбөр гаргуулж чулуужсан түлшний үйлдвэрлэл

эрхлэгч Энержи Трансфер компанид олгохоор шийдвэрлэсэн нь уг байгууллага цаашид оршин байх эсэхэд ноцтой аюул учруулсан. Шүүхээс Грийнпийс иргэний нийгмийн байгууллагад Баруун Дакотагаас Иллиноис хүртэлх нефть дамжуулах Дакота Аксесс Хоолойн эсрэг эсэргүүцэл үзүүлсэн, нэхэмжлэгч компанийн нэр төр гутаасан, эзэмшлийн газарт зөвшөөрөлгүй нэвтэрсэн, саад учруулсан гэх зэрэг үндэслэлээр хариуцлага хүлээлгэжээ. Мөн тус компани нь Грийнпийс олон улсын төрийн бус байгууллагыг Нидерланд улсын шүүхэд хариуцагчаар татаж үйл ажиллагаа явуулахад нь саад хийхээр оролдсон. Харин Европын улс орнуудын дотоодын хууль тогтоомж болон ЕХ-ны эрх зүйн зохицуулалтын аль аль нь олон нийтийн оролцооны эсрэг шүүхийн маргааныг корпорацууд ашиглахаас хамгаалсан байдаг.

**Засгийн газрууд компаниуд хүний эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх хатуу шинэ зохицуулалтыг бий болгож, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэж, хохирогчид зөригдсэн эрхээ сэргээлгэх үр дүнтэй механизмын хүртээмжийг хангах шаардлагатай.**

## **ТЕХНОЛОГИ БА ХҮНИЙ ЭРХЭД УЧРУУЛАХ ХОР УРШИГ**

### **ХУУЛЬ БУС ТАНДАЛТ БОЛОН ЦАХИМ ДАРАМТ**

Засгийн газрууд технологи ашиглан дарангуйллыг тогтоож, хүчирхэгжүүлсээр байв. 2025 онд хийсэн дүн шинжилгээгээр цахим тандалт, цензурын хэрэгслийг хэрхэн ашиглаж байгааг ил тод болгосон. Хятадын засгийн газар тус улсын иргэдийн интернэтэд нэвтрэх мэдээллийг хянах, шүүлт хийх зорилгоор ашигладаг Хятадын "Great Firewall" системийн худалдааны зориулалттай хувилбарыг Пакистаны засгийн газарт худалдсан болохыг илрүүлсэн бол АНУ-ын засгийн газар эсэргүүцлийн жагсаалд оролцогч оюутнууд, цагаачдын эсрэг тандалтын хэрэгсэл ашигласан нь тогтоогдсон. Афганистан, Пакистан, Танзани, Өмнөд Судан зэрэг улсын эрх баригчид ихэвчлэн жагсаал цуглааны үеэр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах зорилгоор интернэт холболтыг тасалдуулсан. Кени улсын эрх баригчид залуучуудын удирдсан эсэргүүцлийн жагсаалыг нухчин дарах зорилгоор цахим орчинд айлган сүрдүүлэх, доромжлох, үзэн ядалт өдөөх, хууль бусаар тандах зэрэг технологид суурилсан дарамт шахалтыг системтэйгээр, зохион байгуулалттайгаар хэрэгжүүлсэн.

Корпорацийн оролцогчид эдгээр үйл ажиллагааг дэмжсэн. Intellexa, NSO, Paragon зэрэг компаниудын өндөр халдлагын тагнах программыг ашигласан халдлагын нотолгоо нэмэгдсээр байгаа нь дэвшилтэт тагнах программын зах зээлийн зохицуулалтгүй байдал нь хүний эрхэд учрах аюул хэвээр байгааг харуулж байна.

**Засгийн газрууд нь өндөр халдлагын тагнах программ хангамжийг ашиглах, шилжүүлэхийг нэн даруй хориглож, хүний эрхийн зөрчил, хүчирхийллээс хамгаалах тогтолцоо бүрдэх хүртэл бүх төрлийн тагнах программ хангамжийг ашиглах, шилжүүлэхийг түдгэлзүүлэх шаардлагатай.**

### **ХИЙМЭЛ ОЮУН БА ХҮНИЙ ЭРХЭД УЧРУУЛАХ ХОР УРШИГ**

Олон нийт хялбар, хүртээмжтэй байдлаар ашиглах боломжтой үүсгэгч хиймэл оюун асар хурдтайгаар, хяналтгүйгээр хөгжиж байна. 2025 онд Google, Meta, Microsoft зэрэг технологийн томоохон компаниуд, мөн Anthropic болон OpenAI зэрэг хиймэл оюуны гол тоглогчид олон шинэ загваруудыг танилцуулсан. Хиймэл оюуны салбарын болон хөрөнгө оруулагчдын зорилгыг хангахад шаардлагатай өргөн хүрээний биет дэд бүтэц, тухайлбал дата төвүүдийг барих үйл явц нь үйлдвэрлэлийн чухал ашигт малтмал зэрэг байгалийн нөөцийн олборлолт, хөргөлтөд шаардагдах ус, эрчим хүчний ашиглалтыг нэмэгдүүлсэн. Дата төвүүдийн орчмын байгаль орчны доройтол,

хөдөлмөрлөх эрхийн зөрчил зэрэг хүний эрхийн сөрөг нөлөөллүүд гарсаар байна. Бразил, Ирланд, Мексик, АНУ-д дата төвийн байгууламжийг өргөжүүлэхийг эсэргүүцсэн орон нутгийн иргэдийн активизм эрчимжсэн. Түүнчлэн АНУ-ын Цахиурын хөндий дэх компаний төв оффисуудаас эхлээд Африк болон бусад бүс нутаг дахь аутсорсингийн контентын хяналт, өгөгдөл шошголот зэрэг туслалх үйлдвэрлэлийн төвүүд хүртэлх технологийн салбарын ажилтнууд аюулгүй хөдөлмөрийн нөхцөлийг хангах кампанит ажлуудыг зохион байгуулах нь нэмэгдсэн.

Хиймэл оюун ухааны зохицуулалт хангалтгүй хэвээр байна. 2025 онд баталсан засаглалын шинэ баримт бичгүүд, тухайлбал Энэтхэгийн хиймэл оюун ухааны засаглалын удирдамж нь заавал биелэгдэх шинжгүй төдийгүй хэт ерөнхий байв. Европын Холбоо корпорацийн хариуцлага, технологитой холбоотой зохицуулалтаа хялбарчлах алхам хийсэн бөгөөд үүнийгээ “хүнд суртлыг бууруулах”, “өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх” зорилготой хэмээн тайлбарлаж байв. Гэвч эдгээр алхам нь Европын холбооны нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа хиймэл оюун ухааны системийн аюулгүй, ил тод, ялгаварлалгүй, суурь эрхийг хүндэтгэх нөхцөлийг хангахад чиглэсэн Европын Холбооны хиймэл оюун ухааны хууль гэх зэрэг одоо мөрдөж буй хууль тогтоомжийн хамгаалалтын механизмуудыг сулруулж, ЕХ-ны бусад зохицуулалтын хамгаалалтад сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Засгийн газрууд дижитал нийтийн дэд бүтцийн төслүүдэд хөрөнгө оруулалтаа үргэлжлүүлсээр байна. 2025 онд Их Британи шинэ дижитал үнэмлэхийн системийг зарласан бол Европын Холбоо Европын Дижитал Иргэний Үнэмлэхийн түрийвч хөгжүүлж байна. Энэ нь Энэтхэгийн Aadhaar зэрэг томоохон дижитал таних системүүдийг нэвтрүүлж ирсэн олон жилийн чиг хандлагын үргэлжлэл юм. Эдгээр системүүд нь нийгмийн хамгааллын салбарт хиймэл оюуныг ашиглах үндсийг бүрдүүлж, тэгш бус байдалд хүргэсэн. Мөн цагдаагийн үйл ажиллагаа, цагаачлал, цэргийн үйл ажиллагааны салбарт хиймэл оюуны системийг нэвтрүүлэх нь хүний эрхийн зөрчил, ялангуяа арьс үндсээр ялгаварлагдсан бүлгүүдийн эрсдэлийг улам дамжруулж байна.

**Засгийн газрууд хиймэл оюуны системийг зохицуулахдаа заавал биелүүлэх, хүний эрхэд суурилсан хууль тогтоомжийг баталж, олон улсын хүний эрхийн эрх зүйд нийцэхгүй хиймэл оюуны системийг хөгжүүлэх, ашиглахыг хориглох шаардлагатай.**

## **СОШИАЛ МЕДИА БА ХҮНИЙ ЭРХЭД ҮЧРУУЛАХ ХОР УРШИГ**

Сошиал медиагаас үүдэлтэй хор уршиг болон бусад нийгмийн асуудлуудын харилцан хамаарлын талаарх олон нийтийн ойлголт нэмэгдсээр байна. Эмнести Интернэшнл сошиал медиа платформ Х-ийн зөвлөмжийн системд дүн шинжилгээ хийх зэргээр энэхүү хөгжилд хувь нэмэр оруулсан бөгөөд Английн Саутпорт хотод гарсан халдлагын улмаас гурван бага насны хүүхэд амь насаа алдсаны дараа 2024 онд Их Британид өрнөсөн арьс үндсээр ялгаварласан үймээн самууныг жишээ болгон авч үзсэн. Халдлагыг үйлдсэн этгээдийг исламын шашинт цагаач эсвэл орогнол хүсэгч байсан гэх худал мэдээлэл онлайн орчинд өргөн тархсан. Сошиал медиа платформ Х нь арьс үндсээр ялгаварласан, исламын эсрэг болон гаднынхныг үзэн ядах үзэл бүхий үг хэллэгийн талбар болж улмаар сүм хийд, дүрвэгсдийн байр, Ази, Хар арьстнууд болон Исламын шашинт иргэд оффлайн орчинд хүчирхийлэл, халдлагын бай болсон. Үүний зэрэгцээ X Corp болон Meta (Facebook болон Instagram-ийг ажиллуулдаг) платформуудын аюулгүй, найдвартай байдлыг хангах, хор хөнөөлтэй зан үйлээс хамгаалах чиг үүрэг бүхий итгэл ба аюулгүй байдлын ажилтнуудыг их хэмжээгээр цомхотгож, баримт шалгах хөтөлбөрүүдийг бууруулсан.

Хүүхдийг онлайн орчинд хэрхэн үр дүнтэй хамгаалах асуудлыг олон тооны улс анхаарч хэлэлцсэн. Австрали улс 2025 онд 16-аас доош насны хүүхдүүдийг

сошиал медиа ашиглахыг хориглох шинэ хууль баталсан бол Малайз улс ижил төстэй үнэмлэхүйн хориг тавих төлөвлөгөөгөө зарласан. Эдгээр арга хэмжээ нь хор хөнөөлтэй платформуудыг зохицуулахад чиглэсэн боловч залуучуудын үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэлд нэвтрэх эрхийг хязгаарлаж, сошиал медиа платформууд хэрэглэгчийн оролцоог нэмэгдүүлэх, хувийн мэдээллийг ашиглах зорилгоор бүх хэрэглэгчдэд хор хөнөөл учруулдаг суурь бүтцийн үндсэн шалтгааныг шийдвэрлээгүй хэвээр байна. Эмнести Интернэшнл 2025 онд сэтгэцийн эрүүл мэндийн талаарх мэдээллийг сонирхсон хүүхэд, залуус TikTok дээр сэтгэл гутрал болон амиа хорлохтой холбоотой бичлэгийг үзээд дараагийн төстэй сөрөг бичлэгүүд рүү тасралтгүй хөтлөгдөн орж, ийм агуулгад амархан автаж байгааг онцолсон.

Илүү олон байгууллага, идэвхтнүүд сошиал медиа платформуудын томоохон компаниудыг эсрэг шүүхийн маргаан өдүүлсэн. Кени улсад Meta-гийн эсрэг гаргасан нэгэн шүүхийн маргаанд Facebook-ийн алгоритмын үйл ажиллагаатай холбоотой ноцтой хууль зүйн асуудлуудыг хөндсөн бөгөөд 2025 онд урьдчилсан шүүх хуралд ялсан. Кенийн Дээд шүүх Meta компанийн эсэргүүцлийг үл харгалзан үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийн зөрчлийг хэлэлцэх өөрийн эрх зүйн харьяаллыг баталгаажуулсан. 2020–2022 оны Этиопын зэвсэгт мөргөлдөөний үеэр Facebook аюултай онлайн агуулгыг түгээсэн хэмээн үзсэн дээрх нэхэмжлэлийг Этиоп улсын хоёр иргэн, Кенийн Катиба Институт гаргасан бөгөөд Эмнести Интернэшнл дэмжлэг үзүүлсэн.

Энэхүү шийдвэр нь газарзүйн байршлаас үл хамааран нийгэм, эдийн засгийн эмзэг бүлгийнхэн шүүхэд хандах боломжийг хангахад чухал алхам болсон бөгөөд АНУ болон Европоос бусад улс орнуудыг зөвхөн ашиг олох зах зээл гэж үздэг өргөн тархсан ойлголтыг буруутгахад чухал ач холбогдолтой.

**Сошиал медиа компаниуд өөрсдийн үйл ажиллагаагаар хүний эрхэд учруулах хор уршгийг таслан зогсоохын тулд бизнесийн загвараа үндсээр нь өөрчилж, үүссэн сөрөг нөлөөллийг шийдвэрлэх шаардлагатай. Улс орнууд бүх хэрэглэгчийг хамгаалах илүү хүчтэй зохицуулалт нэвтрүүлж, одоо байгаа зохицуулалтыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай.**

# АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Бүс нутгийн хэмжээнд томоохон зэвсэгт мөргөлдөөнүүд намжилгүй хэвээр үргэлжилсэн бөгөөд тэдгээрийг зогсоох дипломат оролдлогууд нь мөргөлдөөнөөс үүдсэн зөрчлийг таслан зогсоох, энгийн иргэдийг хамгаалах, гэм буруутай этгээдүүдэд хариуцлага тооцох чиглэлд амжилт гаргаж чадсангүй. Түүнчлэн хөндлөнгийн оролцогч талууд сөргөлдөгч талуудад сум, зэвсэг нийлүүлэх зэргээр мөргөлдөөнийг улам хурцатгав.

Африкийн Холбоо 2014 онд дэвшүүлсэн “2025 он гэхэд өлсгөлөнг арилгаж, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоо хэрэгжүүлж чадсангүй. АНУ тусламжаа танасны улмаас бүс нутгийн эрүүл мэндийн тогтолцоо улам доройтож, зайлшгүй эмчилгээ үйлчилгээ тасалдаж, зарим үйлчилгээ бүр зогсов.

Засгийн газрууд эсэргүүцлийн жагсаал, цуглааныг аюул занал хэмээн үзэж, хүч хэрэглэн тараах, үндэслэлгүйгээр хязгаарлах, хориглох арга хэмжээ авав. Эдгээр дарамт шахалт сонгуулийн үеэр улам эрчимжиж, цэргийн дэглэмтэй улс орнууд үндэсний аюулгүй байдлыг хангах нэрийдлээр шүүмжлэлт дуу хоолойг нухчин дарлаа.

Сая сая хүн мөргөлдөөн, уур амьсгалын нөлөөллөөс үүдсэн гамшгийн улмаас дүрвэв. Судан улс дэлхийн дүрвэгсдийн хамгийн том, хамгийн хурдацтай тэлж байгаа хямралын голомт хэвээр байв.

Засгийн газрууд, олон улсын байгууллагууд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас даамжирч байгаа ган гачиг, үерийн хор уршгаас бүс нутгийн иргэдийг хамгаалж чадсангүй.

Нийгмийн хэм хэмжээг зөрчиж, хүний эрхийн эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэгчид охид, эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийллийг өдөөсөн хэвээр байв. Түүнчлэн засгийн газрууд ЛГБТИ хүмүүсийн эсрэг эрх зүйн тогтолцоог зэвсэг болгон ашиглаж, ялгаварлан гадуурхлаа.

Эрх баригчид ял шийтгэл завшихтай тэмцэх, хариуцлага тооцох хүчин чармайлтыг сулруулж, онц ноцтой гэмт хэргийн хохирогчид болон амьд үлдсэн хүмүүсийн шударга ёсыг тогтоох, зөрчигдсөн эрхээ үр дүнтэй сэргээлгэх боломжийг нь үгүй хийв.

## ХУУЛЬ БҮС ХАЛДЛАГА, АЛЛАГА

Судан улсад мөргөлдөөн улам хурцдаж, нэг болон хоёрдугаар сард Суданы Зэвсэгт Хүчин (СЗХ) Шуурхай Дэмжих Хүчин (ШДХ) нийслэл Хартум болон Гезира мужийг эргүүлэн эзлэн авсан. Хяналтаа дахин тогтоох явцдаа СЗХ, тэдний холбоотнууд энгийн иргэд рүү халдав. Гезира мужид тэд Канаби иргэдийг ШДХ-тэй хамтран ажиллаж, дэмжсэн хэмээн буруутгаж халдлага үйлдсэн. Тэд энгийн иргэдийг хөнөөж, орон гэрийг нь галдан шатааж, эд хөрөнгө болон мал сүргийг нь дээрэмдсэн. ШДХ аравдугаар сард Хойд Дарфур дахь Эл Фашер хотыг 18 сарын бүслэлтийн дараа хяналтдаа авсан. Хотыг эзэлсний дараа ШДХ-ийнхэн энгийн иргэдийг олноор нь хөнөөж, охид, эмэгтэйчүүдийг хүчиндэх болон бусад бэлгийн хүчирхийлэл үйлдэж, хүмүүсийг барьцаалж мөнгө нэхсэн. ШДХ нь Кордофан бүс нутаг, түүний дотор Хойд Кордофан дахь Бара хот руу хийх довтолгоог улам нэмэгдүүлж, шүүхийн шийдвэргүйгээр хүмүүсийг олноор нь цаазалсан. Үүний зэрэгцээ гаднын оролцогчид талуудад зэвсэг нийлүүлэх зэргээр мөргөлдөөнийг улам өдөөв. Арабын Нэгдсэн

Эмират Улс Шуурхай Дэмжих Хүчинд Хятадад үйлдвэрлэсэн дэвшилтэт зэвсэг нийлүүлснийг тус бүлэглэл Дарфурт ашигласан.

Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсын (БНАКУ) зүүн бүсэд нэг, хоёрдугаар сард мөргөлдөөн ширүүсэж, Руандагийн дэмжлэгтэй зэвсэгт бүлэглэл болох “Гурван сарын 23 Хөдөлгөөн” (М23) Хойд Киву болон Өмнөд Киву бүс нутгийн Гома, Букаву хотуудыг тус тус эзэлсэн. Тэд энгийн иргэдийг алж, баривчлагдсан хүмүүсийг эрүүдэн шүүж, бусад байдлаар хэрцгий, хүнлэг бус нөхцөлд байлгасан. Тус бүлэглэлийн цэргүүд Гома дахь эмнэлгүүдэд халдаж, өвчтөнүүд болон асрагчид, зарим тохиолдолд эмнэлэгт нуугдаж байсан Конгын цэргүүдийг хүчээр авч явсан. Нэгдүгээр сарын 28-наас дөрөвдүгээр сарын 9-ний хооронд тус бүлэглэл Гома хотод 200 гаруй хүнийг хөнөөсөн. Мөн долдугаар сарын 9-нөөс 21-ний хооронд Рутшуру бүсэд хамгийн багадаа 319 хүнийг хөнөөсөн. Түүнчлэн зэвсэгт бүлэглэлүүд Итури мужид харгис үйлдэл гаргасан. Конгог Хөгжүүлэх Нэгдэл/Конгийн Ард Түмнийг Хамгаалах Хувьсгалчдын Бүлэг нэг болон хоёрдугаар сард 150 гаруй хүнийг хөнөөсөн бол долдугаар сараас наймдугаар сарын хооронд Холбоот Ардчилсан Хүчнүүд (Угандагийн зэвсэгт бүлэглэл) Итури болон Хойд Кивугийн Луберо бүс нутагт 250 гаруй энгийн иргэнийг хөнөөсөн.

Бүс нутагт удаан хугацаанд үргэлжилж байгаа бусад мөргөлдөөний үеэр засгийн газрын хүчнүүд, зэвсэгт бүлэглэлүүдийн хууль бус халдлага, аллага үйлдсэн талаарх мэдээлэл, Буркина Фасо, Камерун, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс (ТӨАБНУ), Мали, Мозамбик, Нигер, Нигери, Сомали болон Өмнөд Судан зэрэг улсад үргэлжилсээр байв. Буркина Фасод цэргийн хүчин, тэдний холбоотон болох “Эх орноо хамгаалах сайн дурынхан” бүлэглэл гуравдугаар сарын 10-наас 11-ний хооронд Банкуй бүсийн Солензо хот, түүний ойр орчимд дор хаяж 58 энгийн иргэнийг хөнөөсөн. Тус аллагын дүрс бичлэг олон нийтийн сүлжээгээр өргөн тархсан. Малид цэргийн хүчнийхэн, заримдаа Вагнер бүлгийн (Оросын хувийн цэргийн бүлэглэл) дэмжлэгтэйгээр энгийн иргэдийг шүүхийн шийдвэргүйгээр цаазалсан олон тохиолдол гарсан. Дөрөвдүгээр сард Куликоро дахь Квала цэргийн баазын ойролцоо хэдэн арван эрэгтэйг буудан хөнөөж, цогцсуудыг нь хаяжээ. Тавдугаар сард цэргүүд 23-27 орчим эрэгтэйн хоолойг огтолж, цогцсыг хамтад нь буулсан. Мали улсад хүмүүнлэгийн нөхцөл улам дордож, зэвсэгт бүлэглэлүүд хэд хэдэн хот, суурин газарт, түүний дотор нийслэл Бамако хотод бүслэлт тогтоосон. Хоёрдугаар сард Сахелийн бүс нутаг дахь Исламын улс бүлэглэл Гао хотын ойролцоох Кобе тосгоны орчим Малийн аюулгүй байдлын хүчний хамгаалалтад байсан энгийн иргэдийн цуваа руу халдсаны улмаас 34 иргэн амь үрэгджээ. Мозамбикт засгийн газрын зэвсэгт хүчин болон Кабо Делгадо бүс нутгийн Аль-Шабааб зэвсэгт бүлэглэлийн хоорондын мөргөлдөөн хурцдаж арван нэгдүгээр сард Нампула бүс нутгийг хамран тэлсэн. Үүний улмаас ихэвчлэн Кабо Делгадод олон арван энгийн иргэн амь үрэгдсэн.

**Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд энгийн иргэд болон иргэний дэд бүтэц рүү зориуд болон ялгаваргүйгээр халдах явдлыг зогсоож, иргэдийг хамгаалах ёстой.**

## **ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНТЭЙ ХОЛБООТОЙ БЭЛГИЙН БОЛОН ЖЕНДЭРИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ**

Зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн хүчирхийллийн тохиолдлууд Төв Африкийн Бүгд Найрамдах Улс (ТАБНУ), БНАКУ, Сомали, Өмнөд Судан, Судан зэрэг улсад түгшүүр төрүүлэхүйц түвшинд үргэлжилсээр байна. ТАБНУ-д энэ төрлийн хүчирхийлэл өргөн тархсан, мэдээлэгдээгүй тохиолдол их байгаа бөгөөд НҮБ-ын ТАБНУ дахь Олон Талт Нэгдсэн Тогтворжуулах Ажиллагааны байгууллагын мэдээлснээр есөн сарын хугацаанд 295 тохиолдол бүртгэгджээ. Эдгээр хүчирхийллийн ихэнх нь “Буцаан авч, Сэргээн босгох” зэвсэгт бүлэглэлтэй холбоотой бол засгийн газрын цэргийн хүчнийхэн мөн заримд нь холбогджээ.

БНАКУ-ын зүүн хэсэгт бэлгийн хүчирхийлэл, тэр дундаа зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн хүчирхийллийн тохиолдлууд маш өндөр түвшинд хүрсэн. НҮБ-ын мэдээлснээр нэгдүгээр сараас есдүгээр сарын хооронд 81,000-аас дээш хүчиндэх гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2024 оны мөн үеийнхтэй харьцуулахад 31.5 хувиар өссөн үзүүлэлт юм. Зүүн Конгод баримтжуулсан зөрчлүүдийн дотор М23 бүлэглэл, Конго улсын арми болон Вазалендо (Конго улсын армийн дэмжлэгтэй зарим зэвсэгт бүлэглэлийн эвсэл) зэрэг зэвсэгт бүлэглэлүүд эмэгтэйчүүдийг бүлэглэн хүчиндэх хэргүүд багтсан.

Суданы ШДХ-ийхэн эмэгтэйчүүдийг гутаан доромжлох, шийтгэх, хяналтаа тогтоох, айдас төрүүлэх, албадан нүүлгэх зорилгоор бэлгийн хүчирхийллийг өргөн хүрээтэй, системтэйгээр ашигласан бөгөөд энэ нь Хартум, Гезира, мөн Хойд болон Өмнөд Дарфурын хот, тосгодыг хамарчээ. НҮБ-ын Суданы асуудлаарх Хараат бус олон улсын баримт тогтоох ажлын хэсгийн мэдээлснээр Суданы зэвсэгт хүчнийхэн Цагаан Нил, Хөх Нил, Хартум болон Хойд бүс нутагт хоригдож байгаа эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг хүчиндэх, бэлгийн дарамт, бэлгийн шинжтэй эрүүдэн шүүх зэргээр бэлгийн хүчирхийлэл үйлджээ.

**Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд өөрийн гишүүд, цэргийнхэн бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэхийг хориглосон тодорхой шийдвэр гаргах шаардлагатай бөгөөд өөрсдийн хяналтад байгаа нутаг дэвсгэрт хохирогчдыг хамгаалах, асрамж, эмчилгээ, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх механизмыг зайлшгүй бүрдүүлэх үүрэгтэй.**

## ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХ

### ХООЛ, ХҮНСНИЙ ЭРХ

Уур амьсгалын өөрчлөлт, эдийн засаг болон зөрчил мөргөлдөөний улмаас бүс нутагт өлсгөлөн нүүрлэв. Долоодугаар сарын байдлаар бүс нутгийн хүн амын 20%-иас дээш буюу 307 сая гаруй хүн өлсгөлөнд нэрвэгдсэн. Олон улсын тусламж, ялангуяа АНУ-ын Засгийн газрын тусламж зогссон нь хэд хэдэн улсад хоол хүнсний дутагдал үүсгэсэн. АНУ-ын тусламжийн таналт нь Мадагаскар улсад уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн ган гачиг өлсгөлөнгийн хямралыг улам хүндрүүлсэн. Тус улсын Гранд Суд бүс нутагт хоёрдугаар сард ойролцоогоор 8,000 хүүхэд хүнд хэлбэрийн шим тэжээлийн дутагдал оноштойгоор эмнэлэгт хэвтжээ. Малави улсад ургац алдсан нь хүнсний аюулгүй байдалд нөлөөлж, хүнс тэжээлийн дутагдлын түвшин 4.4%-иас 7.1%-д хүрч огцом өссөн.

Мөргөлдөөнд нэрвэгдсэн улс орнуудын иргэдийн нөхцөл байдал төсөөлөхийн аргагүй хүнд байсан бөгөөд Өмнөд Судан, Судан улсын хүн амын талаас илүү хувь нь хүнсний ноцтой эрсдэлд өртжээ. Өмнөд Суданд ойролцоогоор 28,000 хүн амь насанд нь аюул учруулахуйц өлсгөлөнд нэрвэгджээ. Судан улсын хэд хэдэн бүсэд сая сая хүн өлсөх эрсдэлд орсон. Мали улсын Госси, Лере, Диарарабэ, Кайес болон Ниоро ду Сахель зэрэг хэд хэдэн хот, суурин газар зэвсэгт бүлэглэлүүдийн тогтоосон бүслэлтийн улмаас хүнсний аюулгүй байдал алдагдав.

### СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

Бүс нутгийн хэмжээнд олон сая хүүхэд зөрчил мөргөлдөөн, аюулгүй байдлын улмаас сургуульд хамрагдаж чадсангүй. Камерун улсын Хойд-баруун болон Өмнөд-баруун бүсэд 14,829 сургууль хаагдаж, 3 сая гаруй хүүхэд боловсрол эзэмшиж чадаагүйн зэрэгцээ хүүхдийг төрийн бүс зэвсэгт бүлэгт элсүүлэх нь улам бүр нэмэгдсэн. НҮБ-ын Хүүхдийн сангийн мэдээлснээр 3 дугаар сарын 31-ний байдлаар Чад улсын баруун бүсэд 849,000 хүүхэд сургуульд хамрагдаж чадаагүй. Мали улсад 2,036 сургууль

хаагдсан нь 618,000 хүүхдийн сурч боловсрох эрхэд нөлөөлсөн. Мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн мэдээлснээр Өмнөд Судан улсын нийт хүүхдүүдийн 70-аас дээш хувь нь сургуульд сурч чадсангүй.

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРХ**

АНУ-ын Засгийн газрын тусламжийн санхүүжилт зогссоны улмаас Камерун, ТАБНУ, Гана, Лесото, Малави, Намиби, Нигери, Өмнөд Африк, Өмнөд Судан, Замби зэрэг улс орнуудад ХДХВ, хумхаа, сүрьеэ, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн суурь үйлчилгээний хүртээмж тасалдаж, хумигдав. НҮБ-ын Хүн амын сангийн тавдугаар сарын мэдээлэлд дурдсанаар ТАБНУ-д хүчингийн хэрэг, хүүхдийн гэрлэлт, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл өндөр түвшинд бүртгэгдэж буй нөхцөлд санхүүжилтийг бууруулж, зогсоох нь 70,000 орчим охид, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг эрсдэлд оруулжээ. Лесото, Нигери, Сьерра Леон, Өмнөд Африк болон Замби улсад тусламжийн санхүүжилт буурснаар сүрьеэ, ХДХВ-ийн эсрэг үйлчилгээний санхүүжилт зогсож, улмаар эмнэлгүүд хаагдах, ажилтнуудыг цомхотгоход хүргэсэн. Зөвхөн Лесото улсад л гэхэд хандивлагч байгууллагуудын хөтөлбөрийн санхүүжилтээр ажиллаж байсан ойролцоогоор 1,500 эрүүл мэндийн ажилтан ажилгүй болжээ.

## **АЛБАДАН НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ**

Засгийн газрууд албадан нүүлгэн шилжүүлэлтийг үргэлжлүүлсний улмаас олон хүн орон гэргүй болж, амьжиргаагаа алдсан. Этиоп улсад “дэд бүтэц, орон сууц, нийтийн байгууламж” сайжруулах зорилготой хэмээн эрх баригчдын тайлбарласан Коридор хөгжлийн төслийн хүрээнд нийслэл Аддис-Абаба хотыг оролцуулан 60 хотод олон мянган хүнийг албадан нүүлгэн шилжүүлсэн. Эрх баригчид нүүлгэн шилжүүлэлтийг эсэргүүцсэн оршин суугчдыг дарамталж, уг асуудлыг мэдээлсэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнуудыг айлган сүрдүүлсэн. Хоёрдугаар сард Нигери улсын Кано мужийн засгийн газраас Унгого орон нутгийн захиргааны нэгжийн Римин Аузинава сууринд хүч хэрэглэн албадан нүүлгэн шилжүүлэх ажиллагаа явуулах үеэр дор хаяж дөрвөн хүн амь үрэгдсэн. Гуравдугаар сард Лагос мужийн засгийн газар Илаже-Отумара сууриныг албадан нүүлгэн шилжүүлэх ажиллагаа явуулснаар 10,000 гаруй хүн орон гэргүй болсон.

**Засгийн газрууд өлсгөлөнгөөс сэргийлэх шуурхай арга хэмжээ авах, хүнсний аюулгүй байдлын шалтгааныг тодорхойлж, шийдвэрлэх зэргээр эдийн засаг, нийгмийн эрхийг хангах, Аюулгүй сургуулийн тунхаглалыг дэмжин хэрэгжүүлэх, зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах хүчин чармайлтаа эрчимжүүлэх шаардлагатай. Түүнчлэн, Абуджагийн тунхаглалын дагуу улсын төсвийн хамгийн багадаа 15 хувийг нийтийн эрүүл мэндийн салбарт хуваарилж, эрүүл мэндийн эрхийг хэрэгжүүлэхэд саадтай бодлого хэрэгжүүлэхээс зайлсхийх шаардлагатай. Мөн албадан нүүлгэн шилжүүлэлтийг зогсоож, хориглох, нийтийг хамарсан нүүлгэн шилжүүлэлтийг түр хугацаагаар түдгэлзүүлэх, олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд нийцсэн хууль эрх зүйн болон процедурын баталгааг бүрдүүлэх шаардлагатай.**

# ЭСЭРГҮҮЦЭЛ, ШҮҮМЖЛЭЛИЙГ ДАРАНГУЙЛАХ

## ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Аюулгүйн хүчнийхэн эсэргүүцлийн жагсаал, цуглааныг хүний амь насанд аюултай хууль бус хүч хэрэглэж тараасны улмаас олон хүн амь насаа алдсан. Танзани улсад сонгуулийн дараа өрнөсөн эсэргүүцлийн жагсаал, цуглааныг хүчээр тараах ажиллагааны үеэр аравдугаар сарын сүүлээс арван нэгдүгээр сарын эхний хооронд хэдэн зуун хүн амь үрэгдсэн. 2024 онд дор хаяж 60 хүн амь үрэгдсэн жагсаалын ойг тохиолдуулан 6 дугаар сарын 25-нд Кени улсад зохион байгуулсан залуучуудын жагсаалын үеэр цагдаа нар хууль бус хүч хэрэглэсний улмаас дор хаяж 19 хүн амь насаа алдсан. Мөн 7 дугаар сарын 7-нд ардчиллын төлөөх “Саба Саба Өдөр” жагсаалын 35 жилийн ойн хүрээнд улс даяар зохион байгуулсан жагсаалын үеэр дор хаяж 38 хүн амь насаа алдсан. Камерун улсад ерөнхийлөгчийг найм дахь удаагаа улируулан сонгогдсоныг эсэргүүцсэн жагсаалын үеэр аравдугаар сард л гэхэд хамгийн багадаа 48 хүн амь үрэгдсэн хэмээн НҮБ-ын мэдээллийн эх сурвалжийг эш татаж Ройтерс агентлаг мэдээлсэн. Мадагаскар улсад засаглалын муу тогтолцоог эсэргүүцсэн жагсаалын үеэр ес болон аравдугаар сард дор хаяж 22 хүн амь үрэгдсэн. Того улсын нийслэл Ломе хотод зургадугаар сарын сүүлээр өрнөсөн жагсаал цуглааныг хүч хэрэглэн тараасны улмаас долоон хүн амь үрэгдсэн талаар иргэний нийгмийн байгууллагууд мэдээлсэн.

Ангол, Ботсвана, Бурунди, Камерун, Кот-д’Ивуар, Эсватини, Нигер зэрэг улсад эрх баригчид сөрөг хүчин болон засгийн газрыг шүүмжлэгчдийн зохион байгуулсан эсэргүүцлийн жагсаал, цуглааныг үндэслэлгүйгээр хязгаарлаж, хориглож, үнэмлэхүй хориг тавьсан. Эсэргүүцлийн жагсаалд зориг гарган оролцсон хүмүүсийг зодож, дур зоргоор баривчилсан. Кот-д’Ивуар улсын эрх баригчдын хууль бусаар хориглосон аравдугаар сард зохион байгуулагдсан эсэргүүцлийн жагсаалын үеэр сөрөг хүчний 1,600 гаруй дэмжигчдийг баривчилсан. Түүнчлэн, ажилтнуудын эрхийг хамгаалахыг шаардсан жагсаалыг хүртэл аюул заналхийлэл хэмээн үзсэн. Тухайлбал, Этиоп улсад өрнөсөн эмнэлгийн ажилтнуудын жагсаал, Кот-д’Ивуар улсад зохион байгуулагдсан Улсын ханган нийлүүлэгчдийн үндэсний холбооны суултад оролцогчид нэгэн адил шахалт, дарамтад өртсөн. Мөн жагсагчдыг зөвхөн тайван хуран цуглах эрхээ хэрэгжүүлсний төлөө эрүүгийн ял оноосон. Тухайлбал, Кени улсад 500 гаруй жагсагчийг терроризмын эсрэг хууль тогтоомж зөрчсөн зэрэг олон төрлийн гэмт хэрэгт буруутган эрүүгийн ял оногдуулсан.

## ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ

Эрх баригчдыг шүүмжлэгчдийг баривчлах, дур зоргоор саатуулах, шүүхээр дарамтлах зэргээр бүс нутгийн хэмжээнд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх аюул эрсдэлд өртсөн хэвээр байв. Ангол улсад Антонио Фредерико Гонсалвесыг цахимд байршуулсан видео бичлэгтэй нь холбогдуулан таван сараас илүү хугацаанд ямар нэгэн ял шийтгэл оногдуулахгүйгээр дур мэдэн саатуулсан бөгөөд уг бичлэг нь Анголчуудыг Буркина Фасо улсын түр ерөнхийлөгч Ибрахим Траорег дэмжин эв нэгдлийг харуулахыг уриалсан хэмээн буруутгажээ. Гвиней, Сенегал, Сьерра Леон болон Зимбабве улсад хэд хэдэн хүнийг “ерөнхийлөгчийг доромжилсон” үйлдэлд холбогдуулан хорьсон.

Кени улсад Альберт Ожвангийг цахимд байршуулсан засгийн газраас хариуцлага шаардаж байгаа бичлэгтэй нь холбогдуулан баривчилсан ба цагдаагийн түр саатуулах газарт сэжигтэй байдлаар амь насаа алдсан. Мали улсад ерөнхий сайд асан Мусса Мара үзэл бодлоо илэрхийлж хоригдсон хүмүүсийн эрхийг хамгаалахын тулд “бүхий л арга замаар тэмцэнэ” гэсэн бичлэгийг “Х”-д байршуулсныхаа төлөө нэг жилийн хорих ялаар шийтгүүлсэн. Лесото улсад нийгмийн сүлжээний идэвхтэн Тшооло Такели-г засгийн газрын эдийн засгийн бодлогыг шүүмжлсэн бичлэг

байршуулсных нь төлөө төрийг эсэргүүцсэн гэмт хэрэгт буруутган эрүүгийн ял оноосон бөгөөд энэ нь бусад идэвхтнүүд болон нийгмийн сүлжээний хэрэглэгчдэд ноцтой нөлөөлсөн. Танзани улсад сөрөг хүчний удирдагч Тунду Лиссу-г зөвхөн 10 дугаар сарын сонгуулийг бойкотлохыг дэмжсэн шалтгаанаар эх орноосоо урвах гэмт хэрэгт ялласан нь улс орны хэмжээнд шүүмжлэлт дуу хоолойг өргөн хүрээнд нухчин дарах тохиолдлын илрэл юм.

Бенин, Буркина Фасо, Бурунди, ТАБНУ, Этиоп, Нигер, Нигери, Мозамбик, Сомали, Уганда болон Зимбабве зэрэг улсад дур зоргоор баривчлах, саатуулах зэргээр сэтгүүлчдийн эсрэг чиглэсэн дарамт хэвээр байв. Буркина Фасогийн эрх баригчид сэтгүүлчид болон бусад шүүмжлэлт дуу хоолойг дуугүй байлгахын тулд цэргийн албанд хүчээр татсан. Этиоп улсад нүүрээ халхалсан хүмүүс сэтгүүлчийг баривчилж, харилцаа холбоо тогтоох боломжгүй нөхцөлд хорьж саатуулсан. Уганда улсад аюулгүйн хүчнийхэн парламентын сонгуулийн санал авах үеэр Каппала хотын Кавемпе дүүрэгт олон тооны сэтгүүлчдэд халдсан.

Бүс нутгийн хэмжээнд, ялангуяа Бенин, Буркина Фасо, Эритрея, Гвиней, Кени, Мозамбик, Нигер, Сенегал, Того, Уганда улсын эрх баригчид хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хариуцлага хүлээлгэх нь түгээмэл байв. Орон нутгийн болон олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийг онилов. Мозамбик улсад Вилда болон Энхкантро радиог 48 цагийн хугацаагаар, Бенин улсад Le Patriote сониныг 5 сарын хугацаагаар тус тус зогсоосон. Кени улсад 6 дугаар сарын 25-ны эсэргүүцлийн жагсаалыг Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзэж радио, телевизүүдээр шууд нэвтрүүлэхийг хориглох шийдвэр гаргасан. Нигери улсад дуучин Эдрис Абдулкаремийн “Аавыгаа хэлээч” дууг засгийн газрыг шүүмжилсэн хэмээн үзэж радио, телевизээр дамжуулахыг хориглосон. Уганда улсад NTV Uganda болон Daily Monitor сонины сэтгүүлчдийг ерөнхийлөгч болон парламентын үйл ажиллагааг сурвалжлахыг хориглосон.

Интернэтийг тасалдуулсан тохиолдол ч олноор гарсан. Өмнөд Судан улсын эрх баригчид интернэт үйлчилгээ үзүүлэгчдэд 30–90 хоногийн хугацаанд нийгмийн сүлжээний платформуудыг хаах тушаал өгсөн. Того улсад 6 дугаар сарын төгсгөлөөс 9 дүгээр сар хүртэл Facebook, TikTok-д нэвтрэхийг хязгаарласан. Танзани улсад 10 дугаар сард болсон сонгуулийн дараа шүүмжлэгчдийг дуугүй байлгахын тулд интернэтийг тогтмол хааж байв.

**Түүнчлэн ТАБНУ, Кени, Сьерра Леон зэрэг улсын засгийн газрууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг цаашид хязгаарлах эрсдэлтэй хууль тогтоомжийг баталсан.**

## **ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ**

Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний хатуу хязгаарлалт хэд хэдэн улсад улам эрчимжсэн. Буркина Фасо, Камерун, ТАБНУ, Нигер улсад төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл болон бусад эвлэл холбоодын үйл ажиллагааг түр зогсоох, татан буулгах, эсхүл үйл ажиллагаа явуулахыг хориглосон. Буркина Фасо улсад “Аюулгүй байгууллага” Олон улсын ТББ-ын үйл ажиллагааг гурван сарын хугацаагаар түдгэлзүүлсэн. Тус байгууллагын найман ажилтныг зөвхөн эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлснийх нь төлөө эх орноосоо урвах болон тагнуулын хэрэгт буруутган ялласан. Камерун улсын эрх баригчид Төв Африкийн Хүний Эрх Хамгаалагчдын Сүлжээний үйл ажиллагааг дур мэдэн түр зогсоож, тус байгууллагын удирдах зөвлөлийн дарга болон гүйцэтгэх захирлыг “терроризмыг санхүүжүүлсэн” зэрэг хэд хэдэн эрүүгийн гэмт хэрэгт буруутган ялласан.

Түүнчлэн, улс төрийн үйл ажиллагааг мөн хэд хэдэн улсад хязгаарлан боомилсон. Гвиней улсад сөрөг хүчний үндсэн гурван намын үйл ажиллагааг гурван сарын хугацаагаар түр зогсоосон бол Мали улсад бүх улс төрийн намыг татан буулгасан. Уганда улсын аюулгүйн хүчнийхэн хоёрдугаар сараас зургадугаар сарын хооронд

нийслэл Кампала хот дахь сөрөг хүчний Үндэсний Эв Нэгдлийн Намын байрыг бүслэн хааж дөрвөн удаа гэнэтийн нэгжлэг хийсэн. Буркина Фасо, Этиоп, Зимбабве зэрэг бусад улсад чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласан шинэ хууль батлах эсхүл хуулийн төсөл өргөн барьсан.

## **ХҮЧЭЭР АЛГА БОЛГОХ**

Бүс нутгийн түвшинд хүмүүсийг хүчээр алга болгох явдал түгээмэл хэвээр байв. Буркина Фасо, Бурунди, БНАКУ, Гвиней, Кени, Мали, Мозамбик, Нигер, Танзани, Уганда зэрэг улсад энэ төрлийн үйл ажиллагаа өргөн тархсан. Ялангуяа Зүүн Африкт хил дамнасан шинжтэй хүчээр алга болгох тохиолдол нэмэгдэх хандлага ажиглагдсан.

Гуравдугаар сард Танзаний хүний эрхийн идэвхтэн Мария Сарунги Цехайг Кени улсын Найроби хотод багтай хүмүүс улсын дугааргүй машинд хүчээр суулган, улмаар хэдэн цагийн турш саатуулахдаа хоолойг нь багалзуурдаж, айлган сүрдүүлсэн. Дараа нь түүнийг хүнгүй, алслагдсан газарт орхисон. Тавдугаар сард Угандагийн хүний эрх хамгаалагч Агатер Атухайре болон Кенийн хүний эрхийн идэвхтэн Бонифас Мванги нарыг Танзани улсын Дар-эс-Салам хотод Тунду Лиссүгийн шүүх хурлыг ажиглахаар очих үед нь Танзанийн аюулгүй байдлын албаныхан дур зоргоор баривчилсан. Тэднийг үл мэдэгдэх газарт, холбоо барих боломжгүйгээр саатуулж, дөрвөн хоног эрүүдэн шүүсний эцэст албадан нутаг буцаасан. Уганда улсын Кампала хотод аравдугаар сарын 1-нд цэргийн дүрэмт хувцастай, зэвсэглэсэн багтай хүмүүс Кенийн хүний эрхийн идэвхтэн Боб Нжаги, Николас Ойёо нарыг сөрөг хүчний удирдагч Роберт Кягуланигийн сонгуулийн кампанит ажлын цуглаанд оролцсоных нь дараа хүчээр авч явсан. Тэдний хаана байгааг арван нэгдүгээр сарын 8 хүртэл мэдэгдээгүй бөгөөд тухайн өдөр Угандагийн Ерөнхийлөгч Мусевени тэднийг “үймээн самууны мэргэжилтнүүд” байсан тул аюулгүй байдлын хүчнийхэн баривчилсан хэмээн мэдэгдсэн. Ерөнхийлөгч мэдэгдэл хийсэн өдөр тэднийг суллаж, Кенийн эрх баригчдад хүлээлгэн өгсөн.

**Засгийн газрууд хууль сахиулах зорилгоор хүч хэрэглэх нь олон улсын хүний эрхийн эрх зүй болон хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах; үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх болон тайван хуран цуглах эрхээ хэрэгжүүлж буй хүмүүсийн эсрэг чиглэсэн бүх төрлийн дарамт, хавчилтыг зогсоох ёстой. Тэд интернэт, дижитал платформ болон харилцаа холбооны үйлчилгээг хаах, тасалдуулах үйлдлээс татгалзах; хэвлэл мэдээллийн байгууллагуудыг хараат бусаар үйл ажиллагаа явуулах боломжийг хангах зэргээр хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хүндэтгэх шаардлагатай. Мөн хүмүүсийг хүчээр алга болгохыг эцэс болгож, алга болсон хүмүүсийн нөхцөл байдал, тэдний хаана байгааг нэн даруй ил тод болгох; хүний эрх хамгаалагчид, иргэний нийгмийн байгууллагууд, сөрөг хүчний гишүүд аюулгүй, саадгүй үйл ажиллагаа явуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.**

## **ДОТООДОО ШИЛЖИН СУУРЬШИГЧИД, ДҮРВЭГСЭД БОЛОН ЦАГААЧДЫН ЭРХ**

Дотооддоо шилжин суурьшигчид, дүрвэгсэд болон цагаачдын эрх бүс нутаг даяар зөрчигдсөн хэвээр байв. 2024 оны арван хоёрдугаар сараас 2025 оны хоёрдугаар сарын хооронд Этиоп улс Эритрей улсаас дүрвэн ирсэн 600 гаруй эритрей иргэнийг албадан нутаг буцаасан бөгөөд Эритрей улсын засгийн газар тэднийг ийнхүү орогнол хүссэн нь эх орноосоо урвасан үйлдлийн нотолгоо хэмээн үзсэн.

Хоёрдугаар сард М23 зэвсэгт бүлэглэл БНАКУ-ын Гома хотын ойролцоох дотооддоо шилжин суурьшигчдын хэд хэдэн лагерьг хааснаар хэдэн арван мянга гаруй хүн амьдрах газаргүй болсон. Дөрөвдүгээр сард ШДХ Судан улсын Хойд Дарфур дахь Замзам дотооддоо шилжин суурьшигчдын лагерьт халдлага үйлдсэний улмаас 300-1500 хүний аминд хүрсэн бөгөөд ихэнх нь эмэгтэйчүүд, хүүхдүүд байв. Түүнчлэн дөрөвдүгээр сард Камеруны хэд хэдэн иргэдийг тус улсын Элчин сайдын яаманд урьдчилан мэдэгдэлгүйгээр Экваторын Гвиней улсаас албадан гаргасан. Өмнөд Африк дахь “Дудулаг ажиллагаа” хэмээх гаднын иргэдийг үзэн ядагч иргэдийн бүлэг цагаачдыг дарамталж, тэднийг эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд нэвтрүүлээгүйн улмаас Йохансбург хотод долдугаар сард нэг настай хүүхэд нас барахад хүргэсэн.

АНУ-ын засгийн газрын тусламж зогссон нь дотооддоо шилжин суурьшигчид болон бусад дүрвэгсдийн лагерь дахь нөхцөл байдлыг улам дордуулсан. Түүнчлэн Эсватини, Экваторын Гвиней, Руанда, Өмнөд Судан болон Уганда зэрэг улс АНУ-аас албадан гаргасан гуравдагч улсын иргэдийг хүлээн авах талаар АНУ-тай хоёр талт хэлэлцээр байгуулах талаар хэлэлцэж, зарим нь хэлэлцээр хийсэн. Ийм хэлэлцээрийн хүрээнд Эсватини улс 15, Өмнөд Судан 8 гуравдагч улсын иргэнийг хүлээн авсан бөгөөд тэдний ихэнх нь оны эцэс гэхэд дур зоргоор саатуулагдсан хэвээр байсан. Хүний болон Ард түмний эрхийн талаарх Африкийн Комиссын зүгээс эдгээр хоёр талт хэлэлцээрийн ил тод бус байдал болон хүлээн авагч улс орнууд руу албадан гаргасан хүмүүсийн эрхийн хамгаалалт хангалтгүй байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлсэн.

**Засгийн газрууд дүрвэгсэд, цагаачдыг албадан нутаг буцаах, олноор нь албадан гаргахаас хамгаалах ёстой; АНУ-тай байгуулсан хоёр талт хэлэлцээрийн дагуу хүлээн авсан гуравдагч улсын иргэд хаана байгаа болон тэдний эрх зүйн байдлын талаарх мэдээллийн ил тод байдлыг хангаж, тэдний эрхийг баталгаажуулах, түүнчлэн аливаа нутаг буцаах үйл ажиллагааг сайн дурын үндсэн дээр, хүний эрхийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулах шаардлагатай.**

## **ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ БОЛОН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЭМЗЭГ БҮЛГИЙГ АЛАГЧЛАХ**

Бүс нутаг даяар жендэрт суурилсан хүчирхийлэл, тухайлбал, эмэгтэйчүүдийн хүйсэд суурилсан аллага үргэлжилсээр байна. Нэгдүгээр сард хийсэн Афробарометрын судалгаагаар Эсватини улсад судалгаанд оролцогчдын 41 хувь нь жендэрт суурилсан хүчирхийлэл эмэгтэйчүүдийн эрхийн хамгийн тулгамдсан асуудал хэмээн үзжээ. Кени улсад 1-3 дугаар сар хүртэл жендэрт суурилсан эмэгтэйчүүдийн аллагын 129 тохиолдол бүртгэгджээ. Засгийн газраас энэ төрлийн гэмт хэрэгт хариу арга хэмжээ авах ажлын хэсэг байгуулсан хэдий ч бодит үр нөлөө тодорхой бус хэвээр байна. Кот-д’Ивуар, Өмнөд Африк, Замби болон бусад улсад хэдэн зуун эмэгтэйчүүд охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохыг шаардан эсэргүүцлийн жагсаал зохион байгуулсан. Өмнөд Африкт 11 дүгээр сард өрнөсөн эсэргүүцлийн жагсаал нь Йохансбургт болсон G20 дээд хэмжээний уулзалттай давхацсан бөгөөд Засгийн газар жендэрт суурилсан хүчирхийллийн түвшинг үндэсний гамшиг гэж зарласан.

Зарим улс орнуудад эерэг өөрчлөлт гарсан. Тухайлбал, Буркина Фасо улс Иргэн болон Гэр бүлийн хуулийг шинээр баталж, эрэгтэй, эмэгтэйчүүдийн гэрлэх хууль ёсны доод насыг 18 байхаар хуульчилж, уламжлалт болон шашны гэрлэлтийг хүлээн зөвшөөрч бэхжүүлсэн. Чад улсад охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг шинээр баталсан. Сьерра-Леоне улсад Хүүхдийн эрхийн тухай шинэчлэн найруулан баталсан хууль хэрэгжиж эхэлсэн бөгөөд хүүхдийг эрт болон албадан гэрлүүлэхийг хориглосон. Хоёрдугаар сард Эмэгтэйчүүд ба охидын эсрэг хүчирхийллийг зогсоох Африкийн Холбооны Конвенц баталж,

тивийн хэмжээнд хууль эрх зүйн орчин бүрдсэн боловч зарим иргэний нийгмийн байгууллагууд уг конвенцын зохицуулалт сул, хангалтгүй байгааг шүүмжлэв.

Засгийн газрууд эрх зүйн тогтолцоог ЛГБТИ хүмүүсийг онолох, ялгаварлан гадуурхах зорилгоор ашигласан хэвээр байна. Буркина Фасо улсад шинэ Иргэний болон Гэр бүлийн хуулиар ижил хүйстний харилцан тохиролцсон бэлгийн харилцааг гэмт хэрэгт тооцсон. Гана улсад хууль тогтоогчид ЛГБТИ хүмүүсийг гэмт хэрэгт тооцох хуулийн төслийг дахин өргөн барьсан. Өмнөд Африк улсад өөрийгөө нээлттэй зарласан анхны гей имам (шашны номлогч), хүний эрх хамгаалагч Мухсин Хэндриск ижил хүйстний хоёр гэрлэлтийг гэрчлэх замдаа алагдсан нь тус улсын ЛГБТИ хүмүүст тулгарч буй эрсдэлийн тодорхой жишээ юм. Замби улсын Үндсэн хуулийн шүүх тус улсын Эрүүгийн хуулийн 155(а)(с)-д ижил хүйстний бэлгийн харилцааг гэмт хэрэгт тооцсон заалтыг хүйсээр ялгаварлан гадуурхсан үндэслэлээр Үндсэн хуульд нийцээгүй хэмээн үзэж хандсан хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон.

**Засгийн газрууд охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эсрэг бүх төрлийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, үндсэн шалтгааныг шийдвэрлэх, хор уршгийг таслан зогсоох шаардлагатай. Түүнчлэн ЛГБТИ хүмүүсийн эсрэг хууль эрх зүйн зохицуулалтыг хүчингүй болгож, ижил хүйстний бэлгийн харилцааг гэмт хэрэг гэж тооцохоос зайлсхийх шаардлагатай.**

## ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Засгийн газрууд болон олон улсын хамтын нийгэмлэг уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн ган гачиг, үерийн нөлөөллөөс бүс нутгийн иргэдийг хамгаалж чадсангүй. Сомали улсад нүүрлэсэн ган гачиг нь хоол хүнс, ундны цэвэр усны эрхийг улам доройтуулж, дотоодын болон хил дамнансан шилжилт хөдөлгөөнд нөлөөлсөн. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон төсвийн талаарх Засгийн газрын хүчин чармайлт нь өндөр орлоготой, их хэмжээний хүлэмжийн хий ялгаруулдаг улс орнуудын уур амьсгалын санхүүжилт хангалтгүй байсны улмаас буурсан. Мадагаскарт хүчтэй ган гачгийн улмаас хүмүүс газар нутгаа орхин дотооддоо нүүн шилжсээр байгаа боловч Засгийн газрын уур амьсгалын стратегид тэдгээр шилжин суурьшсан хүмүүсийн хэрэгцээг тодорхойлох үр дүнтэй үнэлгээ дутмаг байв. Намибийн ихэнх нутаг дэвсгэрт хүчтэй ган гачиг удаан хугацаанд үргэлжилж, ургац үйлдвэрлэл болон орон нутгийн амьжиргаанд ноцтой сөргөөр нөлөөлсөн. Эдгээр ноцтой нөхцөл байдлыг үл хайхран Намибийн эрх баригчид ойролцоогоор 1.4 сая хүнд зориулсан ган гачгийн үеийн тусламжийн хөтөлбөрийг зогсоосон.

Өмнөд Африкийн Квазулу-Натал болон Зүүн, Баруун Кейпын зарим хэсэгт болсон хүчтэй үерийн улмаас ялангуяа албан бус суурьшлын бүсэд олон хүн амиа алдаж, орон байр сүйдсэн. Харин Того улсын Ерөнхийлөгч уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг илүү сайн зохицуулах хуулийг батламжилсан нь эерэг алхам болсон.

Бүс нутгийн хэмжээнд байгаль орчны доройтол хурдацтай үргэлжилсээр байв. Конго улсын Засгийн газар Конкуати-Дули тусгай хамгаалалттай үндэсний цогцолбор газарт газрын тосны хайгуулын үйл ажиллагааг өргөжүүлэхийг зөвшөөрсөн бөгөөд энэ нь устаж үгүй болж байгаа биологийн олон янз байдал, мянга мянган оршин суугчдын амьжиргаанд заналхийлж байгааг сануулсан ТББ-уудын анхааруулгыг үл тоомсорлов. Замби улсын Коппербелт бүс нутгийн Чамбиши хотын 176 оршин суугч Сино-Метал Лийч уул уурхайн компанийн хаягдлын далан хоёрдугаар сард нурсны улмаас хорт хаягдал Мвамбаши болон Кафуе голд урсаж бохирдуулсан хэмээн үзэж компаний эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргасан. Харин тус компаний Хятадын толгой компани энэ нэхэмжлэлийг “илт үндэслэлгүй” гэж мэдэгдсэн. Дээрх нэхэмжлэлд энэхүү бохирдол нь загасчлалаар амьжиргаагаа залгуулдаг ойролцоогоор 300,000 өрхөд нөлөөлж байгааг тайлбарласан бол Засгийн газрын зүгээс ердөө 449 өрх нөлөөлөлд өртсөн хэмээн тооцжээ.

**Засгийн газрууд олон улсын тусламжийг эрэлхийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн ихээр нөлөөлсөн өндөр орлоготой орнуудаас уур амьсгалын санхүүжилтийг татан төвлөрүүлэх, шатамхай түлшний дэд бүтцийг байгуулахаас татгалзах зэргээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс иргэдээ хамгаалах, цаг агаарын онц аюулт үзэгдэлд бэлэн байдлаа нэмэгдүүлэх зорилгоор яаралтай арга хэмжээ авах шаардлагатай.**

## **ҮНЭНИЙГ МЭДЭХ, ШУДАРГА ЁСЫГ САХИУЛАХ, ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ ЭРХ**

Олон улсын эрх зүйн гэмт хэрэг болон хүний эрхийн ноцтой зөрчлийн хохирогчид, амьд үлдсэн хүмүүс үнэнийг мэдэх, шударга ёсыг сахиулах, хохирлоо барагдуулах эрхээ эдэлж чадахгүй хэвээр байв. 2000 оны 6 дугаар сард БНАКУ-ын Кисанганд болсон зургаан өдрийн дайны хохирогчид өнөөг хүртэл асуудлыг шударгаар шийдвэрлэхийг хүлээсээр байна. Эсватини улсад 2023 оны 1 дүгээр сард хүний эрхийн өмгөөлөгч Тулани Масекогийн амь насыг хөнөөсөн хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд ахиц гарсангүй.

Эрх баригчид шударга ёсыг шаардах, хариуцлага тооцох хүчин чармайлтыг сулруулсаар байв. 2024 онд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутгагдан ял шийтгүүлсэн Гвиней улсын төрийн тэргүүн асан Мусса Дадис Камараг 3 дугаар сард ерөнхийлөгчийн шийдвэрээр өршөөсөн нь 2009 оны Конакригийн цэнгэлдэх хүрээлэнд болсон аллага хядлагын хохирогчдын шударга ёсны хүртээмжийг ноцтойгоор алдагдуулах эрсдэлд хүргэсэн. Есдүгээр сард Буркина Фасо, Мали, Нигер зэрэг улс Олон улсын эрүүгийн шүүхээс гарахаар төлөвлөж байгаагаа мэдэгдсэн. Үүний зэрэгцээ Африкийн Холбооны дэмжлэгтэй Өмнөд Суданд байгуулах Хайбрид шүүхийг байгуулах үйл явц зогсонги байдалд орсон хэвээр байв.

Гэвч зарим зэрэг ахиц гарсан. Төв Африкийн Бүгд Найрамдах Улсын Тусгай эрүүгийн шүүх Төв Африкийн Бүгд Найрамдах Улсыг сэргээн босгох Ардын фронт (FPRC) зэвсэгт бүлэглэлийн зургаан гишүүнийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон. Гэвч тэдний дөрөв нь шүүх хуралдаанд ирээгүй байхад хэргийг шийдвэрлэсэн. Долдугаар сард Олон улсын эрүүгийн шүүх Анти-Балака бүлэглэлийн удирдагч асан Альфред Йекатом, Патрис-Эдуард Нгаиссона нарыг 2013–2014 онд Төв Африкийн Бүгд Найрамдах Улсад үйлдсэн дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутган 15 болон 12 жилийн хорих ял оноосон.

Есдүгээр сард Баримт тогтоох механизм Судантай холбоотой хоёр дахь тайлангаа нийтэлсэн. Үүний дараа 10 дугаар сард Африкийн Хүний болон Ард Түмний Эрхийн Комиссын Судан дахь нөхцөл байдлын талаар хамтарсан баримт тогтоох ажлын хэсгийн анхны тайлан нийтлэгдсэн. Мөн 10 дугаар сард Олон улсын эрүүгийн шүүхээс Жанжавийд зэвсэгт бүлэглэлийн гол удирдагчдын нэг болох Али Мухаммад Али Абд-аль-Рахманыг ("Али Кушайб") 2003 оны 8 дугаар сараас 2004 оны 3 дугаар сарын хооронд Дарфурт үйлдсэн дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутай гэж үзсэн. Мөн аравдугаар сард Африкийн Хүний болон Ард Түмний Эрхийн Комисс БНАКУ-ын Засгийн газрын цэргүүд 2011 онд Өмнөд Кивугийн Физи нутагт 50 гаруй эмэгтэйг хүчиндэж, бусад бэлгийн хүчирхийлэл үйлдсэн хэрэгт тус улсыг хариуцлага хүлээх ёстой хэмээн шийдвэрлэсэн.

**Засгийн газрууд үл завшихтай тэмцэх хүчин чармайлтаа эрчимжүүлж, олон улсын эрх зүйн гэмт хэрэг болон бусад хүний эрхийн ноцтой зөрчил, хүчирхийллийг шуурхай, иж бүрэн, хараат бус, шударга, үр дүнтэй, ил тод мөрдөн шалгах ажиллагаа явуулж, сэжигтнүүдийг шүүхэд шилжүүлж, хохирогчдод зөрчигдсөн эрхээ үр дүнтэй сэргээлгэх хүртээмжийг бүрэн хангах шаардлагатай.**

# АМЕРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Америкийн бүс нутгийн улс орнуудын засгийн газрууд эсэргүүцэл, шүүмжлэлийг нухчин дарах оролдлогоо эрчимжүүлсэн. Эсэргүүцлийн жагсаал цуглааныг хүчээр тарааж, оролцогчдод эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн. Сэтгүүлчдийн эсрэг халдлага гарч, хэвлэл мэдээллийг цензурдсэн.

Хүний эрх хамгаалагчид дарамт шахалт, халдлага, эрүүгийн хариуцлагад татагдах эрсдэлтэй хэвээр байв. Эрх баригчид санхүүжилтийг дур зоргоор хянах зэргээр тэдгээр байгууллагын үйл ажиллагаанд саад учруулсан.

Эрх баригчдын зүгээс хүчийг хууль бусаар ашигласан нь хүний эрхийн зөрчилд хүргэсэн.

Дур зоргоор саатуулах, цагдан хорих, шударга бусаар шүүх ажиллагаа үргэлжилсэн нь төрийн шийтгэх эрх мэдэл зохих хяналтгүй бөгөөд ихэвчлэн улс төрийн ашиг сонирхолд үйлчилж байгааг харуулсан.

Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг хүнлэг бус орчин нөхцөлд цагдан хорьсон. Ялангуяа улс төрийн дарамт, шахалт үзүүлэх зорилгоор эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцсан тухай мэдээллүүд байна.

Хүчээр алга болгох гэмт хэрэг бүс нутаг даяар үргэлжилсэн бөгөөд засгийн газрууд урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйгээс хариуцлага хүлээхгүй байх нь түгээмэл болсон.

Хүний эрхийн зөрчил, олон улсын эрх зүйн гэмт хэрэгт ял завших байдал хэвээр үргэлжилсэн хэдий ч шийдвэрлээгүй олон жил болсон зарим хэрэгт эерэг үр дүн гарсан.

Эдийн засаг, нийгмийн эрхийн баталгаа хангагдаагүй нь ялангуяа эдийн засаг, нийгмийн эмзэг бүлэгт ноцтой нөлөөлсөн. Иргэд боловсрол, эрүүл мэнд, цэвэр ус зэрэг суурь үйлчилгээ авахад хүндрэлтэй тулгарсан.

НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын оролцогч талуудын 30 дахь удаагийн бага хурал (COP30) Бразилд зохион байгуулагдсан ч хязгаарлагдмал үр дүнд хүрч, чулуужсан түлшнээс үе шаттай татгалзах амлалтыг шинэчилж чадсангүй. Улс орнууд уур амьсгалын хямралыг шийдвэрлэхэд хангалттай арга хэмжээ авч чадсангүй.

Жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа эмэгтэйчүүдийн амь насыг нь хөнөөх үйлдэл болон бэлгийн хүчирхийлэл улам бүр нэмэгдсэн хэдий ч хариуцлага хүлээлгэхгүй байдал түгээмэл хэвээр байв. Үр хөндүүлэх эрхийг хууль болон практикт хязгаарласан хэвээр байсан бөгөөд нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ хангалттай баталгаажуулаагүй байв.

Улс орнууд уугуул хүмүүсийн газар нутаг, нутаг дэвсгэр, байгалийн баялгийн эрхийг нь баталгаажуулж чадаагүй бөгөөд тэдэнд нөлөөлөх асуудлаар чөлөөтэй, урьдчилсан, мэдээлэлд үндэслэсэн зөвшилцлийн үйл явцыг бодитоор хангаж чадсангүй.

Засгийн газрын зохих хамгаалалт хангалтгүйн улмаас ЛГБТИ хүмүүс хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтад өртсөөр байв. Трансжендэр хүмүүсийн эрх онцгой эрсдэлд байсан бөгөөд зарим улс эрхийг нь хязгаарласан хууль, бодлого баталсан.

Бүс нутаг даяар арьс үндсээр ялгаварласан гадуурхалт, гаднынхныг үзэн ядах үзэл нэмэгдсэний улмаас цагаачид, дүрвэгсэд, орогнол хүсэгчид хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтад ихээхэн өртсөн. Олон хүн өөрсдийн эрхээ хэрэгжүүлэхэд саад бэрхшээлтэй тулгарсан.

# ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ, ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутаг даяар үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван хуран цуглах эрх зөрчигдсөний улмаас иргэний орон зай ихээхэн доройтсон.

2025 онд Аргентин, Канад, Чили, Куба, Эквадор, Сальвадор, Мексик, Парагвай, Пуэрто-Рико, АНУ, Венесуэл зэрэг улсад эсэргүүцлийн жагсаал цуглаанд хэт хязгаарлалт тогтоосон. Хэд хэдэн тохиолдолд эрх баригчид эсэргүүцлийн тайван жагсаалыг тараах, оролцогчдыг нухчин дарах зорилгоор хууль бусаар хүч хэрэглэсэн. Өмнөх жилүүдэд гарсан ижил төстэй хүний эрхийг зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцоогүй байдал 2025 онд ч үргэлжилсэн. Эсэргүүцлийн жагсаалын үеэр, эсхүл дараа нь оролцогчдыг дур зоргоор саатуулах, цагдан хорих, эрүүгийн журмаар мөрдөн шалгасан нь төрийн шийтгэх эрх мэдлийг үзэл бодлоо илэрхийлэх болон тайван хуран цуглах эрхийг хязгаарлахад ашиглаж байгааг тодорхой харуулж байна.

Бүс нутгийн хэд хэдэн улсад эвлэлдэн нэгдэх эрхийг хэт хязгаарлах зорилготой хууль тогтоомжийг шинэчлэх, шинээр батлах хандлага үргэлжилсэн. Эквадор, Эль Сальвадор, Парагвай, Перу болон Венесуэл улсад шинээр баталсан хууль иргэний нийгмийн байгууллагууд, тэр дундаа хэвлэл мэдээллийн байгууллагуудын оршин тогтнол болон үйл ажиллагаанд ноцтой нөлөөлөхөөр байв. Тухайлбал, Перу улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт нь байгууллагуудад дур зоргоор, хэт хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн.

Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг дарамт, цензур, халдлагын тохиолдлууд Аргентин, Бразил, Куба, Колумб, Сальвадор, Гватемал, Гондурас, Мексик, Парагвай, Перу, Уругвай, АНУ, Венесуэл улсад бүртгэгдсэн. Эдгээр халдлага нь сэтгүүлчдийн амь нас, бие махбодын аюулгүй байдалд заналхийлж, Колумб, Эквадор, Гондурас, Мексик болон Перуд сэтгүүлчдийн амийг хөнөөсөн тохиолдлууд бүртгэгдсэн. Түүнчлэн сэтгүүлчдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, шүүхээр дарамтлах зөрчил үргэлжилсэн хэвээр байв. Аргентинд Ерөнхийлөгч Жавир Милей хамгийн багадаа найман сэтгүүлчийг гүтгэлэг, доромжлолын хэргээр шүүхэд өгсөн бол Гватемал улсад сэтгүүлч Жоуэ Рубэн Замора-д холбогдох эрүүгийн хэргийг шүүхээр шийдвэрлэхэд олон тооны ноцтой зөрчил байсан хэдий ч шүүхээс түүнийг дахин хорих шийдвэр гаргасан.

Хууль бус дижитал тандалт, харилцаа холбоо, хувийн амьдралд хөндлөнгөөс халдах бусад хэлбэр нэмэгдсэн. Аргентин улсад Үндэсний аюулгүй байдлын яам холбооны цагдаа нарт шүүхийн зөвшөөрөлгүйгээр иргэдийг социал медиагаар хянах бүрэн эрхийг олгосон. Мексик биометрийн мэдээлэл агуулсан иргэний үнэмлэх бий болгох эрх зүйн шинэчлэлийг баталсан нь хувийн нууцад ноцтой эрсдэл учруулсан.

**Улс орнууд үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван хуран цуглах эрхийг хэрэгжүүлэхэд саад болж буй хууль болон практикийг хүчингүй болгож, төрийн үйл хэрэгт иргэний нийгмийн оролцоог бодитоор хангах шаардлагатай.**

## ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ

Бүс нутгийн бараг бүх улс оронд хүний эрх хамгаалагчид эрүүгийн хэрэгт татагдах, дарамт шахалт, халдлага, амь насаа алдах эрсдэлтэй тулгарсан.

Байгаль орчин болон газар нутгаа хамгаалагчид эрүүгийн хэрэгт татагдах, хүчирхийлэлд өртөх онцгой эрсдэлд байв. Болив улсад Тариксия үндэсний ургамал, амьтны нөөц газрыг хамгаалж байсан 12 хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн; Канад улсад Уэтсүвэтэн нутгийг хамгаалсан гурван уугуул иргэнийг нийгэмд тустай ажил хийх ялаар шийтгэсэн; Чили улсад хүний эрх хамгаалагч Мария Игнасиа Гонсалес сураггүй алга болсон; Перуд байгаль орчны хамгаалагч Хиполито Киспе Уаман Конде болон Исай Шук Шавит нар бусдын гарт амь насаа алдсан. 2025 онд Колумб улсад хүний эрх хамгаалагчдын эсрэг хүчирхийлэл өмнөх хоёр жилээс давах төлөвтэй байв.

Зарим улсад хүний эрхийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа явуулах чадварыг сулруулах оролдлого үргэлжилсэн. Тухайлбал, Сальвадорд Гадаадын агентын тухай хуулиар байгууллагуудын олон улсын санхүүжилтэд 30 хувийн татвар ногдуулж, мөн торгууль оногдуулах, эсвэл хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг цуцлах бүрэн эрхийг гүйцэтгэх засаглалд олгосон. Никарагуа улсын Дотоод хэргийн яам гуравдугаар сард журам гаргасан нь бодит байдалд байгууллагуудын эрх зүйн байдлыг дур зоргоор үгүйсгэх боломжийг бүрдүүлж, үйл ажиллагаагаа зогсоох эрсдэлийг нэмэгдүүлсэн.

Хүний эрх хамгаалагчид, байгууллагууд дарамтад өртсөөр байв. Тухайлбал, Доминиканы Бүгд Найрамдах Улсад арьс үндэсний шударга ёс, жендэр, цагаачлалын асуудлаар ажилладаг хүмүүс дижитал дарамт шахалтад өртсөн болон хувийн мэдээллийг нь ил болгосон тухай мэдээлсэн. Түүнчлэн Парагвай улсын парламентын комисс таван байгууллагын эсрэг шүүхийн маргаан өдүүлж тэдний үйл ажиллагаа болон санхүүжилтийн талаарх эмзэг мэдээллийг олж авахыг оролдсон.

**Улс орнууд хүний эрх хамгаалагчид үйл хэргээ саадгүй, аливаа хариу хонзогнолоос айх айдасгүйгээр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.**

## ХУУЛЬ БУСААР ХҮЧ ХЭРЭГЛЭХ

Бүс нутагт эрх баригчдын зүгээс шаардлагагүй тохиолдолд хүч хэтрүүлэн хэрэглэсэн хүний эрхийн зөрчил гаргасан нь ялангуяа жагсагчид болон олон төрлийн ялгаварлан гадуурхалтад өртсөн хүмүүст илүү их нөлөөлсөн.

Бразилын Рио Де Жанейро хотод явуулсан олон улсын хэм хэмжээг зөрчсөн цагдаагийн үйл ажиллагаанд олон мянган иргэний болон цэргийн алба хаагчдыг дайчлан оролцуулж, 120 гаруй хүний амь насыг хохироосон.

2025 онд АНУ-ын цагдаа нар 1,143 хүнийг буудан хөнөөсний дотор хар арьстнууд илүү ихээр өртсөн. Зургаадугаар сард Лос Анжелес хотод цагаачдыг байршуулсан холбооны барилгын ойролцоо болсон тайван эсэргүүцлийн жагсаалыг тараах зорилгоор орон нутгийн хууль сахиулах байгууллагууд хүний амь насанд аюулгүй эвэсгийг хууль бусаар ашиглаж, зургаан хүнийг гэмтээсэн. Карибын тэнгис болон Номхон далайн бүсэд хар тамхины худалдаатай тэмцэх ажиллагааны үеэр АНУ хамгийн багадаа 123 хүнийг хөнөөсөн. Эдгээр нь шүүхийн шийдвэргүйгээр хүний амь насыг хөнөөсөн хүний эрхийн зөрчил байж болзошгүй.

Гондурас улсад онц байдлын үеэр аюулгүй байдлын хүчнийхэн дур зоргоор саатуулах, цагдан хорих, хүч хэтрүүлэн хэрэглэх, эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах зэргээр хүний эрхийг зөрчсөн талаар иргэний нийгмийн байгууллагууд мэдээлсэн.

Перу улсад эсэргүүцлийн жагсаалын үеэр цагдаа нар шаардлагагүй тохиолдолд, хүч хэтрүүлэн хэрэглэсний улмаас жагсагч Эдуардо Маурисио Руис Санс буудуулж амиа алдсан бол олон арван хүн гэмтсэн.

**Улс орнууд олон улсын хүний эрхийн эрх зүй, хэм хэмжээ, ялангуяа ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд нийцүүлэн хүчийг хэрэглэх баталгааг хангах шаардлагатай.**

## ДУР ЗОРГООР СААТУУЛАН, ЦАГДАН ХОРИХ, ШУДАРГА БУСААР ШҮҮХ

Бүс нутгийн хэд хэдэн улсад ихэвчлэн засгийн газрыг эсэргүүцэгч хэмээн үзсэн хүмүүсийг улс төрийн шалтгаанаар дур зоргоор саатуулан цагдан хорьсон бөгөөд тэдгээрт холбогдох хэргийг шударга процессын баталгааг хангахгүйгээр шүүхээр шийдвэрлэсэн.

Куба улсын эрх баригчид эсэргүүцэгч, шүүмжлэгч гэгдэх хүмүүсийг нухчин дарах зорилгоор дур зоргоор саатуулж, цагдан хорьсон. Нэгдүгээр сард хамгийн багадаа 211 улс

төрийн хоригдлыг сулласан боловч эрх баригчид тэдний эрхийг дур зоргоор хязгаарлаж, заримынх нь улс төрийн активизм, хүний эрх хамгаалах үйл ажиллагааг үргэлжлүүлсний хариу арга хэмжээ болгон хугацаанаас нь өмнө суллах шийдвэрийг цуцалсан.

Сальвадорд хүмүүсийг дур зоргоор саатуулж, цагдан хорьсон хэвээр байсан бөгөөд оны эцсийн байдлаар 90,000 гаруй хүнийг хангалттай нотлох баримтгүйгээр цагдан хорьжээ. Хууль тогтоох байгууллага шүүхээс өмнөх цагдан хорих хугацааг хэт урт хугацаагаар сунгаж, хувь хүн тус бүрийн гэм буруутай эсэхийг тогтоохгүйгээр олноор нь шүүх боломжийг бүрдүүлсэн.

Никарагуад улс төрийн зорилгоор дур зоргоор саатуулж, цагдан хорих зөрчил үргэлжилсэн хэвээр байсан бөгөөд 2025 онд орон нутгийн хүний эрхийн байгууллагууд хамгийн багадаа 60 тохиолдлыг баримтжуулсан.

Венесуэлд улс төрийн зорилготой дур зоргоор саатуулах, цагдан хорих зөрчлүүд бүртгэгдсэн бөгөөд оны эцсийн байдлаар дор хаяж 806 хүн улс төрийн шалтгаанаар хоригдсон хэвээр байсан хэмээн иргэний нийгмийн байгууллагууд мэдээлсэн. Улсаас томилогдсон өмгөөлөгчид тэднийг хангалттай, үр дүнтэй төлөөлж чадаагүй, яллагдагчид өөрсдөд нь ямар хэрэг тулгасныг мэдэх эрхгүй байсны зэрэгцээ шүүхийн хараат бус байдал хангагдаагүй байв.

Боливи, Эквадор, Гватемал, Мексик, Парагвай, АНУ, Венесуэлд шүүхийн хараат бус байдлыг сулруулах үйл явц эрчимжсэн.

**Улс орнууд шүүх эрх мэдлийг шүүмжлэлт дуу хоолойг нухчин дарах хэрэгсэл болгон ашиглахаа зогсоож, дур зоргоор саатуулах, цагдан хорихоос хамгаалах, шударгаар шүүлгэх эрхийг хангахад шаардлагатай бүх арга хэмжээг авах ёстой.**

## СААТУУЛАГДСАН ХҮМҮҮСИЙН ЭРХ

Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг хүнлэг бус нөхцөлд саатуулж, цагдан хорьсон бөгөөд саатуулах байрны ачаалал хэтэрсэн нь тогтолцооны шинжтэй, давтамжтай тулгардаг асуудал хэвээр байв.

Болив улсын хорих, саатуулах байрны багтаамж ойролцоогоор 16,000 хүн боловч 33,000 гаруй хүн хоригдож, хорих ангийн ачаалал туйлдаа хүрсэн болохыг Омбудсмэний газраас анхааруулсан. Эквадор, Сальвадор улсад эрх чөлөөгөө хасуулсан хүмүүс хэт олноор хоригдож, хоол хүнс, эрүүл мэндийн үйлчилгээний ноцтой дутагдалд өртөж, мөн хүчирхийллийн улмаас амь насаа алдсаар байна. Гаитид насанд хүрээгүй хүмүүсийг саатуулах, цагдан хорих тогтолцоонд хэт ачаалал үүсэж, урьдчилан саатуулах газарт хүүхдүүдийг насанд хүрэгчидтэй хамт байрлуулсан тохиолдол бүртгэгдсэн. Уругвайд саатуулах байрнуудын ачаалал хэтэрч, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангахгүй байдал үргэлжилсээр байв.

Чили, Куба, Сальвадор, Гондурас, Мексик, Никарагуа, АНУ, Венесуэл зэрэг хэд хэдэн улсад саатуулах, цагдан хорих газарт эрүүдэн шүүж байгааг эрх чөлөөгөө хасуулсан хүмүүс болон тэдний эрхийг хамгаалагчид мэдээлсэн.

Сальвадорд хорих газруудад эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг зодох, бэлгийн хүчирхийлэл үзүүлэх, удаан хугацаанд унтуулахгүй байх, хамтын шийтгэл ногдуулах зэргээр эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах зөрчил үргэлжилсээр байв. Түүнчлэн онц байдал зарласнаас хойш саатуулах, хорих газруудад нас барсан хүмүүсийн тоо 470-д хүрсэн.

Куба, Никарагуа, Венесуэл улсад засгийн газрыг эсэргүүцэж, шүүмжилсэн гэгдэх хүмүүс эрүү шүүлт, бусад зүй бусаар харьцах зөрчилд өртөх өндөр эрсдэлтэй хэвээр байв. Никарагуа улс эрүүдэн шүүхийг хориглосон Үндсэн хуулийн 36 дугаар зүйлийг хүчингүй болгосон.

**Улс орнууд эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн эрх, нэр төрийг баталгаажуулах ёстой.**

## ХҮЧЭЭР АЛГА БОЛГОХ

Бүс нутгийн хэмжээнд хүчээр алга болгох зөрчил үргэлжилсэн бөгөөд хариуцлага шийтгэлгүй үлдэх нь нийтлэг байв. Зарим улсад энэ нь эсэргүүцэл, шүүмжлэлийг нухчин дарах зорилготой байсан бол бусад улсад аюулгүй байдлын бодлого хэрэгжүүлэх үр дагавартай холбогдсон.

Кубад хүчээр алга болгох ажиллагааг хүний эрх хамгаалагчид, идэвхтнүүд, уран бүтээлчид болон сэтгүүлчдийн эсрэг дарамт шахалтын хэрэгсэл болгон ашигласан. Никарагуад улс төрийн зорилгоор саатуулагдсан хэд хэдэн хүний хаана байгааг нь нууцалж, уулзалт хийхийг хориглосон нь хүчээр алга болгох нөхцөл байдалд хүргэсэн. Венесуэлд хүчээр алга болгох практик үргэлжилсэн бөгөөд ихэвчлэн төрийн албан хаагчдын дур зоргоор саатуулах ажиллагаагаар эхэлж улмаар тухайн хүний талаар мэдээлэл өгөхөөс татгалзах, саатуулж, цагдан хорьсноо хүлээн зөвшөөрөхгүй байх, цаашлаад тухайн хүн хаана, ямар байдалтай байгаа талаарх мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан.

Эквадор 2024 онд зэвсэгт хүчний явуулсан аюулгүй байдлын ажиллагааны дараа 43 хүнийг хүчээр алга болгосон байж болзошгүй хэрэгт Ерөнхий прокурорын газар мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлсэн. Сальвадор АНУ-аас хууль бусаар албадан гаргаж, 3 дугаар сард Терроризмтой тэмцэх хорих төвд шилжүүлсэн цагаачид, орогнол хүсэгчдийн хэсэг бүлэг хүмүүс хүчээр алга болгох нөхцөл байдалд өртсөн.

Колумб улсад зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотойгоор 1-5 дугаар сарын хооронд хүчээр алга болгох 136 тохиолдол шинээр бүртгэгдсэний 26 нь хүүхэд, өсвөр насныхан байсныг Олон улсын Улаан загалмайн нийгэмлэг баримтжуулсан.

Мексикт нүүрлэсэн хүчээр алга болгох хямралтай холбогдуулан НҮБ-ын Хүчээр алга болгохтой тэмцэх хороо Хүчээр алга болгохоос бүх хүмүүсийг хамгаалах тухай конвенцын 34 дүгээр зүйлийг анх удаа хэрэгжүүлж, тус улсад хүчээр алга болгох хүний эрхийн зөрчил системтэй, өргөн тархсан эсэхийг тодорхойлох ажиллагааг эхлүүлсэн.

**Улс орнууд хүчээр алга болгох үйлдлийг бүрэн таслан зогсоож, төрийн бус этгээдүүдийн үйлдсэн хүчээр алга болгох үйлдлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бүх арга хэмжээг авах үүрэгтэй.**

## ҮНЭНИЙГ МЭДЭХ, ШУДАРГА ЁС, ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ ЭРХ

Хүний эрхийн ноцтой зөрчлийн хэргүүдийг шүүхээр шийдвэрлэсэн. Чили улсад 2019 онд тайван жагсаалд оролцож байсан Моисес Ордонес руу халдсан хэрэгт Карабинерос (цагдаагийн хүчин)-ын гурван алба хаагчийг гэм буруутайд тооцсон. Колумбид Энх тайвны тусгай шүүхээс дайны болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт холбогдох анхны ял шийтгэл оногдуулсан. Мексикийн шүүх 2023 онд таван залууг хууль зөрчиж, шүүхийн шийдвэргүйгээр хөнөөсөн хэрэгт дөрвөн цэргийн алба хаагчид ял оноосон. Уругвайд 1970–1980-аад оны иргэний-цэргийн дэглэмийн үед үйлдэгдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт холбогдуулан цэрэг, цагдаагийн 15 алба хаагчид ял оногдуулсан.

Аргентинд 1994 онд Аргентин болон Израилын Хамтарсан Холбооны төвийн эсрэг халдлагад сэжиглэгдсэн 10 хүнд холбогдох хэргийг тэдний эзгүйд шүүхээр шийдвэрлэхийг зөвшөөрсөн. Гватемал улсад олон жилийн турш оргон зайлсан сэжигтнийг баривчилж, 1998 онд хамба лам Хуан Хосе Герардигийн амийг хөнөөсөн хэрэгт оролцсон байж болзошгүй үндэслэлээр шүүхэд шилжүүлсэн. Гондурас 2024 онд байгаль хамгаалагч Хуан Лопесийг хөнөөсөн хэрэгт сэжиглэгдсэн гурван хүний гэм бурууг шүүхээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Мөн зарим хэргийг шийдвэрлэх ажиллагаанд ухралт гарсан. Болив улсад 2019 онд гарсан хэд хэдэн аллагай холбоотойгоор цагдаа, цэргийн алба хаагчдад холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон. Чилид 2019 оны нийгмийн эсэргүүцлийн үеэр үйлдэгдсэн хүний эрхийн зөрчилтэй холбоотой 1,509 хэргийг үргэлжлүүлэн шалгахгүй

байх шийдвэрийг Улсын прокурорын газар гаргасан. Колумб улсад цэрэг, цагдаагийн алба хаагчдын үйлдсэн байж болзошгүй хүний эрхийн зөрчил болон олон улсын эрх зүйн гэмт хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагаанд иргэний болон цэргийн шүүхийн харьяаллын маргаан үргэлжилсэн. Гватемалд Молина Тайссений хэрэгт холбогдон хүний эрхийн ноцтой зөрчил үйлдсэн нь тогтоогдсон цэргийн алба хаагчдыг гэрийн хорионд байлгах шүүхийн шийдвэр нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээг зөрчсөн. Перу улсад 1980-2000 оны хооронд үйлдэгдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцогдох ноцтой хүний эрхийн зөрчилтэй холбоотойгоор мөрдөн шалгагдсан, яллагдсан, шүүгдсэн болон ял шийтгүүлсэн зэвсэгт хүчин, үндэсний цагдаа болон өөрийгөө хамгаалах хорооны бүх гишүүдэд өршөөл үзүүлэх хуулийг баталсан.

Венесуэлтэй холбоотой Олон улсын эрүүгийн шүүхийн мөрдөн шалгах ажиллагаанд хангалттай ахиц гараагүй бөгөөд 12 дугаар сард тус байгууллагын Прокурорын газар Каракас дахь оффисоо хаах шийдвэр гаргасан.

**Улс орнууд хүний эрхийн зөрчил болон олон улсын эрх зүйн гэмт хэрэгт өртсөн хүмүүсийн үнэнийг мэдэх, шударга ёсыг тогтоолгох, хохирлоо барагдуулах эрхийг хангаж, гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй этгээдэд хуулийн дагуу, шударга шүүхээр хариуцлага оногдуулах шаардлагатай.**

## ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХ

Бүс нутгийн улс орнууд эдийн засаг, нийгмийн эрхийг хангаж чадаагүй бөгөөд ялангуяа нийгэм, эдийн засгийн эмзэг бүлгүүд илүү ихээр өртсөн.

Эрүүл мэндийн эрхийг бүх хүн эдлэх баталгааг хангаж чадсангүй. Жилийн эхэнд АНУ гадаад тусламжаа гэнэт зогсоосон нь Гватемал, Гаити улсад эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжид сөргөөр нөлөөлсөн. Кубын эрх баригчид 7 дугаар сард шаардлагатай нэн чухал эмийн нөөц ердөө 30 хувь байгааг хүлээн зөвшөөрсөн. Парагвайд эрүүл мэндийн тогтолцооны хямрал үргэлжилж, төсвийн хөрөнгө оруулалт ДЭМБ-аас зөвлөдөг ДНБ-ий 6%-ийн доод түвшинд хүрээгүй хэвээр байв. Уругвайд сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй, амиа хорлолт санаа зовнин түвшинд хүрч нэмэгдсэн.

Сурч боловсрох эрх төсвийн таналт, хүчирхийллийн улмаас ноцтой зөрчигдсөн. Эль Сальвадорд оны эхний саруудад улсын боловсролын тогтолцоон дахь сурагчдын хамрагдалт 25,000-аар буурсан. Гаити улсад хүчирхийлэл нь сурч боловсрох боломжийг хязгаарласан.

Аргентинд тэтгэвэрийн доод хэмжээ нь амьжиргааны наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байсан бөгөөд 3 сая гаруй ахмад настан ядуу амьдарч байв.

Нийгмийн суурь үйлчилгээ авахад тулгарч буй саад бэрхшээлүүд үргэлжилсээр байв. Куба улсад цахилгаан эрчим хүчний хангамж жилийн турш хямралд орж, нийтийг хамарсан цахилгааны тасалдал нь олон сая хүнд нөлөөлсөн. Гватемалд цэвэр ус, зохистой ариун цэврийн үйлчилгээний хүртээмжийн тэгш бус байдал гүнзгийрсэн. Гаитид хүмүүнлэгийн хямрал үргэлжилж, эрүүл мэндийн үйлчилгээ авах, хоол хүнс, ундны усаар хангагдах зэрэг үндсэн эрхэд ноцтой нөлөөлсөн. Венесуэлд ус, цахилгааны тасалдал үргэлжилж, суурь үйлчилгээтэй холбоотой эсэргүүцлийн жагсаалууд болсон.

**Улс орнууд нь хүн бүр аливаа ялгаварлан гадурхалтаас ангид байж, эдийн засаг, нийгмийн эрхийг тэгш эдлэх нөхцөлийг хангах үүрэгтэй.**

## ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

2025 оны 11 дүгээр сард Бразил улсад зохион байгуулагдсан COP30 нь хамрах хүрээний хувьд хязгаарлагдмал байсан бөгөөд чулуужсан түлшнээс үе шаттайгаар татгалзах амлалтыг дахин баталгаажуулж чадсангүй. Түүнчлэн өндөр орлоготой улс орнууд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход шаардлагатай татааст суурилсан санхүүжилтийг нэмэгдүүлэх талаар тодорхой амлалтад хүрч чадсангүй.

COP30-оос өмнө ч бүс нутгийн улс орнууд уур амьсгалын хямралыг

шийдвэрлэхэд хангалттай арга хэмжээ авч чадаагүй бөгөөд энэ нь 2025 оны турш хүний эрхэд сөргөөр нөлөөлсөөр байв. Аргентин болон АНУ зэрэг зарим улсын эрх баригчид уур амьсгалын хямралыг үгүйсгэсэн хэвээр байв.

Аргентины уур амьсгалын зорилт, бодлого хангалтгүй хэвээр байв. Канад улс нефтийн болон чулуужсан түлшний төслүүдэд татаас, санхүүжилт, татварын хөнгөлөлт үзүүлсээр байв. Эквадорт 2021 оны шүүхийн шийдвэрээр хий шатаах төхөөрөмжийг зогсоохыг үүрэг болгосон хэдий ч Амазоны бүс нутагт хий шатаах үйл ажиллагааг үргэлжлүүлэн зөвшөөрсөн. АНУ-д гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас гаргасан захирамжаар эрчим хүчний үндэсний онц байдал зарлаж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг үл харгалзан нүүрсний олборлох үйлдвэрлэлийг дахин идэвхжүүлэх зорилт дэвшүүлсэн. Гондурас улсад уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх ажил удааширсан.

Боливид уур амьсгалын өөрчлөлт нь ойгүйжилт, түймэр, хур тунадасны алдагдлыг улам дордуулж, усны хомсдолыг нэмэгдүүлэн, цэвэр ус, хүнсний аюулгүй байдлын эрхэд сөргөөр нөлөөлсөн. Бразилд усны хомсдол, хур тунадасны хомсдол, хөрсний гулсалт, шуурга, үер, хэт халалт, ган зэрэг нь эмзэг бүлгийн хүн ам, ялангуяа хар арьст, уугуул хүмүүс болон бага орлоготой иргэдэд илүү ихээр нөлөөлсөн. Парагвай улсад уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ган, үер, агаарын температурын өсөлт зэрэг үзэгдлүүд нэмэгдсэн.

**Эрх баригчид орон нутгийн болон бүс нутгийн түвшинд бодитой арга хэмжээ авах замаар уур амьсгалын хямралын хүний эрхэд үзүүлэх нөлөөг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах шаардлагатай.**

## БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ

Чилид үр хөндөлтийн үйлчилгээний хүртээмжтэй байдлыг цаг тухайд нь хангах шинэ журам батлагдсан. Мексикийн дөрвөн муж үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохгүй байх хуулийг баталсан. Гэвч эдгээр тодорхой ахиц дэвшлүүдийн зэрэгцээ Аргентин, Бразил, Колумб, Доминиканы Бүгд Найрамдах Улс, Эквадор, Сальвадор, Гватемал, Гаити, Гондурас, Перу, Пуэрто Рико, АНУ, Венесуэл зэрэг улсад үр хөндүүлэх хууль эрх зүйн болон практик саад бэрхшээлүүд хэвээр байв.

АНУ-ын Холбооны засгийн газар нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байсан бодлогуудыг цуцалж, тухайлсан байгууллага болон хөтөлбөрүүдийн санхүүжилтийг бууруулсан. Пуэрто Рикод 16 нас хүрээгүй охид үр хөндөлтийн үйлчилгээ авахад эцэг эх эсхүл хууль ёсны асран хамгаалагчийн бичгээр өгсөн зөвшөөрөл шаардах хууль батлагдсан. Доминиканы Бүгд Найрамдах Улсад шинээр батлагдсан Эрүүгийн хуулиар үр хөндөлтийг бүх нөхцөлд бүрэн хориглосон. Сальвадор, Гаити, Гондурас болон Никарагуа улсад үр хөндөлтийг бүх нөхцөлд гэмт хэрэгт тооцсон хэвээр байв.

Охид, өсвөр насныхны жирэмслэлт байсаар байгаа хэдий ч засгийн газрууд уг асуудлыг шийдвэрлэх дорвитой арга хэмжээ авсангүй. Аргентинд өсвөр насныхны жирэмслэлтийн түвшинг өмнөх дөрвөн жилийн хугацаанд 49%-иар бууруулсан албан ёсны хөтөлбөрийг зогсоосон. Перу улсад 992 охины жирэмслэлтийг үргэлжлүүлэн тээж төрүүлэхийг албадсан.

**Эрх баригчид аюулгүй үр хөндөлт болон бэлгийн, нөхөн үржихүйн бусад эрхийн хүртээмжтэй байдлыг хангах үүрэгтэй.**

## ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Охид, эмэгтэйчүүдийг хүчирхийлэх, эмэгтэйчүүдийн амь насыг хохироох гэмт хэрэг Аргентин, Боливи, Бразил, Чили, Колумб, Куба, Гондурас, Мексик, Парагвай, Перу, Пуэрто Рико болон Уругвай улсуудад бүртгэгдсэн. Зарим улсад энэ төрлийн гэмт хэргийн статистик мэдээлэл хангалтгүй, найдвартай бус хэвээр байв.

Куба улсад эмэгтэйчүүдийг алах үйлдлийг өнөөг хүртэл бие даасан гэмт хэрэг

гэж үздэггүй хэвээр байна. Пуэрто Рико улсын Давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийн энэ төрлийн гэмт хэрэгтэй холбоотой заалтыг шударга процессын хэм хэмжээ, гэм буруугүйд тооцох зарчмыг зөрчсөн үндэслэлээр Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзэж хүчингүй болгосон.

Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бусад хэлбэрүүд, тухайлбал бэлгийн хүчирхийллийн тохиолдлууд Аргентин, Боливи, Чили, Куба, Доминиканы Бүгд Найрамдах Улс, Мексик, Перу, АНУ, Уругвай зэрэг бусад улс орнуудад бүртгэгдсэн. Доминиканы Бүгд Найрамдах Улсын шинээр баталсан Эрүүгийн хуулиар хамтран амьдрагчийнх нь үйлдсэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг олон улсын хэм хэмжээнд нийцээгүй, ухралт болсон гэмт хэргийн ангилалд оруулсан.

Тайлангийн жилд зарим ахиц дэвшил гарсан. Тухайлбал, Боливи улсад 1639 дүгээр хууль хүчин төгөлдөр болж, 18 нас хүрээгүй хүүхэдтэй гэрлэхийг хориглосон. Мөн Колумб улсад нэгдүгээр сард батлагдсан хуулиар гэрлэгч талуудын аль нэг нь хүсэлт гаргасан бол гэрлэлтийг цуцлах эрх зүйн боломжийг бүрдүүлсэн.

**Улс орнууд жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох чиглэлээр үр нөлөөтэй арга хэмжээ авч, охид, эмэгтэйчүүдийг аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байж, эрх, эрх чөлөөгөө бүрэн эдлэх нөхцөлийг хангах үүрэгтэй.**

## УУГУУЛ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Уугуул хүмүүс ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл болон уур амьсгалын хямралын сөрөг нөлөөлөлд өртсөөр байсан хэдий ч улс орнууд тэдний эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлсэнгүй. Боливи, Канад, Эквадор уугуул хүмүүсийн амьдрах газар нутагт олборлох үйлдвэрлэлийн төслүүд өргөжин тэлсээр байсан бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэхдээ чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэйгээр зөвшөөрөл авах олон улсын хэм хэмжээнд нийцсэн зөвлөлдөх журмыг баримтлаагүй.

Америк хоорондын Хүний эрхийн шүүх Эквадор улсад холбогдох хэргийг хэлэлцээд Амазоны бүс нутгийн уугуул ард түмний хамтын өмчийн эрхийг зөрчиж тэдний нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгосон нь хууль зөрчсөн хэмээн шийдвэрлэсэн.

Канад улсад хэд хэдэн хуулийн төсөл уугуул хүмүүсийн өөртөө засан тохинох эрхэд заналхийлж, ялангуяа томоохон дэд бүтцийн төслүүдийг түргэвчилсэн журмаар батлах замаар тэдний оролцоог хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн.

Бразил улсад газар нутгаа эргүүлэн авах тэмцэл, маргаантай холбоотойгоор уугуул бүлгүүдийн удирдагчид, гишүүд амь насаа алдсан ноцтой зөрчил гарсан. Ава Гуарани Паранаэнсе угсаатны бүлэг Итайпу Бинасьональ усан цахилгаан станцын барилгын улмаас өөрсдийн өвөг дээдсийнхээ нутаг дэвсгэрээс нүүхэд хүрсэн бөгөөд Бразил болон Парагвай улс газар нутгийг нь буцаан олгохыг хүлээсээр байна.

Колумб улсад уугуул хүмүүс болон Африк гаралтай хүмүүс олон удаагийн, өргөн цар хүрээтэй албадан нүүлгэн шилжүүлэлт, тусгаарлал, шилжин суурьших эрхийн хязгаарлалтад харьцангуй ихээр өртсөн.

Венесуэл улсад Йеквана угсаатны уугуул иргэд тэдний нутаг дэвсгэр болох Амазонас мужид хууль бус олборлох үйл ажиллагаанаас үүдэн үүсээд байгаа зөрчил, мөргөлдөөний талаар мэдээлсэн.

**Улс орнууд уугуул хүмүүсийн өөрсдийн газар нутаг, байгалийн баялгийг эзэмших, өмчлөх, хяналтаа тогтоох эрхийг хүндэтгэж, хамгаалах үүрэгтэй.**

## ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

ЛГБТИ хүмүүс бүс нутаг даяар гэмт хэрэгт өртсөөр байсан бөгөөд тэдний эсрэг гутаан доромжилж гадуурхсан үг хэллэг, ялангуяа трансжендэр хүмүүсийн эсрэг дайсагнасан хандлага эрс нэмэгдсэн. Орон нутгийн байгууллагуудын мэдээлснээр, жилийн эцсийн байдлаар Гватемал улсад хамгийн багадаа 29, Гондурас улсад 35 ЛГБТИ хүн амь насаа

алдсан бол Мексик улсад 17 трансжендэр эмэгтэйчүүдийн амь насыг нь хохироосон хэрэг бүртгэгдсэн. Ихэнх улсын засгийн газар энэ төрлийн гэмт хэргийн талаарх баттай статистик мэдээлэлгүй байв. Канад, Парагвай, Перу, Пуэрто Рико болон АНУ зэрэг улсад трансжендэр хүмүүсийн эрхийг хязгаарласан хууль, бодлого хэрэгжүүлсэн.

Хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт нь олон төрлийн ялгаварлан гадуурхалтад өртсөн бүлгүүдэд илүү ноцтой нөлөөлсөн. Бразил улсад хар арьст ЛГБТИ хүмүүсийн эсрэг арьс үндсээр ялгаварлан гадуурхсан хүчирхийллийн тохиолдлууд бүртгэгдсэн. АНУ-д трансжендэр өсвөр насныханд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг хязгаарласан хууль батлагдсан. Парагвай улсад хоёр трансжендэр цагаач өөрсдийн хүйсийн баримжаандаа нийцсэн бичиг баримт авч чадаагүй.

Эрх баригчид энэ төрлийн хүчирхийллийг таслан зогсоох зохистой арга хэмжээ авч хэрэгжүүлж чадсангүй. Зарим улсад хохирогчдод үзүүлэх үйлчилгээг сулруулж, зогсоосон. Тухайлбал, АНУ-ын Холбооны засгийн газар амиа хорлохоос урьдчилан сэргийлэх үндэсний шуурхай тусламжийн утасны ЛГБТИ өсвөр үеийнхэнд зориулсан нэгэн сонголтыг цуцалсан.

**Улс орнууд ЛГБТИ хүмүүсийн, ялангуяа трансжендэр хүмүүсийн эрхийг хүлээн зөвшөөрч, тэднийг аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс хамгаалах шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.**

## **ДҮРВЭГСЭД, ЦАГААЧДЫН ЭРХ**

Бүс нутгийн хэмжээнд дүрвэгсэд, цагаачид болон орогнол хүсэгчдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт ноцтой түвшинд хүрсэн. Тэдний нөхцөл байдал нь улс орнууд, ялангуяа АНУ-ын бодлого, үг хэллэгийн нөлөөгөөр улам төвөгтэй болж тив даяарх цагаачлалын урсгалд нөлөөлсөн. Хойд зүгт чиглэсэн хууль бус шилжилт хөдөлгөөний урсгал эрс буурч, харин өмнөд зүг рүү чиглэсэн урсгал нэмэгдсэн болохыг Колумб, Коста Рика, Панама улс орнуудын эрх баригчид онцлон тэмдэглэсэн.

Хэд хэдэн улсын эрх баригчид ялгаварлан гадуурхах, дайсагнасан болон гутаан доромжлох үг хэллэгийг улам бүр түгээн дэлгэрүүлсэн. Чили болон АНУ-д сонгуулийн үеэр арьс үндэс, гарал үүсэлтэй холбоотой үзэл суртал эрс эрчимжсэн.

Түүнчлэн АНУ-д арьс үндсээр ялгаварлах болон цагаач иргэдийн эсрэг хөтөлбөрийг идэвхжүүлсэн. Нүүрээ халхалсан ажилтнууд цагаачлалын эрх зүйн байдлыг нь үл харгалзан хүмүүсийг саатуулж, хуягласан машинууд сургууль, шашны төв, эмнэлэг зэрэг өмнө нь цагаачлалын хяналтаас хамгаалагдсан бусад бүсэд чиглэсэн арга хэмжээг идэвхжүүлсэн.

Доминиканы Бүгд Найрамдах Улсад цагаачлалын хяналт нь цагаачдыг саатуулах төвүүдэд арьс үндсээр ялгаварлан гадуурхах, дур зоргоор саатуулах, цагдан хорих, хүч хэтрүүлэн хэрэглэх, харгис, хүнлэг бусаар харьцах, олон улсын эрх зүйг зөрчиж олноор нь албадан гаргах ажиллагааг явуулсан. Түүнчлэн, эмнэлгүүдийн эрүүл мэндийн протоколын дагуу шаардлагатай баримт бичиггүй иргэдийг эмчилгээ хийсний дараа албадан гаргах, эх орон руу нь буцаах арга хэмжээ авсан нь ялангуяа Гаити улсын иргэд болон Гаити гаралтай хүмүүст илүү сөргөөр нөлөөлсөн.

Улс орнууд цагаач, дүрвэгсэдэд тэдний эрхийг хангалттай, ялгаварлалгүйгээр эдлүүлэх үүргээ биелүүлж чадаагүй бөгөөд олон тохиолдолд эрхийг нь улам хязгаарласан. Канад улсад Түр хугацааны Гадаад ажилчны хөтөлбөр цагаачдыг ажил олгогчтой шууд холбож байсан нь өргөн хүрээнд ашиг сонирхлын зөрчил, хөдөлмөрийн мөлжлөг болон ялгаварлан гадуурхалтын эрсдэлийг нэмэгдүүлсэн. Түүнчлэн бусад хязгаарлалтууд нь цагаачдын нөхцөл байдлыг улам эмзэг болгосон. Чили улсын Конгресс зарим тохиолдолд дүрвэгсэд, цагаачдыг эрүүгийн гэмт хэрэгт татах санал бүхий хэд хэдэн хуулийн төслийг хэлэлцсэн. Колумб, Мексик улсад орогнол олгох үр дүнтэй систем хомс хэвээр байв.

**Улс орнууд арьс үндсээр ялгаварлан гадуурхах болон гадаадын иргэдийг үзэн ядах үзлийг таслан зогсоож, дүрвэгсэд, орогнол хүсэгч, цагаачдыг хамгаалах, тэдний бүх эрхийг бүрэн эдлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.**

# АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Бүс нутаг даяар дарангуйлал, системт ялгаварлан гадуурхалт болон хариуцлага үл хүлээх байдал нь хэлмэгдүүлэлт, тэгш бус байдал, ял шийтгэл завшихыг улам өдөөв. Эрх баригчид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх болон тайван хуран цуглах эрхэд тогтоох хязгаарлалтыг улам бүр нэмэгдүүлж, хууль тогтоомж, цагдаагийн үйл ажиллагаа болон цахим тандалтаар дамжуулан хяналтыг гүнзгийрүүлэв. Эдгээр арга хэмжээнүүд харилцан бие биенээ бэхжүүлснээр иргэний орон зайг хумьж, үндсэн эрх чөлөөг дордуулав. Балба болон Индонезид олон хүнийг үхэлд хүргэсэн нухчин дарах ажиллагаа явуулж, Энэтхэгт терроризмтой тэмцэх хуулиудыг ашиглаж, Мьянмарт арван хоёрдугаар сард цэргийн дэглэмийн хүчээр явуулсан санал хураалтын өмнө олон хүнийг дур зоргоор хорьж, мөн Хонконгод идэвхтнүүдийг баривчлах зэргээр эсэргүүцэл, шүүмжлэлийг хүчээр дарангуйлах нь хэвийн үзэгдэл боллоо.

Олон улсын түвшинд хариуцлага тооцох хүчин чармайлтад зарим амжилт гарлаа. Тухайлбал, Филиппиний ерөнхийлөгч асан Родриго Дутертег баривчлан Олон улсын эрүүгийн шүүхэд шилжүүлж, Талибаны хоёр удирдагчийн үйлдсэн жендэрийн ялгаварлан хавчих хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт нь Олон улсын эрүүгийн шүүхээс баривчлах шийдвэр гаргасан. Гэвч ял шийтгэл завших нь өргөн хүрээтэй хэвээр үлдэж, Рохинжа хүмүүсийн эсрэг үйлдсэн олон улсын гэмт хэрэгт холбогдох албан тушаалтнуудыг Олон улсын эрүүгийн шүүхээс баривчлах шийдвэр гаргахад ахиц гараагүйн зэрэгцээ БНХАУ-ын Шиньжян дахь хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг шийдвэрлэх талаар төрөөс бодитой арга хэмжээ авсангүй. Афганистанд дотоодын хариуцлага тооцох механизм үндсэндээ үгүй болж, Шри Ланкад дайны үеийн зөрчлүүдийг шийдвэрлэх үйл ажиллагаа ихэнхдээ үр нөлөөгүй хэвээр байв.

Улс орнууд хил дамнасан дарамт шахалтыг өргөжүүлэв. Тайланд улс эрх нь зөрчигдөх эрсдэлийг үл хайхран Уйгаруудыг Хятад руу албадан буцаасан бол Монтаньярд хүний эрх хамгаалагчдыг Вьетнамд хүлээлгэн өгсөн. Малайз улс Тайландын эрх баригчидтай хамтран нэгэн сэтгүүлчийг онилсон бол Хонконг болон Хятад гадаадад байгаа идэвхтнүүдийг мөрдөн мөшгөхдөө хууль ашиглаж, Хонконгт үлдсэн гэр бүл, найз нөхдийг нь дарамталсан.

Ялгаварлан гадуурхалт нь нийгмийн гадуурхагдсан эмзэг бүлгүүдэд учрах хор уршгийг улам нэмэгдүүлэв. Рохинжа хүмүүс Мьянмарт албадан хөдөлмөр эрхэлж, Бангладеш дахь дүрвэгсдийн хуаранд хүмүүнлэгийн тусламж буурснаас үүдсэн эрсдэлд илүү ихээр өртөв. Шашны цөөнхүүдийг Афганистан, эх газрын Хятад болон Пакистанд системтэйгээр онилсон бол, Австрали болон Индонез дахь Уугуул хүмүүс газар нутгаасаа салах үр дагаврыг үргэлжлүүлэн амссаар байв. Өмнөд Ази даяарх далитууд аюултай хүнд хөдөлмөрт өртсөөр байна.

Жендэрт суурилсан хүчирхийлэл бүс нутаг даяар үргэлжилж, технологи ашиглан үйлдсэн хүчирхийлэл Өмнөд Солонгос, Тайланд болон Вьетнамд олны анхаарлыг татав.

Зүүн Өмнөд Азид хүний наймаа болон албадан хөдөлмөр огцом нэмэгдэж, Камбож болон Мьянмар зэрэг гэмт хэргийн гаралтын түвшин өндөр улс орнуудад залилангийн бүлэглэлүүд хүмүүсийг боолчлон, эрүүдэн шүүж байв.

Уур амьсгалын хямрал, бусад гамшигт өртөмтгий байдал, түүнчлэн эдийн

засгийн эмзэг байдал нь хүний эрхийг хасах, хязгаарлах явдлыг эрчимжүүлэв. Афганистан улсад Иран болон Пакистанаас албадан гаргагдсан, түүнчлэн газар хөдлөлтөд өртсөн олон сая хүн тусламжид найдаж байсан бол, Индонез, Пакистан, Шри Ланка, Вьетнам болон Филиппинд болсон үерийн улмаас олон зуун хүн нас барж, өргөн хүрээний шилжилт хөдөлгөөнийг үүсгэж, ургац алдаж, ядуурал улам гүнзгийрэв. Бангладеш, Кирибати, Пакистан болон Тувалу дахь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн гамшиг нь олон хүн шилжин суурьшихад хүргэж, эцэстээ бүтцийн тэгш бус байдалд хүргэв. Хойд Солонгосын суурь хэрэгцээний ноцтой хомсдол болон Шри Ланкын хэмнэлтээс үүдэлтэй халамжийн хэт таналтын эдийн засгийн бодлого нь эмзэг байдлыг хэрхэн нэмэгдүүлж байгааг бодитоор харууллаа.

## ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутгийн улс орнуудын засгийн газрууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарласан хууль, практикийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хүний эрх хамгаалагчид, сэтгүүлчид, идэвхтнүүд болон эрдэмтэн судлаачдын эсрэг цензур, тандалт, өс хонзонгийн арга хэмжээ авсаар байв. Хэд хэдэн улсад онлайн агуулгыг хянах, эсэргүүцлийг нухчин дарах өргөн хүрээний эрх мэдэл олгосон хуулиудыг шинээр баталж, эсхүл хэвээр хадгалсан. Фижи улсын засгийн газар олон нийтийн дэг журмын хязгаарлалт бүхий хуулиудыг шинэчлэх талаарх НҮБ-ын шаардлагыг хүлээн авахаас татгалзав. Мьянмар улсын Кибер аюулгүй байдлын тухай хуулийн тодорхой бус заалтуудаар эсэргүүцлийг гэмт хэрэгт тооцсон бөгөөд Сонгуулийн тухай хуулиар сонгуулийн үйл явцын үеэрх хүчирхийлэлд бүх насаар нь хорих, цаазаар авах хүртэлх хатуу шийтгэл оногдуулахаар хуульчилсан. Балбад Нийгмийн сүлжээний тухай хуулийн төслийг өргөн барьж, гүйцэтгэх засаглалд шүүхийн хяналтгүйгээр цахим агуулгыг устгах, мэдээлэлд нэвтрэх боломж олгосны зэрэгцээ “худал мэдээлэл” болон троллингийг эрүүгийн гэмт хэрэгт тооцохоор тусгав. Пакистаны эрх баригчид Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр цахимаар үзэл бодлоо илэрхийлэхийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох, цензур тавих эрх мэдлийг улам өргөжүүлэв. Шри Ланк улсын эрх баригчид Терроризмтой тэмцэх тухай хатуу чанга хуулийг үргэлжлүүлэн ашиглав. Энэтхэгт Махараштрагийн Олон нийтийн аюулгүй байдлын тухай тусгай хууль батлагдаж, эсэргүүцлийг гэмт хэрэгт тооцов. Малайзын эрх баригчид Мультимедиа, харилцаа холбооны тухай хууль зэрэг хуулиудыг ашиглан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласаар байв. Монгол улсад иргэний орон зайг хумихад Эрүүгийн хуулийг ашиглав. Камбожийн эрх баригчид иргэний харьяаллыг хүчингүй болгох аргыг шүүмжлэгчдийг шийтгэхдээ ашигласан бол Мальдивт сэтгүүлчдийн үйл ажиллагаанд өргөн хүрээний хяналт тавих эрх мэдэл олгох, шийтгэл давамгайлсан шинжтэй хэвлэл мэдээллийн хуулийн төсөл боловсруулав. Харин Вьетнам улсад Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, цагдаа нарт интернет хэрэглэгчдийн интернэт протокол (IP) хаягийг шаардах бүрэн эрхийг олгож, интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдэд 24 цагийн дотор агуулга устгах үүрэг хүлээлгэсний зэрэгцээ сэтгүүлчдийг эх сурвалжаа илчлэхийг шаардсан Хэвлэл мэдээллийн тухай хуулийн төсөл боловсруулсан нь хувийн нууц болон цахим тандалтад санаа зовнил төрүүлэв.

Засгийн газрууд эсэргүүцлийг намжаахын тулд дижитал орон зайг улам бүр онилж байв. Сингапурын эрх баригчид Онлайн худал мэдээлэл, манипуляцаас хамгаалах тухай хуулийг ашиглан идэвхтнүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд болон сөрөг хүчний төлөөлөгчдийн эсрэг олон удаагийн шийдвэр гаргав. Хятад болон Хонконгийн эрх баригчид үндэсний аюулгүй байдлын хуулиудыг өргөжүүлж, бүр тайван үйл ажиллагааг онилов. Хонконгийн хууль тогтоогчид үндэсний аюулгүй байдлын хуулийг боловсролын салбарт өргөжүүлж үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан бол санал өгөхөөс татгалзахыг уриалсан үйлдлийг шүүхээс гэмт хэрэгт тооцсон хуулиудыг хүчинтэй хэвээр үлдээв. Балбад эрх баригчид Telegram

болон нийгмийн сүлжээний бусад 26 платформыг хаасан бол, Пакистанд засгийн газрыг шүүмжилсэн YouTube сувгууд болон социал медиа хаягуудыг хориглов. Энэтхэгт эрх баригчид Х болон Instagram-д мянга мянган хаягийг хаахыг тушааж, элэглэл хошигнолыг хязгаарлан, Жамму ба Кашмирт 25 номыг хориглов. Хойд Солонгосын эрх баригчид бүрэн хяналтаа хэвээр хадгалж, өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрийг саатуулан, айлуудыг шалгаж, гадаадын хэвлэл мэдээллийг түгээсэн тохиолдолд цаазаар авах ял зэрэг хатуу шийтгэл оногдуулсаар байв.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ хэрэгжүүлснийх нь төлөө зүй бусаар хариу арга хэмжээ авах нь өргөн тархав. Афганистанд Талибан сэтгүүлчдийг баривчилж, Назим Радио-г хааж, эмэгтэйчүүдийн бичсэн ном болон Талибанчуудын бодлогыг шүүмжилсэн яруу найраг зэрэг бүтээлийг их сургуулиудад хориглон, интернэтэд холбогдох боломжийг тасалсан. Хятадад сэтгүүлч Жанг Жан хоёр дахь удаагаа хорих ял авч, Хонконгт ардчиллыг дэмжигч Жошуа Вонг үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу дахин өөр төрлийн хэрэгт татагдав.

Энэтхэгт сэтгүүлчдийг дарамтлах үйлдэл цагдаагийн бүртгэл үүсгэх, баривчлах зэрэг арга замаар эрчимжиж, эрдэмтэн Ниташа Каулын иргэн байх эрхийг цуцлав.

Камбожид сэтгүүлчид болон идэвхтнүүдийг баривчилж, урт хугацааны ял шийтгэл хүлээлгэв. Малайз улс Тайландын эрх баригчидтай хамтран нэгэн зохиолчийг баривчилж, Монгол улсад цагдаа нар хараат бус хэвлэл мэдээллийн байгууллагад нэгжлэг хийв. Тайландад иргэний болон цэргийн харилцааны сэдвээр судалгааны ажил хийснийх нь төлөө нэгэн эрдэмтэнд ял оногдуулав. Вьетнамд газрын эрхийн төлөө идэвхтэнд “засгийн газрыг эсэргүүцсэн” хэргээр 21 жилийн хорих ял оногдуулав.

**Засгийн газрууд дарангуйллын хуулиудыг хүчингүй болгох эсвэл өөрчлөх, зохицуулалтын агуулгад үр нөлөөтэй шүүхийн хяналтыг тогтоож, сэтгүүлчид болон идэвхтнүүдийг дарамт, хүчирхийллээс хамгаалах ёстой.**

## ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ, ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Засгийн газрууд дарамт шахалт үзүүлэх, урьдчилан саатуулах, хязгаарлалт бүхий хууль эрх зүйг ашиглах зэргээр тайван жагсаал, цуглаан хийх эрхийг ноцтой хязгаарлав. Жилийн турш эсэргүүцлийн жагсаал, цуглааныг хүч хэрэглэн нухчин тараах тохиолдлууд гарсаар байв. Афганистан улсад Талибаны хүчнийхэн Бадахшан бүс нутагт намуу цэцэг (опиумын ургамал) тариалалтыг зогсоохын эсрэг жагсаалын үеэр дор хаяж 10 хүнийг буудан хөнөөж, 40 хүнийг шархдуулсан. Индонезид үндэсний хэмжээнд өрнөсөн жагсаалын үеэр жагсагчдыг олноор нь баривчилж, 4,000 хүнийг саатуулж, 900 хүнийг хүчирхийлж, дор хаяж 10 хүн амь үрэгдсэн. Балбад авлигын эсрэг болон социал медиа хоригийг эсэргүүцсэн залуучуудын удирдсан “Gen-Z” жагсаалын үеэр жагсагчид болон цагдаа нар нийт 76 хүн амиа алдсан. Пакистаны эрх баригчид Балучистан болон Пакистаны хяналтад байдаг Жамму, Кашмир зэрэг бүс нутагт жагсагчдын эсрэг үхэлд хүргэх хүч хэрэглэж, интернэтийн сүлжээг тасалдуулав. Малайзын эрх баригчид эсэргүүцэл шүүмжлэлийг дарах зорилгоор цагдаагийн хүчиг ихээр ашиглаж, баривчилгаа явуулав. Филиппин улсад авлигын эсрэг жагсаалд оролцсон хэдэн зуун хүнийг, түүний дотор ихэвчлэн залуучуудыг баривчлав. Хонконгийн эрх баригчид жагсаал цуглаан зохион байгуулахыг хориглож, жагсаалд оролцохоор төлөвлөж байсан хүмүүсийг баривчилж, Бахархлын жагсаал цуглааныг цуцалсан. Хо Ши Мин хотод ийм жагсаалыг 13 жилийн хугацаанд анх удаа цуцалсан бөгөөд бусад арга хэмжээнүүдийг орон нутгийн эрх баригчдын дарамт шахалтын улмаас хяналт тавьж, эсхүл цуцлав.

Албадан саатуулах, зөвшөөрөл олгохоос татгалзах, хууль зүйн арга хэмжээ авах нь бүс нутаг даяар түгээмэл байв. Энэтхэгийн эрх баригчид жагсаал, цуглаанд зөвшөөрөл олгохоос татгалзсаны дараа Жамиагийн оюутнууд, сөрөг хүчний удирдагчид болох Рахул Ганди зэрэг улс төрчид, түүнчлэн нийтийн үйлчилгээний цэвэрлэгээний ажилтнуудыг баривчлан саатуулав. Мальдивт элчин сайдын яамдын

гадна тайван жагсаал, цуглаан хийсэн эмэгтэйчүүдийг баривчилсан. Өмнөд Солонгосын шүүх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн төлөө тэмцэгчдийг тайван жагсаал, цуглаанд оролцсоных нь төлөө яллав. Сингапур, Энэтхэгт эрх баригчид жагсаал, цуглааныг хууль бус гэж зарлахын тулд эрх, эрх чөлөөг хязгаарласан хууль тогтоомжийг үргэлжлүүлэн ашигласаар байна.

Хязгаарлалтын цар хүрээ нь тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхийн хяналтыг улам гүнзгийрүүлэв. Тайваний эрх баригчид зарим бүсэд дур зоргын хязгаарлалт тогтоосон бол Хонконгт шинэ “хориглосон бүсүүд” бий болгож, зөвхөн эсэргүүцлийн жагсаал төдийгүй зөвшөөрөлгүйгээр тухайн бүсэд байхыг хязгаарласан. Малайз улсад Тайван жагсаал, цуглааны тухай хуулийг шинэчлэх санал гарсан хэдий ч цагдаагийн хатуу хяналт, дарамт, баривчилгаа, мөрдөн шалгалт үргэлжилсэн хэвээр байв. Харин Өмнөд Солонгосын шүүхүүд жагсаал, цуглааны хязгаарлалтыг тодорхой хэмжээгээр сулруулав. Түүнчлэн, иргэний нийгэм болон улс төрийн байгууллагуудад тавих хяналт нэмэгдсэн. Шри-Ланкад төрийн бус байгууллагуудыг Батлан хамгаалах яаманд бүртгүүлэх шаардлага тавьсан хэвээр байгаа бөгөөд иргэний нийгмийн үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгасан. Бангладешид Авами Лиг намыг терроризмын эсрэг хуулийг үндэслэн хориглож, улс төрийн эвлэлдэн нэгдэх болон оролцооны эрхийг ноцтойгоор алдагдуулав.

**Засгийн газрууд дарамт шахалтаа зогсоож, тайван цуглаанд оролцсоны төлөө саатуулагдсан хүмүүсийг суллаж, хязгаарлалт бүхий, эсвэл дарангуйлагч хуулиудыг хүчингүй болгох, эсхүл өөрчлөх, мөн олон улсын хэм хэмжээнд нийцсэн аюулгүй, хүртээмжтэй хуран цуглах орчныг баталгаажуулах шаардлагатай.**

## ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Ялгаварлан гадуурхалт нь шашин шүтлэг, үндэс угсаа, гарал үүсэл, хөгжлийн бэрхшээл болон уугуул иргэдийн эсрэг зэрэг олон хэлбэрээр үргэлжилсэн хэвээр бөгөөд ихэвчлэн төрийн бодлого, тогтолцооны тэгш бус байдал, нийгмийн дайсгалт хандлагаар улам бэхжив.

Төрийн дэмжлэгтэй шашны ялгаварлан гадуурхалт өргөн тархсан хэвээр байв. Афганистанд Талибаны эрх баригчид Шийтийн цөөнхийг онилон, Исмаил урсгалыг Суннит Исламд хүчээр оруулах, Шиит-Хазара шашны зан үйлийг хязгаарлах, хүмүүнлэгийн тусламжийн хуваарилалтад ялгаварлан гадуурхах зэрэг арга хэмжээг авав. Мөн Хазара гэр бүлүүдийг албадан нүүлгэн шилжүүлж, мөн тэд хөдөлмөр эрхлэлтийн ялгаварлан гадуурхалтад өртөв. Пакистан улсад төрийн байгууллагууд болон хувь оролцогчдын зүгээс Ахмади шашинтнуудын эсрэг хүчирхийлэл, хязгаарлалт нэмэгдсэн бөгөөд хувь оролцогчдын христийн шашинтнуудын эсрэг 2023 онд үйлдсэн халдлагад хариуцлага тооцох нь хангалтгүй хэвээр байв. Энэтхэгт өөр шашинтнуудын гэрлэлтийг ялгаварлан гадуурхсан хуулиар гэмт хэрэгт тооцсон бөгөөд хувийн болон төрийн оролцогчдын үйлдсэн Мусульман болон Кашмир иргэдийн эсрэг үзэн ядалтын гэмт хэргүүдийг баримтжуулав. Индонезид Ахмадия болон Христийн шашинтнуудын үзэн ядах хандлага үргэлжилж, мөргөлийн газруудад хязгаарлалт тавих, халдлага үйлдэх тохиолдол гарав. Хятадын засгийн газар Төвдийн буддын шашны асуудалд хөндлөнгөөс оролцож, христийн шашны удирдагчдыг саатуулсан бол Фижигийн зарим хэсэгт хиндү сүмүүдийг эвдэн сүйтгэв.

Үндэс угсаагаар ялгаварлан гадуурхах нь хэд хэдэн улсад газар авав. Япон улсад сонгуулийн кампанит ажлын үеэр гадаадын иргэдийг үзэн ядах агуулгатай уриа, хэллэг гарсан бол Өмнөд Солонгост хятадуудын эсрэг жагсаал цуглаан өрнөв. Мьянмарын хойд Ракхайн мужид Аракан арми нь дотооддоо дүрвэн суурьшсан Рохинжа хүмүүсээр албадан хөдөлмөр эрхлүүлж, татгалзсан хүмүүстэй зүй бусаар харьцсан тухай мэдээлэл бүртгэгдсэн.

Уугуул иргэдийн эсрэг ноцтой бөгөөд тогтолцооны шинжтэй ялгаварлан гадуурхалт байсаар байв. Хятадад Уйгар болон Төвөд иргэдийн соёл, хэл, шашны илэрхийлэлд тавих хязгаарлалт зэрэг тогтолцооны шинжтэй ялгаварлан гадуурхалтад

өртсөн хэвээр байв. Австралид Уугуул болон Торресын хоолойн арлын хүмүүс тэгш бус байдалд өртсөн хэвээр байгаа бөгөөд тэдний хоригдлуудын дунд эзлэх хувь хэмжээ өндөр бөгөөд хорих газарт нас барах тохиолдол нэмэгдсэн. Энэтхэг улсад байгаль орчны хамгаалалт суларч, уугуул иргэдийг нутаг орноос нь шахан зайлуулах эрсдэл нэмэгдсэн. Индонезид томоохон дэд бүтцийн төслүүд болон никелийн уул уурхай нь уугуул иргэдийн газар нутгийг сүйтгэж, эсэргүүцлийн хөдөлгөөнийг улам өдөөсний зэрэгцээ эсэргүүцлийн хөдөлгөөний идэвхтнүүдэд эрүүгийн ял шийтгэл оногдуулсан. Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенцын Хороо Японы засгийн газарт хандан Окинавад АНУ-ын цэргийн бааз байгуулах төслийн нөлөөллийн талаар анхааруулсан бол уугуул иргэдийн удирдагчид гадаадад хэрэгжүүлж байгаа Японы санхүүжилттэй төслүүдийг эсэргүүцэн жагсав. Малайзын засгийн газар Оранг Асли уугуул иргэдийн эрхийг өргөжүүлэх боломжит хуулийн өөрчлөлтийн талаар хэлэлцсэн бол Балбад хөгжлийн төслийн ил тод байдал хангалтгүйн улмаас байгалийн болон соёлын дурсгалт газрын талаар хүчирхийлэл мөргөлдөөн гарсан. Бангладешийн эрх баригчид 2024 онд баривчлагдсан 100 уугуул Бавм хүмүүсийн 62 гаруйг саатуулсан хэвээр байгаа бөгөөд хорих газарт нас барсан тохиолдол бүртгэгдсэн. Шинэ Зеландын парламент Маори иргэдийн уламжлалт эрхийг сулруулсан хууль баталсан. Тайваньд Пингпу уугуул иргэдийн соёлын эрхийн хамгаалалт хязгаарлагдмал бөгөөд хууль зүйн хувьд хангалттай хүлээн зөвшөөрөгдсөнгүй. Ялангуяа, боловсролын салбарт тогтолцооны ялгаварлан гадуурхалт үргэлжилсээр байв. Тайланд улс уугуул иргэдийн амьжиргаанд заналхийлэх төслүүдийг үргэлжлүүлж, уугуул иргэдийн эрх зүйн байдлыг хүлээн зөвшөөрөхгүй байх хуулийн төслийг баталсан. Угсаа гарвалд суурилсан ялгаварлан гадуурхалт гадуурхагдсан бүлгүүдэд нөлөөлсөөр байв. Энэтхэгт кастын бүртгэл хийх төлөвлөгөө гацаж, тогтолцооны тэгш бус байдал шийдвэрлэгдээгүй хэвээр үлдэв. Балбад Далит овгийн бүлгүүд өргөн хүрээний нийгмийн ялгаварлан гадуурхалт, шударга ёсны саадтай тулгарсаар байв. Пакистанд каст болон шашин шүтлэгт суурилсан ялгаварлан гадуурхалт нь нийтийн үйлчилгээний цэвэрлэгээний ажилтнууд (тэдгээрийн ихэнх нь Далит христийн шашинтнууд)-ын аюулгүй байдлыг эрсдэлд оруулж, хууль зүйн хамгаалалтгүй ажлын байранд үргэлжлүүлэн ажиллахад хүргэв.

Хөгжлийн бэрхшээлд суурилсан ялгаварлан гадуурхалт өргөн тархсан хэвээр байв. Хойд Солонгост хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн салбарт тогтолцооны шинжтэй ялгаварлан гадуурхалтад өртөж, албадан асрамжийн байгууллагад байрлуулсан тохиолдол бүртгэгдсэн. Тайваньд Ялгаварлан гадуурхалтын эсрэг иж бүрэн хууль хараахан батлагдаагүй тул хамгаалалт нь хэсэгчилсэн, сул хэвээр байв. Японд албадан үргүйдүүлэлтийн хохирогчдод нөхөн олговор олгох хууль батлагдсан нь ахиц байсан ч тогтолцооны саад бэрхшээл, мэдээллийн хомс байдал нь шударга ёсыг хангахад саад болсоор байв.

**Засгийн газрууд уугуул иргэдийн газар нутгийг хамгаалах, ялгаварлан гадуурхсан үг хэллэгээс зайлсхийх, зүй бус хэвшмэл ойлголттой тэмцэх, үр дүнтэй ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль батлан хэрэгжүүлэх, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн тэгш боломжоор хангах, шударга ёсны тогтолцоог баталгаажуулах үүрэгтэй.**

## ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

Эдийн засгийн хямрал, уур амьсгалын гэнэтийн нөлөө болон ялгаварлан гадуурхсан бодлогоос үүдэн эдийн засаг, нийгэм, соёлын эрх ноцтой хязгаарлагдсан хөвдөр байна. Хүнсний аюулгүй байдал ноцтой хэмжээнд хүрэв. Афганистанд 22.9 сая хүн албадан нутаг буцаалт (ихэвчлэн Иран болон Пакистанаас), газар хөдлөлт, санхүүжилтийн хомсдол зэрэг нөхцөл байдлын улмаас тусламжид найдан амь зогоож байгаа бөгөөд хүүхдүүдийн 90 % нь хоол хүнсний ядууралд, 4 сая хүн хоол тэжээлийн дутагдалд нэрвэгджээ. Хойд Солонгост цаг уурын нөхцөл хүнсний үйлдвэрлэлд тааламжтай байсан хэдий ч бордооны хомсдол, уур амьсгалын гэнэтийн

нөлөөллийн улмаас ургац алдаж иргэд хүнсний ноцтой хомсдолд өртсөн бөгөөд төрийн хуваарилалтын алдаа нь хөдөө нутгийн иргэдийн хүндрэл бэрхшээлийг улам гүнзгийрүүлэв. Пакистанд хүн амын 44.7% нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа бөгөөд ОУВС-ийн хязгаарлалтын улмаас төсвийн зардал улам буурч, хүний үйл ажиллагаагаар нөхцөлдсөн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн үерийн улмаас үндсэн ургацаа алдав. Шри Ланкад нийгмийн халамжийн тэтгэмж олгож байгаа хэдий ч ядуурлын түвшин хямралын өмнөх түвшнээс өндөр хэвээр байв.

Эрүүл мэндийн тогтолцоо хэврэг хэвээр байв. Афганистан улсад хөдөө нутгийн эрүүл мэндийн хүртээмж хязгаарлагдмал байсан бол газар хөдлөлтийн үед эмэгтэйчүүдийг аврах ажиллагаанд Талибанын хязгаарлалт саад болов. Хойд Солонгосын эмнэлгүүд анхан шатны эм, тоног төхөөрөмж дутмаг, нөөцийн ноцтой дутагдалтай байв. НҮБ-ын Хүүхдийн Сангаас 2 сая хүүхдийг дархлаажуулсан хэдий ч мониторинг тавих боломж хязгаарлагдмал байлаа.

Сурч боловсрох эрх улам доройтсоор байв. Талибаны хоригийн улмаас Афганистанд охид, эмэгтэйчүүдийн 78% нь сургуульд сурах, ажил эрхлэх боломжгүй болов. Хойд Солонгосын сургуулиудад халаалт, сурах бичиг дутагдалтай байсан бол Мьянмарт тусламжийн санхүүжилт зогссоны дараа сургалтын үйл ажиллагаа ноцтой хэмжээнд саатсан. Хятад улсаас Төвдөд хэрэгжүүлж байгаа хос хэлний боловсролын бодлого нь цөөнхийн хэлний эрхэд ноцтой заналхийлж байна.

Орон байр, газрын аюулгүй байдал алдагдсан хэвээр байв. Камбожид олон улсын хүчтэй эсэргүүцлийн дараа эрх баригчид Ангор дах ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн дурсгалт газарт явагдаж байсан албадан нүүлгэлтийг зогсоосон боловч нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн гэр бүлүүдийн зөрчигдсэн эрхийг сэргээх арга хэмжээг санал болгоогүй. Монгол Улсад хөгжлийн төслүүдийн нөлөөлөлд өртсөн хот болон хөдөөгийн иргэдтэй зөвлөлдөх үйл явц хангалтгүй байгааг болон өмч хөрөнгийг бодит үнээс доогуур үнэлэх асуудлыг шийдвэрлэх механизм дутмаг байв. Энэтхэгийн Ассам мужид өрнөсөн нүүлгэн шилжүүлэлтийн улмаас ойролцоогоор 3,800 өрх орон гэрээсээ дүрвэсэн бөгөөд энэ нь мусульман иргэдэд харьцангуй ихээр нөлөөлсөн.

Хөдөлмөрлөх эрхийн өргөн тархсан зөрчил, хүчирхийлэл нь нийгмийн ялгаварлагдсан, гадуурхагдсан бүлгүүдэд илүү ихээр нөлөөлөв. Пакистанд доод кастын нийтийн үйлчилгээний цэвэрлэгээний ажилтнууд тогтолцоот ялгаварлан гадуурхалтад өртөв. Шри Ланкад Малайя Тамилчууд ялгаварлагдсан хэвээр байсан бол хувцас, оёдлын үйлдвэрийн салбарын ажилтнууд үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааны дарамт шахалт, жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөөр байв. Бангладеш улсад оёдлын үйлдвэрт үймээн гарч, үйлдвэрчний эвлэлийн удирдагчдыг баривчлав. Филиппин улсад гамшгийн үеэр ажиллах ажилчдын аюулгүй байдал хангагдаагүй бол, Хонгконгод гэрийн үйлчлэгчээр ажилладаг цагаач ажилтнуудын эрхийг хангалттай хамгаалж чадсангүй.

**Засгийн газрууд хүчээр нүүлгэн шилжүүлэхийг зогсоох, ядуурлыг бууруулах, нийгмийн хамгаалалтыг сайжруулах, ажилтнуудыг хамгаалах, үндсэн үйлчилгээний хүртээмжийг ялгаварлалгүйгээр хангах замаар хүнсний, эрүүл мэндийн, орон байраар хангагдах, боловсролын болон хөдөлмөрийн эрхийг баталгаажуулах шаардлагатай.**

## **ДҮР ЗОРГООР БАРИВЧЛАХ, ЗРҮҮДЭН ШҮҮХ, ХҮЧЭЭР АЛГА БОЛГОХ БОЛОН ЦАГДАН ХОРИХ ГАЗАРТ НАС БАРАХ**

Эрх баригчид эсэргүүцэл, шүүмжлэлийг дарах зорилгоор аюулгүй байдлын хууль тогтоомж болон ялгаварлан гадуурхсан практикийг үргэлжлүүлэн ашиглаж, хүний эрхийн идэвхтнүүд, цөөнхийн бүлгүүд болон улс төрийн өрсөлдөгчдийг илүү ихээр онилж байв. Дур зоргоор баривчлах, саатуулах, цагдан хорих явдал өргөн тархсан

хэвээр байлаа. Афганистан улсад Талибанчууд үсний засалт, хөгжим тоглох зэрэг ялимгүй үйлдлийг зөрчилд тооцож хүмүүсийг саатуулж, “ёс суртахууны хяналтын байцаагчид”-аар дамжуулан хатуу журам мөрдүүлж байв. Түүнчлэн төрийн албан хаагч байсан хүмүүс, сэтгүүлчид, хүний эрх хамгаалагчид болон шүүмжлэгчдийг дур зоргоор баривчлах, саатуулах, хүчээр алга болгох, эрүүдэн шүүх зэргээр онилсоор байв. Шүүхээс гадуур хүнийг хөнөөсөн 100 гаруй тохиолдлыг баримтжуулав.

Мьянмарт төрийн эргэлтийн дараах системт баривчилгаа үргэлжилж, эрүүл мэндийн тусламжийг зориуд үзүүлээгүй, эсхүл хүч хэрэглэсэн байцаалтын улмаас цагдан хоригдож байх үедээ нас барах тохиолдлууд бүртгэгдсэн. Хойд Солонгост дур зоргоор саатуулах, цагдан хорих нь төрийн хяналтыг хадгалах гол хэрэгсэл хэвээр байж, улс төрийн гэмт хэрэгт буруутгагдсан хүмүүсийг шударга шүүхээр шүүлгэх эрхгүйгээр онилон хорьж байв. Хонконг болон Макаод үндэсний аюулгүй байдлын тухай хуулиудыг өргөн хүрээнд хэрэглэн улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг дарангуйлах, хүний эрхийн идэвхтнүүдийг баривчлах зорилгоор ашиглав.

Пакистанд терроризмын эсрэг хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хүмүүсийг ял шийтгэл оногдуулахгүйгээр гурван сар хүртэл хугацаагаар цагдан хорих, саатуулах боломжийг олгосон бөгөөд сэтгүүлчид болон Балуч идэвхтнүүдийг баривчлав. Энэтхэгт терроризмтой тэмцэх хуулийг урвуулан ашиглаж хүний эрхийн хамгаалагчид болон мусульман идэвхтнүүдийг шүүхээс өмнөх шатанд урт хугацаагаар цагдан хорив.

Эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах үйлдлийг хуулиар хориглосон хэдий ч өргөн хүрээнд үргэлжилсэн хэвээр байв. Афганистанд хоригдлуудыг цахилгаанаар цохиулах, усанд живүүлэх, шүд болон хумсыг нь сугалж авах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх зэргээр эрүүдэн шүүсэн бол Мьянмарт байцаалтын үеэр зодох, цахилгаанаар цохиулах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх, хумс сугалах зэрэг аргыг хэрэглэсэн. Хойд Солонгост “хэрэг хүлээлгэх” зорилгоор зодох, нойргүйдүүлэх, албадан хөдөлмөр хийлгэх зэрэг арга хэрэглэж, улс төрийн хорих лагерьт зохистой хоол хүнсгүйгээр хатуу шийтгэл ногдуулсаар байв. Вьетнамд идэвхтнүүдийг ганцаарчлан хорих, дөнгөлөх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхээс татгалзах зэргээр зүй бус харьцсаны зэрэгцээ цагдан хорих үед сэжигтэй байдлаар нас барсан тохиолдлууд бүртгэгдсэн. Энэтхэгийн Жамму ба Кашмир зэрэг бүс нутагт цагдаа нарын үйлдсэн эрүү шүүлтийн улмаас 25 настай нэгэн залуу нас барсан. Шри Ланкад цагдан хорих үед нас барсан хамгийн багадаа 13 тохиолдол бүртгэгдэж, эрүүдэн шүүсэн талаарх гомдол гарсан. Тайландын шүүх цэргийн алба хаагчийг хөнөөсөн хэрэгт эрүүдэн шүүхийн эсрэг хуулийг хэрэглэж анхны ял шийтгэл оногдуулсан нь хариуцлага тооцох ховор алхам болсон.

Хүчээр алга болгох нь дарангуйллын хэрэгсэл хэвээр байлаа. Хойд Солонгост хоригдлуудын талаар гэр бүлд нь мэдээлэл өгөхөөс татгалздаг нь хүчээр алга болгохтой ижил нөхцөл байдлыг бий болгодог. Хятадын эрх баригчид “Тодорхойлсон байршилд оршин суух хяналт” хэмээх нууц саатуулах хэлбэрийг үргэлжлүүлэн ашиглаж байгаа нь хүний эрхийн хамгаалагчид болон хуульчдыг хүчээр алга болгохтой адил үр дагаварт хүргэсэн. Малайзын шүүх өнгөрсөн хугацаанд өрнөсөн хүчээр алга болгох тохиолдлууд төрийн оролцоотой байсныг тогтоосон бол Мьянмарт эрүү шүүлтийн дараа хүчээр алга болгох, нас барах зэрэг тохиолдол давтагдав. Пакистанд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хүчээр алга болгох 125 шинэ тохиолдол бүртгэгдсэн. Бангладешийн Засгийн газрын байгуулсан Хүчээр алга болгох асуудлыг шалгах комиссын мэдээлснээр 2009–2024 оны хооронд 1,772 гомдол бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийн 67 хувь нь төрийн байгууллагуудтай холбоотой байжээ. Энэ байдал эмзэг бүлгийн хүмүүст чиглэсэн ялгаварлан гадуурхалтыг нэмэгдүүлж, ял шийтгэл завших боломжийг улам бүр гүнзгийрүүлж байна.

**Засгийн газрууд дур зоргоор баривчлах, эрүүдэн шүүх, хүчээр алга болгох явдлыг зогсоож, саатуулагдсан хүмүүсийн эрхийг хамгаалан, хүчирхийллийн эсрэг хариуцлага тооцох болон хамгаалалтын баталгааг хангах ёстой.**

# ДҮРВЭГСЭД, ШИЛЖИН СУУРЬШИГЧДЫН ЭРХ БА ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

Засгийн газруудын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын бодлого улам чангарч байгаа нь дүрвэгсдийн хамгаалалт, шилжин суурьшигчдын эрхийг сулруулж, эмзэг бүлгийн хүмүүсийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртөх эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна. Олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүргийг үл хайхран, хүмүүсийг олноор нь албадан нутаг буцаах, албадан шилжүүлэх үйлдэл үргэлжилсээр байна. Пакистанд “Хууль бус гадаадын иргэдийг нутаг буцаах төлөвлөгөө” эрчимжиж 990,000 афган иргэнийг буцаасан. Иран улс 1.8 сая афган иргэнийг нутаг буцаасан бол Герман, Тажикстан, Турк улс Талибаны хүчирхийллийг үл харгалзан афган иргэдийг албадан нутаг буцаасаар байв. Афганистан руу буцаасан охид, эмэгтэйчүүд тогтолцооны шинжтэй хүний эрхийн хязгаарлалтад өртөж, засгийн газрыг шүүмжлэгчид баривчлагдах, эрүү шүүлтэд өртөх эрсдэлтэй тулгарав. Тайлангийн жилийн турш Бангладеш дахь Рохинжа дүрвэгсэд зэвсэгт бүлэглэлүүд тэднийг Мьянмар руу хүчээр буцаан аваачиж, мөргөлдөөнд татан оролцуулах вий гэсэн айдастай байв. Энэтхэгт нөхцөл байдал хурцдаж, эрх баригчид Рохинжа дүрвэгсдийг Бангладеш руу албадан гаргасан бөгөөд гадаадын иргэн байж болзошгүй хэмээн үзсэн 300 мусульман хүнийг албадан гаргасан. Түүнчлэн шинэ хуулиар орогнол хүсэгчдийг “хууль бус шилжин суурьшигч” гэж ангилснаар буцаан албадан шилжүүлэхийг хориглох зарчмыг улам сулруулсан. Малайзын эрх баригчид Рохинжа дүрвэгсдийг албадан саатуулж, бусдыг тээвэрлэсэн завинуудыг буцааж байв. Япон улс оршин суух хугацаагаа хэтрүүлсэн гадаадын иргэдийн тоог хоёр дахин бууруулах зорилгоор “Тэг төлөвлөгөө”-г хэрэгжүүлж, түргэвчилсэн журмаар нутаг буцааж байгаа нь орогнол хүсэгчдийг эрсдэлд оруулж байгаа талаарх шүүмж өрнөв. Тайландын засгийн газар эрүү шүүлтэд өртөх эрсдэлийг үл хайхран 40 Уйгур хүнийг Хятад руу албадан буцаасан.

Бүс нутаг даяар дур зоргоор, тодорхой хугацаагүйгээр саатуулах явдал хэвээр үргэлжиллээ. Малайзын эрх баригчид цагаачлалын саатуулах төвүүдэд 20,000 гаруй хүнийг, тэдний дотор 2,000 гаруй хүүхдийг саатуулав. Австралийн засгийн газар орогнол хүсэгчдийг “оффшор журам”-д хамруулах бодлогоо хэвээр үргэлжлүүлснээр 11 жилийн дараа ч 90 хүн Науру аралд, 30 хүн Папуа Шинэ Гвинейд шийдвэрээ хүлээсээр байв. Гэвч шинэ хууль тогтоомжуудаар орогнол хүсэгчдийн процессын эрхийг хязгаарласан. Шри Ланкад 116 Рохинжа дүрвэгч, тэдний дотор хүүхдүүдийг НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газарт хандах боломжгүйгээр цэргийн байгууламжид саатуулсан. Япон, Тайвань улсын засгийн газрууд ил тод бус тогтолцооны хүрээнд иргэдийг цагаачлалын шалтгаанаар тодорхой бус хугацаагаар саатуулах зөвшөөрлийг үргэлжлүүлсэн бөгөөд саатуулах байрны шаардлага хангаагүй нөхцөл болон саатуулагдсан хүмүүсийн эрхийг хамгаалах хууль зүйн баталгаа хангалтгүй байгаатай холбоотойгоор шүүмжлэлд өртсөн. Бангладеш дахь нөхцөл байдал огцом дордов. Нэг сая гаруй Рохинжа дүрвэгчийг байршуулсан дэлхийн хамгийн том дүрвэгсдийн лагерь болох Кокс-Базарт тусламжийн санхүүжилт эрс буурч, 150,000 шинэ дүрвэгчийг хүлээн авсны улмаас нөхцөл байдал улам хүндэрсэн бөгөөд НҮБ-аас яаралтай уриалга гаргасан хэдий ч хандивлагчдын амлалт хангалтгүй байснаас амин чухал үйлчилгээний тогтолцоо нуран унах эрсдэлд хүрээд байна.

Бүс нутагт хүн худалдаалах болон албадан хөдөлмөр эрхлүүлэх нь эрс нэмэгдсэн. Камбожид 50 гаруй цахим залилангийн төвд гадаадын иргэдийг хүн худалдаалдах арга замаар авчирч, цахим луйврын ажиллагаанд албадан оролцуулж байсан бөгөөд энэ талаарх эрх баригчдын авч байгаа арга хэмжээ ил тод бус байв. Мьянмар улс хүний наймааны гол бүс нутаг хэвээр байсан бөгөөд залилангийн төвүүдэд 100,000 орчим хүнийг саатуулан байлгаж, зэвсэгт бүлэглэлүүд албадан хөдөлмөр болон албадан дайчлах ажиллагаа явуулж байв. Зөрчил үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэсэн боловч зөрчил үргэлжилсэн хэвээр байна.

**Засгийн газрууд дүрвэгсдийг албадан шилжүүлэх, дур зоргоор саатуулах болон хүн худалдаалах үйлдлийг зогсоож, орогнол хүсэх аюулгүйн журмыг хангаж, хууль бусаар саатуулагдсан хүмүүсийг суллаж, дүрвэгсэд болон шилжин суурьшигчдын эрх, нэр төрийг олон улсын хэм хэмжээнд заасны дагуу хамгаалах ёстой.**

## **ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ**

Уур амьсгалын өөрчлөлт нийгмийн тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлэв. Бангладешид цаг агаарын эрс тэс үзэгдлүүд нь жөндөр болон кастад суурилсан ялгаварлан гадуурхалтыг улам даамжруулж, нийтийн үйлчилгээний цэвэрлэгээний ажилтнуудын эмзэг байдлыг хэвээр хадгалахад хүргэв. Тувалу болон Кирибати улсад далайн түвшин нэмэгдсэний улмаас хүмүүс нутаг орноосоо шилжин суурьшиж байгаа нь орон сууц, эрүүл мэнд болон соёлын нэгт зүйлээ хадгалах эрхэд заналхийлж байна. Пакистанд аймшигт үерийн улмаас 1,000 гаруй хүн амь үрэгдэж, сая сая хүн орон гэрээсээ дайжсан бол халууны давлагаа 49°C хүрсэн нь гамшгийн эрсдэлийн эсрэг хариу арга хэмжээ хангалтгүй байгааг илтгэн харуулав. Түүнчлэн Энэтхэг, Индонез, Балба, Шри-Ланкад хар салхинаас үүдэлтэй үер, хөрсний гулгалтын улмаас хүний амь нас хохирч, тусламж хүрэх боломж хязгаарлагдмал хөдөө орон нутгийн иргэд илүү ихээр өртсөн нь уур амьсгалтай холбоотой гамшгийн бэлэн байдлын талаар ноцтой асуулт дэвшүүлэхэд хүргэв. Албан ёсны мэдээллээр 10-11 дүгээр сард Энэтхэгийн нийслэл Нью-Дели хот дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой хотын жагсаалтыг тэргүүлжээ.

Шатмал буюу чулуужсан түлшний олборлолтыг тэлэх бодлого болон эрчим хүчний шилжилтийн зарим төслүүдийн хэрэгжилт сулаас уугуул иргэдийн эрх зөрчигдсөөр байна. Индонез улсын Зүүн Халмахера дахь никелийн олборлолтыг эсэргүүцсэн 27 уугуул иргэнийг баривчилсан нь уламжлалт (заншлын) эрхэд суурилсан газар нутагт нүүрлэж байгаа аюулыг тодотгов. Японы засгийн газар АНУ болон Канад зэрэг улсын шингэрүүлсэн байгалийн хийн төслүүдийг гадаад улсуудад идэвхтэй дэмжин хэрэгжүүлж байгаа нь уугуул Гвичин болон Ветсүвэтэн ард түмний уламжлалт газар нутаг, эрх ашигт хохирол учруулна гэх шүүмжлэлийг дагуулав. Австрали улсад Торресын хоолойн арлуудын уугуул иргэдийн уур амьсгалын асуудлаарх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нь оршин тогтнох эсэх нь эрсдэлд байгаа үндэстнүүдийн шударга ёс эрэлхийлэх оролдлогыг сулрууллаа.

Сул засаглал нь эмзэг байдлыг үргэлжлүүлсээр байна. Мальдив улс уур амьсгалын эрс шийдэмгий төлөвлөгөөг эхлүүлсэн боловч хүний эрхийг баталгаажуулсан хүчтэй хамгаалалтыг тусгаагүй бөгөөд уур амьсгалтай холбоотой шүүхийн нэхэмжлэлийг хаасан нь соёл болон амьжиргааны эрхийг доройтуулав. Малайзад хууль тогтоогчид салбарын зөвлөлдөх уулзалтыг эн тэргүүнд тавьж уур амьсгалын тухай хуулийн төслийг хойшлуулсан бол Өмнөд Солонгосын засгийн газар ялгаруулалтын талаарх зорилтоо хангалтгүй хэвээр үлдээж, шударга шилжилтийн чиглэлд авч хэрэгжүүлэх тодорхой төлөвлөгөөг батлаагүй. Хятадад байгаль орчны шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог хүчтэй хязгаарлах бодлого үргэлжилсээр, хариуцлагын механизмийг сулруулж байна. Ялгаварлан гадуурхсан шилжилт хөдөлгөөний бодлого нь уур амьсгалын нөлөөллөөс үүдэлтэй шударга бус байдлыг улам гүнзгийрүүлэв. Шинэ Зеландын засгийн газар уур амьсгалын нөлөөгөөр шилжин суурьшсан Номхон далайн бүс нутгийн хүмүүст хангалттай хууль ёсны гарц бүрдүүлж чадаагүй нь тэгш бус байдлыг улам бэхжүүлж, гэр бүлүүдийг салгах, хүүхдийн эрхийг зөрчих, мөн шилжин суурьшигчдын эмзэг байдлыг нэмэгдүүлэхэд хүргэв.

**Засгийн газрууд уур амьсгалын шударга ёсыг хангаж, шатамхай буюу чулуужсан түлшний олборлолтыг тэлэх бодлогыг зогсоож, уугуул хүмүүс болон нийгэм, эдийн засгийн эмзэг бүлгийг хамгаалж, хүний эрхэд суурилсан уур амьсгалын бодлого хэрэгжүүлж, уур амьсгалын нөлөөгөөр нутаг орноосоо шилжин суурьшсан хүмүүст аюулгүй, хууль ёсны шилжилт хөдөлгөөн хийх боломжийг баталгаажуулах шаардлагатай.**

## ЦААЗААР АВАХ ЯЛ

Ази номхон далайн бүс нутгийн ихэнх улсад цаазаар авах ялыг хэвээр хадгалж, олон улсын хүний эрхийн эрхзүй, хэм хэмжээг удаа дараа зөрчив.

Хоёр улс тодорхой хугацаагаар завсарлага авсны дараа цаазаар авах ялыг дахин гүйцэтгэсэн. Япон улс гурван жил завсарласны эцэст Ткахирос Шираишиг дүүжилж цаазалсан нь цаазаар авах ялыг халах хүчин чармайлтыг эрсдэлд орууллаа. Тайвань улсад Хуан Лин-Кайг цаазаар авсан нь уг ялыг 2020 оноос хойш анх удаа гүйцэтгэсэн тохиолдол бөгөөд ингэхдээ түүний давж заалдах хүсэлт болон сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг анхаарч үзээгүй.

Афганистан улсад Талибанчууд олон нийтийн өмнө цаазаар авах ял гүйцэтгэсэн. Тайлан мэдээлэлд дурдсанаар Хойд Солонгосын засгийн газар олон улсад хүлээн зөвшөөрдөггүй гэмт хэрэг, тухайлбал гадаадын мэдээллийг түгээсэн хэрэгт цаазаар авах ял оноож, олон нийтийн өмнө гүйцэтгэх замаар хяналтын хэрэгсэл болгон ашиглав.

Хятадын эрх баригчид авлига, луйвар болон хүн худалдаалах гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэсэн хэвээр байна. Олон хүнийг нэг дор цаазаар авах нь шударгаар шүүлгэх эрхийн ноцтой зөрчлийг үүсгэж болзошгүй гэх санаа зовнил нэгэн маргаантай холбогдуулан үүссэн. Бангладешт 2024 оны эсэргүүцлийн бослогын дараа тусгай шүүхийн шийдвэрээр Ерөнхий сайд асан Шейх Хасина болон бусад төрийн албан тушаалтнуудыг шүүх хуралд оролцуулалгүйгээр дүүжилж гүйцэтгэх цаазаар авах ял оногдуулжээ. Мальдив улс хар тамхитай холбоотой гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулахаар өргөжүүлж, уучлалд хамруулах, хэлэлцэх журмаар шийдвэрлэхийг хориглосон.

Сингапурт хар тамхитай холбоотой хэрэгт цаазаар авах ял оногдуулах явдал тасралтгүй үргэлжилсний зэрэгцээ олон улсын эсэргүүцэл шүүмжлэлийг үл харгалзан Малайзын иргэн Паннир Селвамыг цаазалсан. Вьетнамд эерэг өөрчлөлт гарч, хар тамхи тээвэрлэх зэрэг найман төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан боловч, цаазаар авах ялтай хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шударга шүүхийн үйл явц хангалтгүй байх, мөн нууцлал өндөртэй байдал хэвээр байгаа нь санаа зовох асуудлыг төрүүлсээр байна. Малайз улсад 2023 онд сонголтгүйгээр цаазаар авах ял оногдуулахыг хүчингүй болгосны дараа цаазаар авах ял болон түүнийг халах асуудлыг судлах тухайгаа засгийн газар мэдэгдэв.

Эдгээр үйл явдлууд нь тодорхой ялгаа бүхий дүр төрхийг харуулж байна. Зарим улсад шат дараалсан өөрчлөлтүүд явагдаж байхад зарим улсад нууцлал, ялгаварлан гадуурхалт, улс төрийн зорилго давамгайлсан практик хэвээр байна.

**Цаазаар авах ялыг хадгалж үлдсэн улс орнууд уг ялыг халах алхмыг нэн яаралтай авч хэрэгжүүлэх, халах хүртлээ цаазаар авах ялын гүйцэтгэлийг түдгэлзүүлэх шаардлагатай.**

## ЯЛ ЗАВШИХГҮЙ БАЙХ, ШУДАРГА ЁС, ҮНЭНИЙГ МЭДЭХ, ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ ЭРХ

Хууль эрх зүйн болон хяналт шалгалтын байгууллагуудын тогтолцооны сул талууд нь хүний эрхийн ноцтой зөрчлийн хохирогчдод шударга ёс тогтоох боломжийг хаасан хэвээр байна. Афганистан улсад Талибанчууд шүүхийн бүтцүүдийг задлан устгаж, ялгаварлан гадуурхсан шариатын хуулийг хэрэгжүүлж, шударгаар шүүлгэх эрх хэрэгжих боломжийг үгүй хийж байна. Үндэсний хүний эрхийн байгууллага зэрэг хяналтын байгууллагууд ажиллагаагүй хэвээр байна. Непалд шилжилтийн шударга ёсны комиссуудын томилгоог хаалттай, улс төрийн нөлөөн дор явагдсан хэмээн шүүмжилж, улмаар хохирогчдын бүлгүүд эдгээр томилгоонд бойкот хийв. Шри Ланкад, Ерөнхий прокурорын хараат бус байдал алдагдсан, хэргийг дахин

нээлтэйгээр мөрдөн шалгах ажиллагааны хангалтгүй байдал зэрэг олон төрлийн саад бэрхшээлүүд үргэлжилсээр байна. Бангладешийн прокурорууд хүчээр алга болгосон хэрэгт цэргийн офицеруудыг анх удаа яллагдагчаар татсан хэдий ч шударга процессын хэм хэмжээг сахин мөрдөх асуудал нь тэр дундаа Шейк Хасинагийн шүүх хурлын үеэр санаа зовнилыг бий болгосон хэвээр байна.

Зарим хэрэгт олон улсын хариуцлагын тогтолцоонд ахиц дэвшил гарсан. Олон улсын эрүүгийн шүүхээс Талибаны удирдагчдад жендэрт суурилсан хавчлага үйлдсэн хэрэгт буруутган баривчлах шийдвэр гаргасан бол НҮБ Афганистанд мөрдөн шалгах механизмыг байгуулсан. Филиппин улсын ерөнхийлөгч асан Родриго Дутертег хүн төрөлхтний эсрэг аллагын гэмт хэрэгт буруутган баривчилж, Олон улсын шүүхэд шилжүүлсэн нь түүхэн алхам болсон.

Үнэнийг мэдэх, хохирол барагдуулах үйл явц хангалтгүй хэвээр байна. Шри Ланкад Үнэн ба Эвлэрүүлэн зуучлах комисс байгуулагдаж, сураггүй алга болсон хүмүүсийн асуудал эрхэлсэн газрыг өргөжүүлсэн хэдий ч ахиц дэвшил хэт удаашралтай байна. Филиппинд хар тамхитай холбоотой аллага, хүний эрхийн идэвхтнүүдийн эсрэг дарамт шахалт, Шри Ланкад Тамилчуудын эсрэг тандалт үргэлжилж байгаа нь хууль бус үйлдэлд ял шийтгэлгүй үлдэх байдал хэвээр байгааг харуулж байна.

**Засгийн газрууд олон улсын эрх зүй болон бусад ноцтой хүний эрхийн зөрчлүүдийг шуурхай, хараат бусаар, шударгаар, үр дүнтэй мөрдөн шалгаж, сэжигтнүүдийг шударга шүүхээр шийтгэж, хохирогчдын зөрчигдсөн эрхийг үр дүнтэй сэргээх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай.**

## ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Бүс нутгийн хэмжээнд бэлгийн болон жендэрийн эрхэд системт ухралт гарлаа. Афганистан улсад Талибанчуудын шийдвэрүүдээр эмэгтэйчүүдийн сурч боловсрох, хөдөлмөрлөх, чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлаж, Махрам(эрэгтэй харгалзагч)-ын дүрэм журмыг хэрэгжүүлж, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн гэрлэлтийг даамжруулав. Бангладешт өв залгамжлалын хөрөнгийг тэгш хуваарилах болон гэрлэлтийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох хуулийн шинэчлэлийг эсэргүүцсэн өргөн хүрээний бослого өрнөв. Фижи, Непал, Пакистан зэрэг улсад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нэмэгдсэн бол Непал, Пакистанд шүүхээр гэмт хэргийн асуудлыг хэлэлцэхэд хохирогчийг шүүгдэгчтэй хүчээр тохиролцоо хийлгэх тохиолдлууд гарсан. Непалд Чхаупади буюу эмэгтэйчүүдийг сарын тэмдгийн үед нь ганцаарчлан тусгаарлах зэрэг зан үйл үргэлжилсээр байна. Өмнөд Солонгост эрх зүйн шинэчлэл хийсэн ч цахим орчны хүчирхийлэл, дарамт, доромжлол, зөвшөөрөлгүйгээр хүний биеийн эмзэг хэсгийн зургийг тараах зэрэг технологи ашиглан үйлдэгдсэн жендэрт суурилсан хүчирхийлэл үргэлжилсэн хэвээр байна. Шри-Ланка улсын засгийн газар анх удаа Эмэгтэйчүүдийн комисс байгуулахаа зарласан бол, Өмнөд Солонгост үр хөндөлтийн эрх зүйн шинэчлэл удаашрах зэргээр институцийн шинэчлэл харилцан адилгүй байв.

## ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

ЛГБТИ хүмүүсийн эрхийг үл ойшоосоор байна. Японд шүүхүүд гэрлэлтийн эрх тэгш байдалд харилцан адилгүй хэдий ч зарим ахиц гаргав. Пакистанд трансжендэр хүмүүсийн амь насыг хөнөөсөн хэрэг бүртгэгдсэн; Вьетнамд төрийн дарамт шахалтын улмаас Бахархлын жагсаал цуцлагдсан бол Хятадын үндэсний хууль тогтоомж ЛГБТИ хүмүүстэй холбогдолтой мэдээллийн агуулгад тавих хяналтыг улам нэмэгдүүлсэн. Хонгконгийн хууль тогтоогчид ижил хүйстний гэрлэлтийг хамгаалах хуулийг баталж чадаагүй бөгөөд ингэснээр хууль эрх зүйн хамгаалалт олгох боломж хязгаарлагдсан.

**Засгийн газрууд нь жендэр, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд суурилсан ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоож, үр дүнтэй хамгаалалтыг хэрэгжүүлж, хууль, бодлого болон өдөр тутмын амьдралд тэгш байдлыг бодитоор баталгаажуулах ёстой.**

## **ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН ЗӨРЧИЛ**

Энгийн иргэд хууль бус халдлага, довтолгооны ноцтой эрсдэлд өртөв. Афганистанд амиа золиосолсон дэлбэрэлт, зэвсэгт бүлэглэлүүдийн тэсрэх төхөөрөмжүүд, Пакистаны хил дамнасан довтолгооны улмаас энгийн иргэд амь насаа алдаж, шархдав. Мьянмар улс дахь агаарын цохилт нэмэгдэж, сургууль, тосгонуудыг онилж, “жигжиг нисэх төхөөрөмж” ашигласан довтолгооны улмаас хүүхдүүдийг оролцуулан хэдэн арван хүн амь үрэгдэж, эрсдэлтэй бүс нутагт хүмүүнлэгийн тусламжийг гацаав. Камбож, Тайландын хилийн мөргөлдөөний улмаас эмнэлэг, орон сууц, сүм хийд сүйдэж, иргэний байгууламжийг үл ялгасан довтолгоонууд олноор бүртгэгдэв. Худал, ташаа мэдээлэл нь хурцадмал байдлыг нэмэгдүүлж, зэвсэгт мөргөлдөөн болон түр зогсоох гэрээний зөрчлүүд үргэлжилснээр оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх болон хүмүүнлэгийн хямрал улам гүнзгийрэв.

**Засгийн газрууд хууль бус довтолгоог зогсоож, энгийн иргэдийг хамгаалж, хүмүүнлэгийн тусламжийг зөвшөөрч, олон улсын хүмүүнлэгийн эрхийг хэрэгжүүлэх шаардлагатай.**

# ЕВРОП, ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

## ЗҮҮН ЕВРОП БОЛОН ТӨВ АЗИ

Тус бүс нутаг хүний түгээмэл эрх болон олон улсын шударга ёсны тогтолцоог хүндэтгэх зарчим дэлхий даяар доройтож буй үйл явцын тэргүүн эгнээнд хэвээр байлаа. Орос улс энэ чиг хандлагыг үргэлжлүүлэн манлайлж, Украин улсын эсрэг зэвсэгт түрэмгийлээ үргэлжлүүлэхийн зэрэгцээ энгийн иргэдийн эсрэг ялгаваргүй халдлага үйлдэх, чухал дэд бүтцийг устгах зэргээр олон улсын эрх зүйн гэмт хэрэг үйлдсэн. Энгийн иргэд хамгийн их хохирол амссан.

Ийм нөхцөлд хүний эрх тохиролцооны үр дүнгээс ихээхэн хамааралтай болов. Беларусь улс хоригдлуудыг суллах замаар АНУ-ын хориг арга хэмжээг зөөлрүүлсэн бол газрын ховор ашигт малтмал болон эрчим хүчний нөөц нь Украин болон бусад бүс нутаг дахь хүний амь наснаас дээгүүр тавигдав. Европын Холбоо-Төв Азийн анхны дээд хэмжээний уулзалт Төв Азийн улс орнууд олон улсын хүний эрхийн үүргээ хангалттай биелүүлэхгүй байгаа нөхцөлд зохион байгуулагдсан. Азербайжан улс дахь хүний эрхийн нөхцөл байдал маш хангалтгүй байгааг үл харгалзан Европын Холбоо болон бусад улс орнууд Оросын газрын тос, хийнээс хараат байдлаа бууруулах зорилгоор тус улстай эрчим хүчний хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлсэн.

Иргэний нийгэм байнгын дарамт, шахалтад өртсөн. Олон тооны идэвхтэн, сэтгүүлч, байгууллагуудыг "террорист", "экстремист", "гадаадын агент", "зохисгүй байгууллага" гэх зэргээр нэрлэж эх орноос нь хөөж, үйл ажиллагааг нь зогсоосон. АНУ гадаад тусламжаа урьд өмнө байгаагүй хэмжээгээр зогсоосноор хүний эрхийн төлөөх олон улсын дэмжлэг хумигдаж, айдаст түгшүүртэй орчин үүссэн нь иргэний нийгмийн байгууллагуудыг сулруулж, хүний эрхийн тайлагналтыг мэдэгдэхүйц багасгасан.

Хүний эрхийг хүндэтгэх чиглэлд гарсан томоохон ухралтын нэг нь Киргизстан улс Үндсэн хууль, олон улсын гэрээгээр хориглосон цаазаар авах ялыг дахин сэргээхээр оролдсон явдал байв. Гүрж улс дарангуйлал руу огцом шилжиж, эсэргүүцэл, шүүмжлэлийг зохион байгуулалттайгаар нухчин дарах арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх, хууль дээдлэх ёс, дүрвэгсэд, цагаачдын эрх мөн адил нухчин даралтад өртөж, бүс нутгийн хэмжээнд бүхэлдээ буурсан үзүүлэлттэй байв. Эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах явдал өргөн тархсан. Жендэрт суурилсан хүчирхийлэл үргэлжилсэн. Мөн чулуужсан түлшний үйлдвэрлэл, хэрэглээ нэмэгдсэн нь засгийн газрууд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хүлээсэн үүргээ үл ойшоож буйг илтгэж байна.

## ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН ЗӨРЧИЛ

ОХУ-ын Украины эсрэг түрэмгийлэл дөрөв дэх жилдээ үргэлжилж, энгийн иргэдийн чухал дэд бүтцийг онилсон агаарын цохилтууд улам эрчимжсэн. Хүчээр алга болгох, эрүүдэн шүүх ажиллагаа өргөн тархаж, дрон ашиглан энгийн иргэд рүү халдсан нь хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцогдоно. Өвлийн саруудад эрчим хүчний дэд бүтэц рүү бараг өдөр бүр халдсаны улмаас сая сая хүн хасах хэмийн хүйтэнд халаалт, цахилгаангүй үлдсэн. Харин Украин улсын зүгээс Оросын эрчим хүчний байгууламжуудад хийсэн цохилтууд нь цахилгааны тасалдал үүсгэсэн. Орос

руу хийсэн зарим довтолгооны улмаас хүний амь нас хохирч, иргэний дэд бүтэц эвдэрч сүйдсэн.

Оросын эрх баригчид эзлэн авсан газар нутагт энгийн иргэдийг хүчээр алга болгох, эрүүдэн шүүх ажиллагааг зохион байгуулалттайгаар явуулсан. Түүнчлэн сургуулийн заавал судлах сургалтын хөтөлбөрөөр дамжуулан Украин үндэстний онцлогийг үгүй хийх оролдлоо хийсэн. Түүнчлэн 2022 онд хууль бусаар нэгтгэн авсан нутаг дэвсгэрийн оршин суугчдыг Оросын иргэншил авахаас татгалзсан тохиолдолд тэдний өмч хөрөнгө болон бусад эрхийг хасах хууль тогтоомжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн нь дайны хуулийн илэрхий зөрчил юм.

Армени, Азербайжан улсууд Нагорно-Карабахын мөргөлдөөний үеэр бий болсон эерчлүүдэд хариуцлага тооцох талаар ахиц дэвшил гаргасангүй.

**Дайны болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг түгээмэл харьяаллын зарчмын дагуу хараат бус, бие даасан журмаар мөрдөн шалгах шаардлагатай.**

## **ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ**

Бүс нутгийн хэмжээнд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх улам хязгаарлагдаж, шүүмжлэлт дуу хоолой илэрхийлсэн хүмүүсийг “экстремист”, урвагч, “гадаадын агент” хэмээн цоллож, эх орноос нь хөөх, улс төрийн зорилгоор шийтгэх, эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцаж, зорчих эрхийг нь хориглосон.

Азербайжанд 300 гаруй шүүмжлэгчдийг хилс хэргээр хорьж, олон арван хүний зорчих эрхийг хориглож, бусад олон хараат бус хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг зогсоосон. Гүрж улсад хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслүүд гүтгэлгийн кампанит ажил, торгууль, эрүүгийн хэрэгт холбогдуулан шалгах зэрэг иж бүрэн шахалт, дарамтад өртсөн.

Беларусь улсын “экстремист үйл ажиллагаанд оролцогчдын жагсаалт”-нд хамгийн багадаа 6,127 хүний нэр бичигдсэн бөгөөд уг жагсаалтад орсон хүмүүстэй холбоотой байгууллагуудыг хориглосон. Киргизстан улсад нэр хүндтэй хараат бус хэвлэл мэдээллийн байгууллагуудыг “экстремист” хэмээн нэрлэж, тэдгээрийн материалыг дэмжсэн, түгээсэн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан. Молдав улсад Оросын талыг дэмжсэн телевизийн сувгуудын зөвшөөрлийг шүүхийн хяналтгүйгээр хүчингүй болгох ажиллагаа үргэлжилсэн.

ОХУ-д Украин улсын эсрэг дайныг эсэргүүцсэн, эсхүл шүүмжилсэн иргэдэд урт хугацаагаар хорих зэрэг хатуу ял шийтгэл оногдуулсан. Цензур, хяналт нийгмийн бүх төрлийн харилцаанд гүнзгийрч, “гадаадын агент”, “террорист”, “экстремист” хэмээн үзсэн зохиогчдын хөгжим, ном, кино зэрэг бүтээлийг хориглоход хүргэсэн.

## **ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ**

Тайван хуран цуглах эрхийг улам дарангуйлж, эрхээ хэрэгжүүлэхийг оролдсон тохиолдолд эрүүгийн хэрэгт татаж, хорьж, эрүүдэн шүүж, бусад байдлаар зүй бусаар харьцсан. Бүс нутгийн ихэнх улсад эсэргүүцлийн хөдөлгөөнүүд илэрхий дарагдаж, хумигдсан. Беларусь, Тажикстан болон Туркменистан улсад эсэргүүцлийн жагсаал бараг зохион байгуулагдаагүй бөгөөд хүнд ялаар шийтгэгдэх эрсдэлтэй байв. Беларусь улсын эрх баригчид гадаадад зохион байгуулагдсан жагсаалд оролцсон иргэдэд хариуцлага хүлээлгэхийг оролдсон.

Гүрж улсад эрх баригчид 2024 оны сүүлээс эхлэн бараг өдөр бүр үргэлжилсэн жагсаал, цуглааны хариу болгон амны хаалт зүүсэн, явган хүний зам дээр зогсох зэрэг тайван үйлдэлд хүртэл эрүүгийн хариуцлага хүлээлгэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Цагдаа нар жагсагчдын эсрэг нулимс асгаруулагч хий, резинэн сум, хорт химийн бодистой усан хөөрөг хэрэглэж, зодох зэргээр хууль бус хүч хэрэглэсэн. Идэвхтнүүд, сэтгүүлчид, сөрөг хүчний дэмжигчдийг зөвхөн эрхээ эдэлснийх нь төлөө нэгжих, баривчлах, хорих ялыг зориуд оногдуулах арга хэмжээ авсан.

ОХУ-д жагсаал, цуглааныг хатуу дарангуйлж байсан хэдий ч орон нутгийн

шинжтэй асуудлаар жижиг хэмжээний жагсаал, цуглаан үргэлжилсээр байв. Харин Украин улсад дайны тухай хуулиар хязгаарлалт тогтоосон хэдий ч авлигын эсрэг олон нийтийн томоохон жагсаал, цуглаанууд өрнөсөн.

## **ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ**

Засгийн газрууд дарангуйллын хууль тогтоомж хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоог гэмт хэрэгт тооцож, санхүүгийн хатуу хязгаарлалт ногдуулах замаар иргэний нийгмийн үйл ажиллагааны орчныг улам хумьж, эрсдэлд оруулсан. Гадаад тусламжийн огцом таналт нь нөхцөл байдлыг улам дордуулж, олон тооны төрийн бус байгууллагуудыг үйл ажиллагаагаа бүрэн зогсоох, эсхүл мэдэгдэхүйц хэмжээгээр танахад хүргэсэн.

Азербайжан улс төрийн бус байгууллагуудын эсрэг 2014 оны хэргийг дахин нээж, гэнэтийн үзлэг нэгжлэг хийж, үйлдвэрчний эвлэл болон иргэний нийгмийн анхан шатны байгууллагуудыг онилсон. Беларусь улсад албадан татан буулгасан, түдгэлзүүлсэн, бүртгүүлээгүй төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгдсэн үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох болсон. Гүрж улс “гадаадын агент”-ын эсрэг хууль баталж, 2024 онд жагсагчдад эмнэлгийн хэрэгсэл болон бусад дэмжлэг үзүүлснийг “хорлон сүйтгэх үйл ажиллагаа” хэмээн үзэж долоон төрийн бус байгууллагын банкны дансыг царцаасан.

Казахстаны Ерөнхийлөгч “хүний эрхийн гэх тодотголтой байгууллага, блогч, сэтгүүлчид”-ийг гадаадаас санхүүждэг, сөрөг агуулгатай мэдээлэл санаатайгаар эрэлхийлж, эрх баригчдыг буруутгах зорилготой хэмээн буруутгасан. ОХУ иргэний нийгмийн байгууллагуудыг “гадаадын агент”, “зохисгүй байгууллага” хэмээн үзэж тэдний эсрэг хууль тогтоомжийг зэвсэг болгон ашиглаж, иргэний нийгмийг боомилж, идэвхтнүүдийг гутаан доромжилж, хорьсон. Эмнести Интернэшнл болон Хүний эрхийн Хяналт зэрэг 95 байгууллагыг “зохисгүй байгууллага”-д хамааруулсан.

**Засгийн газрууд үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван хуран цуглах эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомж, үйл ажиллагааг халж, ийм хуулиудыг хүний эрхийн талаарх хэлэлцүүлгийг боомилох, эсэргүүцэл, шүүмжлэлийг нухчин дарах урьдчилсан нөхцөл болгон ашиглахаа зогсоох ёстой.**

## **ШУДАРГА БУСААР ШҮҮХ**

Шүүхийн тогтолцоог эсэргүүцэл, шүүмжлэлийг нухчин дарах зорилгоор ашиглах явдал нэмэгдсэнээр шударгаар шүүлгэх эрх улам бүр эрсдэлд оров. “Терроризм”, “экстремизм” гэх хэрэгт яллагдагчийг оролцуулалгүйгээр шүүхээр шийдвэрлэх тохиолдол нэмэгдсэн. Азербайжан улс олон тооны сэтгүүлч, идэвхтнүүдийг үндэслэлгүй хэрэгт холбогдуулан шалгаж, шударга бусаар шүүсний дараа хорьж, оны эцсийн байдлаар ойролцоогоор 30 хэвлэл мэдээллийн ажилтан хорих ял эдэлж, шүүхийн өмнөх шатанд урт хугацаагаар цагдан хоригдсон. Беларусь улсад зарим хоригдлын хариуцлагыг хөнгөрүүлж хугацаанаас нь өмнө сулласан хэдий ч улс төрийн зорилгоор хоригдогсдын тоо нэмэгдсэн. Гүрж улсад эсэргүүцэл, шүүмжлэлийг дарах зорилгоор шударга бусаар шүүсний дараа жагсагчид, сэтгүүлчид, сөрөг хүчний төлөөлөгчдийг дур зоргоор саатуулах, хорих нь түгээмэл байв. Киргизстан улсад Клүүп, Темиров Лайв зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус сэтгүүлчдийн эсрэг үндэслэлгүй хэрэг үүсгэсэн нь тус улс дахь хараат бус хэвлэл мэдээлэлд ноцтой цохилт болсон. Казахстан, Туркменистанд шүүмжлэлт дуу хоолой илэрхийлсэн хүмүүсийг хорьсон. ОХУ-ын шүүх улс төрийн зорилготой, илт үндэслэлгүй хэрэгт хатуу ял оноосоор байв. Тажикстанд сөрөг хүчний улстөрчид, зарим албан тушаал хашиж байсан хүмүүст холбогдох хэргийг хаалттай шүүх хурлаар хэлэлцэж урт хугацаагаар хорих ял оноосон бөгөөд 2015 оноос хойш дур зоргоор хоригдож буй хүний эрхийн өмгөөлөгч Бузургмэр Иоровыг суллахыг шаардсан 12 олон улсын хүний эрхийн байгууллагын давж заалдах гомдолд албан ёсны хариу өгөөгүй хэвээр байв.

**Эрх баригчид шударгаар шүүлгэх эрхийг баталгаажуулж, шүүх тогтолцоог эсэргүүцэл, шүүмжлэлийг нухчин дарах хэрэгсэл болгон ашиглахаас татгалзах ёстой.**

## **ЭРҮҮ ШҮҮЛТ, БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА**

Бүс нутаг даяар эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах нь түгээмэл хэвээр байв. Гэвч эдгээр гэмт хэрэгт ял завших явдал өргөн тархсан хэвээр байсан бөгөөд цагдаагийн хүчирхийллийг мөрдөн шалгах нь ховор, үр дүнгүй байв.

ОХУ-ын зэвсэгт хүчин Украины дайны олзлогсдыг шүүхийн бус журмаар цаазалж, эрүүдэн шүүсэн талаарх олон тооны мэдээлэл гарсан. ОХУ-д хоригдлуудыг сахилгын камерт тогтмол хорих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, гадаад ертөнцтэй харилцах боломжийг хязгаарлах зэрэг хүчирхийлэл байсаар байна.

Азербайжаны урьдчилан хорих газарт хүмүүсийг ганцаарчлан хорих, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, хүчирхийлэх, шийтгэлийн зорилгоор шилжүүлэн хорих, удаан хугацаагаар гавлах зэргээр эрүүдэн шүүж, бусад зүй бусаар харьцах нь олширсон. Беларусьд улс төрийн зорилгоор ял шийтгэл хүлээсэн хоёр хүн хоригдож байх хугацаандаа нас барсан бол Тажикстанд Памирын таван идэвхтэн зэрэг долоон хүн хоригдож байх үедээ нас барсан.

Гүрж улсад нүүрээ халхалсан алба хаагчид баривчилгааны үеэр болон цагдан хорих явцад саатуулагдсан хүмүүсийг зодож, хүч хэрэглэх нь олширсон. Казахстанд 2022 онд өрнөсөн нийтийг хамарсан эсэргүүцлийн жагсаалын дараа хүмүүсийг эрүүдэн шүүсэн гэх олон гомдлыг үр дүнтэй шийдвэрлэж чадсангүй. Харин Киргиз улс НҮБ-ын анхааруулгыг үл харгалзан эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагаа татан буулгасан.

Узбекистанд эрүү шүүлт болон бусад зүй бус харьцаа нь ноцтой санаа зовних асуудал байсан хэвээр байна. Беларусь, Туркменистан улсад ганцаарчлан хорьж, гадаад ертөнцтэй холбоогүйгээр цагдан хорьсон нь хүчээр алга болгосон үйлдэлд хамаарна.

**Засгийн газрууд эрүү шүүлт болон бусад зүй бус харьцааг нэн даруй зогсоож, уг гэмт хэрэгт холбогдсон бүхий л этгээдийг шударга шүүхээр оруулж, хариуцлага хүлээлгэх ёстой.**

## **ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ**

ЛГБТИ хүмүүсийн эрхийг үл хүндэтгэх нь нэмэгдэж, тэдний эсрэг чиглэсэн шууд халдлага хэвээр байв. Ялгаварлан гадуурхалтын эсрэг цогц хууль тогтоомж бүс нутаг даяар үгүйлэгдэж байсан бөгөөд ЛГБТИ хүмүүсийн эрхийг “уламжлалт үнэт зүйлс”-тэй сөргөлдүүлсэн албан ёсны яриа хэлэлцүүлэг газар авсан.

Украины шүүхээс ижил хүйстэн хосыг “де-факто гэр бүл” хэмээн анх удаа зөвшөөрсөний зэрэгцээ ЛГБТИ хүмүүсийн эрхийн тэгш байдлыг дэмжих олон нийтийн хандлага тогтвортой өсөж байгаа эерэг өөрчлөлт гарсан.

Молдав улс дахь ОХУ-д эзлэгдсэн газар нутаг болох Приднестровийн дефакто эрх баригчид ЛГБТИ хүмүүсийн эсрэг “суртал хуульга”-ыг хориглосон хуулийг баталсан бол Казахстан улс мөн ижил төстэй хуулийг баталсан. Узбекистан, Туркменистан улсад ижил хүйстэн эрэгтэйчүүдийн хоорондын бэлгийн харилцааг эрүүгийн гэмт хэрэгт тооцсон хэвээр байна.

**Засгийн газрууд ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхсан хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг хүчингүй болгож, ижил хүйстний харилцан зөвшөөрсөн бэлгийн харилцааг гэмт хэрэгт тооцохыг халж, ижил хүйстний гэрлэлтийг хуульчлахад саад болж буй эрх зүйн саад тотгорыг арилгах шаардлагатай.**

## **ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ**

Жендэрт суурилсан хүчирхийлэл бүс нутгийн хэмжээнд өргөн тархсан хэвээр байв. Гүрж улсын төрийн өндөр албан тушаалтнуудын эмэгтэйчүүдийг дорд үзсэн, хүйсээр ялгаварласан үг хэллэг нь эмэгтэй жагсагчдын эсрэг бэлгийн хүчирхийлэл, бүрэн нүцгэлсэн үзлэг хийх зэрэг жендэрт суурилсан хүчирхийлэлд хүргэсэн. ОХУ-ын парламент олон нийтийн шаардлага, дэмжлэгийг үл харгалзан гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль тогтоомжийг хэлэлцэхгүй орхисон. Тажикстан улсад гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол өмнөх онтой харьцуулахад 15%-иар өссөн.

**Засгийн газрууд жендэрт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэртэй нэн даруй тэмцэж, түүний суурь шалтгааныг шийдвэрлэх яаралтай арга хэмжээ авах шаардлагатай.**

## **ШАШИН ШҮТЭХ, ИТГЭЛ ҮНЭМШИЛТЭЙ БАЙХ ЭРХ ЧӨЛӨӨ**

Бүртгэлийн хатуу шаардлага тавих, шашны цөөнхийн эсрэг “экстремизмын эсрэг” хууль тогтоомжийг зүй бусаар ашиглах зэргээр шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хязгаарлах зорилготой дарамт шахалтын тактикийг бүс нутгийн хэмжээнд өргөн хэрэглэсэн.

Беларусь улсад шашны байгууллагуудыг дахин бүртгэх үйл ажиллагааг ил тод бусаар явуулж, бүртгэлгүй шашны үйл ажиллагааг хориглож, эрх баригчидтай нийцээгүй шашны зүтгэлтнүүд байнгын хавчлагад өртсөн. Киргиз улсад бүртгэлгүй шашны үйл ажиллагааг хязгаарласан хууль баталж, зарим төрлийн шашны хувцсыг хориглон, Адвентист сүмийг “экстремист” хэмээн зарлаж үйл ажиллагааг нь хориглосон. ОХУ-д Еховагийн Гэрчүүдийг дур зоргоор эрүүгийн хэрэгт холбогдуулан шалгаж, цагдан хорьсон хэвээр байсны зэрэгцээ бусад шашны бүлгүүд дарамт шахалтад өртсөн. Украин улс тус улс дахь Ортодокс Сүмийг ОХУ-тай холбоотой хэмээн буруутган татан буулгасан нь “шашны үйл ажиллагааг үндэсний аюулгүй байдалд заналхийлсэнтэй адилтган үзсэн” хэмээн НҮБ-ын шинжээчид шүүмжилсэн.

**Засгийн газрууд шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг бүрэн хамгаалах, дэмжих, баталгаажуулах зорилгоор хууль эрх зүй, бодлогын шинэчлэлийг үр дүнтэй, ялгаварлан гадуурхалт, хавчлагагүйгээр хэрэгжүүлэх яаралтай арга хэмжээ авах шаардлагатай.**

## **ДҮРВЭГСЭД, ЦАГААЧ БОЛОН ДОТООДОО ШИЛЖИН СУУРЬШИГЧДЫН ЭРХ**

Бүс нутгийн хэмжээнд, ялангуяа Украин улсад олон сая хүн нутаг орноосоо дүрвэж, нүүн шилжсэн. Армени улс Нагорно-Карабахас дүрвэсэн 100,000 гаруй хүнийг орон байр, амьжиргаагаар хангах хүндрэлтэй тулгарсан. Беларусь улс Европын Холбооны хилийн дагуух дүрвэгсэд, цагаачдын эсрэг бие махбодын хүчирхийлэл үйлдсэн талаарх мэдээлэл гарсан. ОХУ цагаач иргэдийн хүүхдүүдийг сургуульд элсүүлэхэд заавал хэлний шалгалт өгөх, хууль ёсоор нэвтрэх баримт бичиг шаардах журмыг нэвтрүүлсэн нь олон хүүхдүүдийг сурч боловсрох эрхийг хассан. Тажикстаны эрх баригчид Афганистаны дүрвэгсдийг нутаг дэвсгэрээс албадан гаргасан.

**Засгийн газрууд хавчлага, хүний эрхийн зөрчлөөс зугтаж байгаа бүх хүнд аюулгүй байдал, олон улсын хамгаалалт авах боломжийг хангаж, хэнийг ч хүний эрхийн ноцтой зөрчилд өртөх бодит эрсдэлтэй нөхцөлд буцаан шилжүүлэхгүй байх үүрэгтэй.**

## **ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ**

ОХУ-ын дайн дотооддоо төдийгүй гадаадад байгаль орчны ноцтой хохирол учруулсаар байв. Украйны эсрэг түрэмгийлэл нь байгаль орчинд асар их хор уршиг дагуулж, цэргийн довтолгоонууд нь цөмийн аюулгүй байдлын заналхийллийг бий болгосон. ОХУ болон Беларусь улс дахь иргэний нийгмийн дарамт шахалт нь

байгаль орчин, уур амьсгалын асуудлаар ажилладаг идэвхитнүүдийг эх орноос нь хөөхөд хүргэсэн.

Улс орнууд чулуужсан түлшнээс хамааралтай олборлолтоо нэмэгдүүлснээр уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үүрэг амлалт зөрчигдөж, улам бүр суларсан. Казахстан улс нүүрсний хэрэглээгээ өргөжүүлж, ногоон шилжилтийн амлалтаасаа ухарч байгааг илтгэсэн. Тус улсын Ерөнхийлөгч байгаль орчны бодлогыг ил тод шүүмжилж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээг “өргөн хүрээтэй залилан” хэмээн мэдэгдсэн. Молдавын уур амьсгалын зорилтууд санхүүжилтийн хүндрэлтэй тулгарсан. Узбекистан улс “ногоон эдийн засгийн жил” хэмээн зарласан ч агаарын бохирдлын ноцтой түвшин Беларусь болон бусад улс орнуудын нэгэн адил өндөр хэвээр байв.

Усны нөөц бүс нутгийн олон улс орон, ялангуяа Төв Азид хомсдсон хэвээр байв. Тажикстанд цэвэр усны хүртээмж ноцтой асуудал хэвээр байсан бөгөөд албан ёсны мэдээллээр хүн амын 85%, тэр дундаа хөдөө орон нутгийн бараг бүх хүн бохир усны шугам сүлжээгүй байв. Туркменистанд усны менежментийн доголдол нь хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлсөн. Украин улсын ОХУ-д эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгаа Донецк бүс нутагт де-факто эрх баригчид усны хямралыг шийдвэрлэж чадсангүй.

**Зүүн Европ болон Төв Азийн хүлэмжийн хийн өндөр ялгаруулалттай улс орнууд чулуужсан түлшний олборлолтоо зогсоох зэргээр уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад манлайлах шаардлагатай. Засгийн газрууд уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл, нөлөөллөөс хувь хүн болон орон нутгийн иргэдийг хамгаалах шуурхай арга хэмжээ авах ёстой.**

## **БАРУУН, ТӨВ, ЗҮҮН ӨМНӨД ЕВРОП**

Олон улсын эрх зүйг сахин мөрдөх талаарх улс орнуудын өгсөн үүрэг амлалт болон бодит хэрэгжилт хооронд асар зөрүү байсаар байв. Зарим улс Олон улсын эрүүгийн шүүхтэй хамтран ажиллахаас татгалзсан. Хэд хэдэн улс Израил улсад ээвсэг нийлүүлсээр байв. Ихэнх улсын засгийн газрууд эзлэгдсэн Газын зурваст Израилын үйлдэж буй төрлөөр устгах гэмт хэргийг зогсоох хууль ёсны үүргээ биелүүлэхийн оронд Палестинчуудтай эв санааны нэгдэл илэрхийлсэн үйлдлийг эрүүгийн хариуцлагад татах, хууль бус хүч хэрэглэх замаар нухчин дарах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Зарим улс орогнол хүсэгчид болон дүрвэгсдийн эрхийг зөрчих зэргээр олон улсын эрх зүйн дэг журамд халдсан бодлогоо эрчимжүүлсэн. Үндэсний болон бүс нутгийн түвшинд улс орнууд хүний эрхийн бүс нутгийн гэрээ, хэлэлцээрийн хамгаалалтыг сулруулахыг оролдсон. Мөн хэд хэдэн улс шилжилт хөдөлгөөнийг зохицуулах үүрэг хариуцлагаа өөр бусад улсад тохих бодлогыг санаатайгаар хэрэгжүүлсэн.

Зарим улс үр хөндөлтийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулсан боловч бусад улсад энэ төрлийн саад бэрхшээл хэвээр үлдэж, үр хөндөлтийн эрхийг хамгаалагчид жавчлага, эрүүгийн хариуцлагад өртсөн. Хүний эрхийн эсрэг болон хөндөрийн эсрэг чиглэсэн, санхүүжилт сайтай кампанит ажлууд, засгийн газруудын бодлогын нөлөөгөөр ЛГБТИ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл улам эрчимжсэн. Сая сая хүн ядууралд өртөж, ядуу нөхцөлд амьдарсан хэвээр байв. Зарим тохиолдолд засгийн газрууд орон гэргүй болох, эрүүл мэнд болон бусад суурь үйлчилгээний хүртээмжийг хязгаарлах эрсдэлд хүргэсэн бодлого хэрэгжүүлсэн. Түүнчлэн мөн чанараараа ялгаварлан гадуурхсан шийдвэр гаргах цахим хэрэгслүүр ашигласны улмаас олон мянган хүн нийгмийн хамгааллаас хасагдсан. Арьс үндсээр ялгаварлагдсан бүлгүүд, цыган иргэд, исламын шашинтай эсхүл еврей гэгдэх хүмүүсийн эсрэг үзэн ядалтад суурилсан гэмт хэргийн талаарх мэдээлэл нэмэгдсэн. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн гамшиг үзэгдлүүд, ялангуяа Өмнөд Европын орнуудад ноцтой хохирол учруулсан. Зарим улс уур

**амьсгалын өөрчлөлтийн эсрэг идэвхтэй арга хэмжээ авсан боловч бусад нь үүргээ биелүүлж чадсангүй. Хүний эрх хамгаалагчид дарамт шахалтад өртөж, хорих ялаар шийтгүүлсэн.**

## **ХАРИУЦЛАГАГҮЙ ЗЭВСГИЙН НИЙЛҮҮЛЭЛТ**

Хариуцлагагүй зэвсгийн нийлүүлэлтийг нэн даруй зогсоох НҮБ-ын шинжээчид уриалгыг үл харгалзан хэд хэдэн улс Израил улсад зэвсэг нийлүүлсээр байв. Герман улс зэвсэг нийлүүлэх боломжийг дахин нээж, Франц улс цэргийн зориулалттай материалын экспортын зөвшөөрөл олгосоор байсан бол Чех болон Их Британи улс зэвсгийн экспортоо үргэлжлүүлсэн. Серби улс зэвсгийн нийлүүлэлтээ нэмэгдүүлсэн. Ирланд, Португал, Словени зэрэг олон улс өөрсдийн агаарын орон зай, боомтоор дамжуулан Израил руу зэвсэг тээвэрлэхийг зогсоосонгүй.

**Засгийн газрууд хүний эрхийн ноцтой зөрчил үйлдэх бодит эрсдэлтэй улс орнуудад зэвсэг нийлүүлэлтийг нэн даруй зогсоох шаардлагатай.**

## **ЯЛ ЗАВШИХ**

Олон улсын эрүүгийн шүүхийн эсрэг чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд Унгар, Польш улс тус шүүхээс гаргасан Израилын Ерөнхий сайд Бенжамин Нетаньяху болон Батлан хамгаалахын сайд асан Йоав Галлант нарыг баривчлах захирамжийг хэрэгжүүлэхээс ил тод татгалзсан. Итали улс Ливийн зэвсэгт бүлэглэлийн гишүүн, хүний эрхийн ноцтой зөрчилд буруутгагдаж буй Осамэ Элмасри Нжимийг Олон улсын эрүүгийн шүүхэд шилжүүлэн өгөх үүргээ биелүүлээгүй. Турк улсад тайван жагсагчдын эсрэг хууль сахиулах байгууллагын алба хаагчдын үйлдсэн эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцаанд хариуцлага тооцуулах үйл явцад саад бэрхшээл учиран, ял завших өргөн хүрээний практиктай нүүр тулгарав.

**Засгийн газрууд гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй этгээдүүдэд хариуцлага тооцох, олон улсын шүүхээс гаргасан баривчлах захирамжийг биелүүлэх замаар ял завшихтай тэмцэх боломжит бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.**

## **ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ, ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ**

Иргэний нийгмийг дуугүй болгох зорилгоор хууль бусаар тандах, тайван үйл ажиллагааг эрүүгийн хэрэгт татах, мөн айлган сүрдүүлэх олон төрлийн арга хэлбэрийг ашиглах зэргээр нухчин дарах үйл ажиллагаагаа үргэлжилсээр байв. Гадаадын агентын тухай хууль болон түүнтэй төстэй хуулийн төслийг хэлэлцэх, хэрэгжүүлэхээр баталсан нь Босни ба Герцеговин, Болгар, Унгар, Словак улс дахь иргэний нийгэмд заналхийлэл учруулсан. Олон нийтийн оролцооны эсрэг стратегийн шүүхийн нэхэмжлэлүүд бүс нутгийн хэмжээнд, ялангуяа Хорват, Польш улсад хэвлэл мэдээллийн эрх чөлөө, шүүмжлэлт үзэл бодлыг илэрхийлэхэд ноцтой сөрөг нөлөө үзүүлсэн. Серби улсад хүний эрх хамгаалагчид, сонгуулийн ажиглагчид болон сэтгүүлчдийг гутаан доромжлох зорилготой “системтэй кампанит ажил” явагдаж байж болзошгүй талаар НҮБ-ын тусгай илтгэгчид санаа зовниж байгаагаа мэдэгдсэн.

Засгийн газрууд тайван жагсаал, цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хууль бусаар хязгаарлаж, үг хэлэх, иргэний үл захирагдахуйн үйлдэлд хариуцлага хүлээлгэсэн. Зарим улс уур амьсгалын өөрчлөлт болон Газын зурвас дахь Палестинчуудын эсрэг төрлөөр устгах үйл ажиллагааг эсэргүүцсэн жагсагчдыг шийтгэх, гутаан доромжлох зорилгоор терроризмын эсрэг хэт өргөн хүрээтэй хуулийг ашигласан. Тухайлбал, Их Британи Улс 7 дугаар сард Палестин Акшион шууд эсэргүүцлийн бүлгийг “террорист байгууллага” хэмээн хориглосон нь тайван журмаар өрнөсөн иргэний үл захирагдахуйн өргөн хүрээтэй хөдөлгөөнийг өдөөсөн. Оны эцэс

гэхэд Их Британий эрх баригчид томоохон тайван эсэргүүцлийн жагсаал цуглааны дараа хамгийн багадаа 2,700 хүнийг баривчилсан. Оны эцэс гэхэд дээрх хоригийг шүүхийн журмаар хянаж байв.

**Засгийн газрууд үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван хуран цуглах эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийг хүчингүй болгож, энэ эрхийг боомилох зорилготой үйл ажиллагаагаа таслан зогсоох шаардлагатай.**

## **ДҮРВЭГСЭД БОЛОН ЦАГААЧДЫН ЭРХ**

Европын олон улс оронд дүрвэгсэд, цагаачдын хүний эрхийн хамгаалалтыг сааруулах хоёрдахь шатны тогтолцоог бий болгох хандлага үндэсний болон бүс нутгийн институцийн түвшинд эрчимжсэн бөгөөд үүнд хар арьст, лалын шашинт болон арабчуудыг үзэн ядах, дайсагнах хандлага ихээхэн нөлөөлсөн. Энэ нь олон улсын эрх зүйн үндсэн зарчмууд болох албадан буцаахыг хориглох, хүний эрхийн түгээмэл байх шинж, эрүүдэн шүүхийг хориглох, хувийн амьдралын эрхийг онцгой эрсдэлд оруулсан. Энэ нь төрийн үүргийг сулруулах зорилгоор олон улсын гэрээнээс гарах санаачилга болон улс төрийн мэдэгдлүүдээр илэрч байв. Европын Холбооны гишүүн улс орнууд орогнолын журам дахь хүний эрхийн хамгаалалтыг сулруулах, албадан буцаах арга хэмжээний талаар хэлэлцэн тохиролцсон. Үүний зэрэгцээ Европын Зөвлөлийн 27 гишүүн улс Европын Хүний эрхийн конвенцод заасан цагаачдын эрхийн хамгаалалтыг сулруулахыг уриалсан. Эдгээр хандлага дотоодын түвшинд мөн илэрсэн. Их Британид хууль эрх зүйн өөрчлөлт, өндөр түвшний улс төрчдийн мэдэгдлүүд нь Европын Хүний эрхийн конвенцын ач холбогдлыг сулруулах, бууруулахад чиглэсэн. Австри, Герман улсын эрх баригчид Сири улсын хүний эрхийн нөхцөл байдлыг үл харгалзан тус улсаас дүрвэгсдийг албадан нутаг буцаасан бол бусад олон улс Африканы дүрвэгсдийг албадан нутаг буцаахыг эрмэлзсэн. Грект орогнол хүсэх эрхийг хууль бусаар түр хугацаанд түдгэлзүүлсний дараа олон зуун хүнийг саатуулж, цагдан хорьсон. Хэдийгээр уг арга хэмжээний хугацаа дуусахад заримыг сулласан хэдий ч оны эцсийн байдлаар үлдсэн хүмүүсийг шаардлагад нийцээгүй орчин нөхцөлд үргэлжлүүлэн саатуулсаар байв. Түүнчлэн Польш улс орогнол хүсэх эрхийг Беларусьтай хиллэх хэсэгт хууль бусаар түдгэлзүүлсэн. Швейцарын Холбооны Зөвлөл Украин улс дахь аюулгүй бүс нутгуудыг тодорхойлж, шинээр өргөдөл гаргагчдын түр хамгаалалтад хамрагдах боломжийг хязгаарласан. Гэвч Украин улсад Оросын халдлагаас ангид, аюулгүй бүс нутаг байсангүй.

Хавчлага мөрдлөгөөс зугтсан, эсхүл илүү сайхан амьдрал эрэлхийлж Европт цагаачлан ирсэн хүмүүсийн хамгаалалтад хүрэх боломжийг хязгаарлах, мөн тэдний амь нас, аюулгүй байдалд эрсдэл учирч болзошгүй нөхцөлд ч албадан буцаах зорилгоор зарим улс цагаачлалын хөдөлгөөнийг зохицуулах үүрэг хариуцлагаа өөр улсад шилжүүлэх бодлогыг санаатайгаар хэрэгжүүлэв. Зарим улс Европ руу чиглэн ирж буй ихэвчлэн хар арьст, лалын шашинт болон бусад ялгаварлагдсан бүлгийн хүмүүсийг эрх нь зөрчигдөж байгаа эсэхийг хянахад хүндрэлтэй бусад улс орнууд руу буцаах, саатуулах чиглэлээр хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулахыг оролдсон. Итали улс энэхүү хор хөнөөлтэй, хүний эрхийн ухралт бүхий санаачилгыг манлайлж, хууль эрх зүйн маргааныг үл харгалзан Албани дахь шилжин суурьшигчдын саатуулах төвүүдийг улам өргөжүүлсэн. Засгийн газар өргөн хүрээний эдийн засгийн хүндрэл бэрхшээлийн гол бурууг дүрвэгсэд, цагаачидтай холбон тайлбарлаж, аюултай, хор хөнөөлтэй үг хэллэгийг ашигласан. Грек, Итали, Мальта зэрэг улсын эрх баригчид далай болон хуурай газраар тус улсад нэвтрэх эрсдэлийг зориудаар нэмэгдүүлж, аврах ажиллагааг саатуулж, хүмүүнлэгийн аврагчид, ажилтнуудын үйл ажиллагаанд саад учруулж, тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авсан.

**Засгийн газрууд орогнол хүсэгчид, дүрвэгсэд болон цагаачдын эрхийг хамгаалж, олон улсын эрх зүйгээр хамгаалагдсан эрхүүдийг бүрэн хэрэгжүүлж, дур зоргоор саатуулах үйл ажиллагааг таслан зогсоох шаардлагатай.**

## **БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ**

Дани болон Гринланд улсын удирдагчид 1966 оноос 1990-ээд он хүртэлх хугацаанд өөрсдийнх нь зөвшөөрөлгүйгээр мянга мянган инуит эмэгтэйчүүдэд жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл суулгасныхаа төлөө хамтарсан уучлал гуйсан мэдэгдэл гаргасан. Иргэний нийгмийн байгууллагууд энэхүү алхмыг сайшаан хүлээн авсан хэдий ч инуит эмэгтэйчүүдэд зохих санхүүгийн нөхөн төлбөр олгохыг шаардсан.

Дани, Фарерын арлууд, Норвеги болон Их Британи улс үр хөндөлтийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг баталсан. Люксембург улс үр хөндөлтийг Үндсэн хуулиар баталгаажсан эрх чөлөө болгон тусгасан бол Европын парламент Европын Холбооны хэмжээнд аюулгүй үр хөндөлтийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хамтарсан механизмыг дэмжсэн саналыг өгсөн. Гэвч бүс нутаг даяар үр хөндөлтийн тусламж үйлчилгээний хүртээмжийг хязгаарлах олон талт бэрхшээл, эрүүгийн хариуцлага оногдуулах явдал үргэлжилсээр байв. Хорват, Итали, Португал, Испани зэрэг хэд хэдэн улсад эрүүл мэндийн ажилтнууд ёс суртахууны шалтгаанаар үр хөндөлт хийхээс татгалзах тохиолдол ихээхэн нэмэгдсэн нь хүний эрх, эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулсан.

**Засгийн газрууд бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг ялгаварлан гадуурхалгүйгээр хүн бүрд баталгаажуулж, аюулгүй үр хөндөлтийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй, саадгүй авах баталгааг хангах үүрэгтэй.**

## **ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХ**

Амьжиргааны өртөг өссөнөөс үүдсэн сөрөг нөлөөллийг засгийн газрууд бууруулж чадаагүйгээс сая сая хүн ядууралд өртөж, ядуу амьдарсан хэвээр байв. Их Британи, Финланд зэрэг хэд хэдэн улс оронд орон гэргүйдэлт нэмэгдэх, эрүүл мэнд болон бусад зайлшгүй шаардлагатай үйлчилгээ авах боломжийг хязгаарлах хүний эрхийн хамгаалалтаас ухарсан бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Энэ нь дүрвэгсэд, цагаачид зэрэг арьс үндсээр ялгаварлагдан гадуурхагдсан, эсхүл архаг өвчтэй хүмүүс зэрэг эмзэг байдалд байгаа хүмүүс илүү сөргөөр нөлөөлсөн.

Их Британи, Серби улсыг оролцуулан зарим засгийн газрууд нийгмийн хамгаалал болон бусад халамжийн дэмжлэгийг олгох эсэхийг шийдвэрлэхдээ уг мөн чанараараа ялгаварлан гадуурхсан алгоритм, технологийг нэвтрүүлсний улмаас арьс үндсээр ялгаварлагддаг хүмүүс, гадаадын иргэд, өрх толгойлсон эхчүүд, цыган хүмүүс зэрэг мянга мянган хүн нийгмийн халамжаас хасагдсан.

**Засгийн газрууд хүн бүрийг ялгаварлан гадуурхалгүйгээр эдийн засаг, нийгмийн эрхээ эдлэх боломжийг хангахын тулд хангалттай нөөцийг яаралтай хуваарилах шаардлагатай. Тэд нийгмийн халамжид хамрагдах боломжийг тодорхойлж, шийдвэр гаргахдаа ялгаварлан гадуурхсан алгоритмд үндэслэх явдлыг зогсоож, бүх нийтийг хамарсан, иж бүрэн нийгмийн хамгааллын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.**

## **ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ**

Хүний эрх болон жендэрийн эсрэг санхүүгийн хангалттай нөөц бүхий сүлжээ улам идэвхжиж бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүс, трансжендер хүмүүсийн эрхийг үгүйсгэхэд чиглэсэн хор хөнөөлтэй үг хэллэг, үзэл санааг улам бүр гүнзгийрүүлэв. Словак улс Үндсэн хуульдаа ЛГБТИ хүмүүсийн эрхийг улам дордуулах нэмэлт, өөрчлөлт оруулах алхам хийсэн бол Туркийн эрх баригчид ЛГБТИ хүмүүс болон тэдний эрхийг хамгаалан тэмцэгчдийг эрүүгийн хариуцлагад татах боломжтой хууль эрх зүйн өөрчлөлтийг санал болгосон. Унгар болон Турк улс ЛГБТИ хүмүүсийн жагсаал цуглааныг хориглосон.

Чех улс 11 дүгээр сард цыган хүүхдүүдийг нийгмийн эмзэг байдалд нь үндэслэн тусгай сургуульд сургадаг ялгаварлан гадуурхалтыг арилгах зорилготой шинэ арга хэмжээг нэвтрүүлсэн боловч Чех болон Словакийн сургуулиудад Цыган хүүхдүүдийг

ялгаварлан тусгаарласан хэвээр байв. Словенийн Засгийн газар онц байдлын үеийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг яаравчлан баталж, гүйцэтгэх засаглал болон цагдаагийн байгууллагын эрх мэдлийг өргөжүүлэх, тандалтыг нэмэгдүүлэх, нийгмийн халамжийн хязгаарлалтыг тогтоосон нь цыган хүмүүст илүү сөргөөр нөлөөлсөн. Бус нутаг даяар арьс үндсээр ялгаварлагдан гадуурхагдсан бүлгийн хүмүүс, цыган, ЛГБТИ, исламын болон еврейн шашинт хэмээн үзэгдэж буй хүмүүсийн эсрэг бие махбодын хүчирхийлэл, доромжилсон үг хэллэг онцгой анхаарал хандуулах түвшинд хүрсэн. Шашны мөргөлийн газруудад халдсан олон тохиолдол бүртгэгдсэн. Их Британид болсон халдлагын үеэр хоёр мөргөлч амь насаа алдсан бөгөөд 7-10 дугаар сарын хооронд 27 сүм халдлагад өртсөн нь хүний эрхийн эсрэг бүлгүүдтэй холбоотой кампанит ажил болон орогнол хүсэгчдийг байршуулж болзошгүй газруудын гадна болсон эсэргүүцлийн жагсаалуудтай давхацсан хугацаанд өрнөсөн.

Австри, Хорват, Герман, Польш, Серби зэрэг улсад ЛГБТИ хүмүүсийн эсрэг халдлага нэмэгдсэн. Спорт, боловсролын салбарт лалын шашинт охид, эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалт үргэлжилсэн хэвээр байв. Франц улсад бүх төрлийн спортын тэмцээнд шашны хувцас өмсөхийг хориглох тухай хуулийн төслийг хэлэлцсэн бол Австрийн парламент 14-өөс доош насны охидыг сургуульд хижаб өмсөхийг хориглосон хууль баталсан. Португалын парламент нүүр халхлах хувцсыг хориглох асуудлыг хэлэлцэж эхэлсэн нь зарим исламын шашинт эмэгтэйчүүдийн эрх чөлөөг хязгаарлах эрсдэлд хүргэж болзошгүй байна.

**Засгийн газрууд хууль эрх зүй, бодлогын шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх замаар ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс ангид амьдрах хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, дэмжих, баталгаажуулах үүрэгтэй.**

## **ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ**

Уур амьсгалын өөрчлөлт нь бүс нутаг даяар хор уршиг учруулсан хэвээр байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн хор уршиг бүс нутаг даяар үргэлжилсээр байв. Грек, Португал, Испанид хэт халалт, ой хээрийн түймэр, үерийн гамшиг улам нэмэгдэж, урьд өмнө байгаагүй олон тооны хүний амь нас хохирч, газар нутаг, эд хөрөнгө сүйдсэн.

Европын улс орнууд уур амьсгалын өөрчлөлтөөс сэргийлэх чиглэлд харилцан адилгүй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Зарим улс уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах хүчтэй бодлогоор манлайлан ажилласан бол зарим улсын хүлэмжийн хийн ялгаруулалтын зорилтот түвшин олон улсын түвшинөөс хэт доогуур байв. Сэргээгдэх эрчим хүч болон “ногоон” технологид шилжих үйл явц нь бүхий л тохиолдолд хүний эрхэд нийцсэнгүй. Швед, Норвеги, Финланд улс газар ашиглалтын төслүүдийг эхлүүлэхээс өмнө хангалттай хамгаалах, утга учиртай зөвлөлдөх үйл явцыг хангаагүй нь саамийн уугуул иргэдийн амьжиргаа, соёлд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх аюул заналхийллийг бий болгосон.

Европын Холбооны Чухал ашигт малтмалын тухай хууль нь саамийн уламжлалт нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагааг эрчимжүүлэх боломжийг бүрдүүлж, улмаар тэдний эрхэд учрах заналхийллийг улам нэмэгдүүлсэн.

**Засгийн газрууд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах чиглэлээр тогтоосон олон улсын зорилтуудыг чанд мөрдөх замаар уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын ноцтой эрсдэл, сөрөг нөлөөллөөс хувь хүн, бүлгийг хамгаалах шаардлагатай.**

## **ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИД**

Хүний эрх хамгаалагчид, ялангуяа эмэгтэй хүний эрх хамгаалагчид болон Европт хүрэхийн тулд аюултай арга замаар зорчиж байгаа дүрвэгсэд, цагаачдын эрхийг хамгаалагчид жилийн турш аюул, эрсдэлд өртөв. Польш улсад хүний эрхийн идэвхтэн Жустына Вьедрижинска жирэмсэн эмэгтэйд үр хөндөлтийн эм авах боломж

олгосон хэргээр дахин шүүхэд татагдав. Грек улсад дүрвэгсэд, цагаачдад тусламж үзүүлсэн 24 хүмүүнлэгийн ажилтан 20 хүртэлх жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэгдэх эрүүгийн хэрэгт шүүгдэгчээр татагдсан. Турк улс хүний эрх хамгаалагчдын эсрэг үндэслэлгүй мөрдөн шалгах ажиллагаа, яллагдагчаар татах болон ял шийтгэх үйл ажиллагааг эрчимжүүлж, Үндсэн хуулийн шүүх болон Европын хүний эрхийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрүүдийг үл биелүүлж, үзэл санааны хоригдлуудыг суллах үүргээ биелүүлээгүй хэвээр байв.

**Засгийн газрууд хүний эрх хамгаалагчдыг гутаан доромжлох, эрүүгийн хариуцлагад татахын оронд тэдний чухал үүргийг хүлээн зөвшөөрч, хамгаалах ёстой.**

# ОЙРХ ДОРНОД БОЛОН ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

2025 онд бүс нутгийн хэмжээнд зэвсэгт мөргөлдөөн, дарангуйлал, эдийн засаг, нийгэм, уур амьсгалын хямрал, Израил улсын эзлэгдсэн Газын зурвас дахь палестинчуудын эсрэг үйлдсэн төрлөөр устгах гэмт хэрэг нь бүс нутгийн сая сая хүний амьдрал, ялангуяа нийгэм, эдийн засгийн эмзэг бүлэгт ноцтой үр дагавар учруулсан.

Израил улс Газ дахь палестинчуудын эсрэг дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, төрлөөр устгах зэрэг олон төрлийн гэмт хэрэг үйлдсэн. Төрлөөр устгах үйл ажиллагааг 10 дугаар сарын 9-ний гал зогсоох хэлэлцээрийн дараа ч үргэлжлүүлсэн хэвээр байв. Израил улс Газын зурвас дахь бараг бүх орон сууц, түүхэн барилга байгууламж, иргэний дэд бүтцийг устгах, ноцтой гэмтээх замаар палестинчуудыг амьдрах ямар ч боломжгүй болгох нөхцөлийг санаатайгаар бий болгосон. Эдгээрт 18 жилийн турш үргэлжилсэн бүслэлтийг чангатгах, палестинчуудын хүмүүнлэгийн тусламж болон суурь хэрэгцээний бараа, үйлчилгээ авах боломжийг системтэйгээр хаах, хүмүүнлэгийн хямралыг зориудаар бий болгох зэрэг багтана. Газ дахь 2 сая палестинчуудын дийлэнх нь хууль бус албадан нүүлгэлт, өлсгөлөнд нэрвэгдэж, зохистой эрүүл мэндийн үйлчилгээ, орон байртай байх эрхээ алдсан.

Израил улсын Иран, Ливан, Катар, Сири, Йеменд хийсэн цэргийн ажиллагааны улмаас энгийн иргэд амь насаа алдаж, шархадсан. Түүнчлэн Израилын довтолгооны улмаас Өмнөд Ливанд энгийн иргэдийн өмч хөрөнгө өргөн хүрээнд сүйдсэн. Палестинчуудын эсрэг Израилын апартеид тогтолцоо нь Зүүн Иерусалим болон эзлэгдсэн Баруун эрэгт цэргийн эрчимжүүлсэн ажиллагаа, Израил иргэдийн үйлдэж буй төрийн дэмжлэгтэй хүчирхийлэл эрс нэмэгдсэнээр палестинчуудын амьдралд ноцтой нөлөөлсөн.

Израилын үйлдсэн төрлөөр устгах гэмт хэргийн эсрэг олон нийтийн эсэргүүцлийн жагсаал дэлхий даяар өрнөсөн. Олон улсын байгууллагууд, улс орнууд, янз бүрийн байгууллагууд Израил улс төрлөөр устгах гэмт хэрэг явуулж байгааг хүлээн зөвшөөрсөн. Гэвч дэлхийн улс орнууд үүнийг таслан зогсоох, Израилын хууль бус эзлэн түрэмгийллийг эцэс болгох талаар бодитой, үр нөлөөтэй арга хэмжээ авсангүй.

Бүс нутгийн хэмжээнд засгийн газрууд, төрийн бус зэвсэгт бүлэглэлүүд шүүмжлэлт дуу хоолойг боомилж, дарангуйллыг улам ихээр ашигласан. Эрх баригчид шүүмжлэгчид, улс төрийн өрсөлдөгчдийг саатуулах, цагдан хорих, эрүүдэн шүүх, үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэгт яллах, цаазаар авах ял гэх зэрэг хатуу ял шийтгэл оногдуулсан. Эдгээрт сэтгүүлчид, улс төрийн шүүмжлэгчид, хүний эрх хамгаалагчид, эмэгтэйчүүдийн эрхийн идэвхтнүүд, үйлдвэрчний эвлэлийн гишүүд ихэвчлэн өртсөн.

2024 оны сүүлээр Сири улсад Ассадын дэглэм унаснаар иргэний нийгмийн орон зайг нээх, шилжилтийн үеийн шударга ёсны үйл явцыг эхлүүлэх боломж бүрдсэн. Гэвч шашны тээлд суурилсан аллагад хариуцлага тооцох, иргэний нийгмийн байгууллагуудын хөгжих орчныг бүрдүүлэхэд томоохон сорилт тулгарсан хэвээр байв.

Жендэр, арьс өнгө, үндэс угсаа, угсаа гарвал, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэл, нийгмийн анги давхарга зэрэг үндэслэлээр ялгаварлан гадуурхах нь бүс нутгийн сая сая хүний амьдралд сөргөөр нөлөөлсөн. Зарим улсад дүрвэгсэд, орогнол хүсэгчид, цагаачдын эсрэг

**хүний эрхийн зөрчил улам нэмэгдсэн.**

**Уур амьсгалын хямралын ноцтой үр дагаварыг үл харгалзан бүс нутгийн шатамхай түлш үйлдвэрлэлээр тэргүүлэгч улс орнууд олборлолтын хэмжээгээ хэвээр хадгалж, нэмэгдүүлсээр байв.**

## **ТӨРЛӨӨР УСТГАХ ГЭМТ ХЭРЭГ**

Израил улсын Газын зурвас дахь палестинчуудын эсрэг явуулж буй төрлөөр устгах үйл ажиллагаа 2025 оны турш үргэлжилж, бараг бүх хүн амыг албадан шилжүүлэх, сүйрлийн үр дагавар бүхий цэргийн бөмбөгдөлт, иргэний өмч болон дэд бүтцийн өргөн хүрээний сүйтгэлээс гадна шаардлагатай хүмүүнлэгийн тусламж авах боломжийг хязгаарласан хэвээр байв.

Израил улс нэгдүгээр сарын 19-нд байгуулсан гал зогсоох хэлэлцээрийг гуравдугаар сард нэг талын санаачилгаар цуцалж, Газад явуулсан цэргийн эрчимжүүлсэн довтолгоо улам нэмэгдсэн. Харин аравдугаар сард байгуулсан гал зогсоох хэлэлцээр нь Палестины зэвсэгт бүлэглэлүүдийн барьцаанд байсан 20 хүн, мөн Израилын талд хоригдож байсан 2000 орчим палестин хоригдол, цагдан хоригдсон хүмүүсийг чөлөөлөхөд хүргэсэн. Гэвч Израилын цэргийн ажиллагаа үргэлжилж, гал зогсоох хэлэлцээр болон он дуусах хүртэл дахин 415 палестин иргэнийг хөнөөсөн.

2025 онд Израил улс Газад нийт 26,791 палестин хүнийг хөнөөж, 64,065 хүнийг шархдуулсны 60 хувь нь хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настнууд байв. Израилын зэвсэгт хүчин хүн ам ихээр төвлөрсөн иргэний объектууд болох кафе, зах, худалдааны төв, албадан нүүлгэн шилжүүлсэн хүмүүсийг байршуулсан сургуулиудыг онилсон.

Ялангуяа гуравдугаар сарын 18-ны өдөр Газын зурвас даяар явуулсан олон тооны дайралтын улмаас үлэмж хэмжээний хохирол учирч хамгийн багадаа 414 палестин хүн амь үрэгдсэний 174 нь хүүхэд байв. Гуравдугаар сарын 23-нд Израилын хүчнийхэн хүмүүнлэгийн тэмдэг бүхий тээврийн хэрэгслүүд, тэр дундаа таван түргэний машинд халдаж, Улаан хавирган сар нийгэмлэгийн эмнэлгийн ажилтнууд зэрэг нийт 15 тусламжийн ажилтныг хөнөөсөн. Зургаадугаар сарын 30-нд Израилын арми олны хөл ихтэй Ал-База кафег бөмбөгдсөний улмаас энгийн иргэд голдуу 32 хүнийг хөнөөсөн.

Израилын гаргасан шийдвэр болон олон тооны сууринг сүйтгэсний улмаас үүссэн өргөн хүрээний албадан нүүлгэн шилжүүлэлт нь палестинчуудын бие махбодь, сэтгэл зүйд ноцтой хохирол учруулсан. Тавдугаар сард Израил улс цэргийн зайлшгүй ажиллагаа хийх шаардлага үүсээгүй байхад өмнөд хэсгийн Хуза хотыг хайр найргүй бөмбөгдөж 11,000 орчим палестинчууд орон гэргүй болсон. Есдүгээр сарын 5-нд Израил улс Газ хот даяар орон сууцны болон худалдааны өндөр барилгуудыг нураах кампанит ажил эхлүүлж, 10 хоногийн дотор хамгийн багадаа 16 өндөр барилгыг нурааж, ойролцоох түр суурьшлын лагериудыг сүйтгэсэн нь олон мянган гэр бүлийг дахин нүүн шилжихэд хүргэсэн.

Газад хүмүүнлэгийн хямралыг бий болгоход чиглэсэн бодлого нь Израилын төрлөөр устгах ажиллагааны нэг хэсэг юм. Наймдугаар сарын дунд үе гэхэд Газ дахь хагас сая гаруй палестинчууд өлсгөлөнд нэрвэгдэж, өлсгөлөнгийн хамгийн ноцтой түвшинд орсон бол 1.4 сая хүн өлсгөлөнгийн хоёр болон гуравдугаар түвшинд оржээ. НҮБ-ын Хүмүүнлэгийн асуудлыг зохицуулах албаны мэдээлснээр долдугаар сард л гэхэд хоол тэжээлийн цочмог дутагдалтай хүүхдүүдийн эмнэлэгт шинээр хэвтсэн тохиолдол 13,000-д хүрчээ. Гурав дахь жилдээ дараалан Израил улс шүүхэд гаргасан өргөдөл, гомдлыг үл хайхран Газын зурвасаас Баруун эрэг болон Израил руу эмнэлгийн журмаар өвчтөн шилжүүлэхийг бүрэн хориглосны зэрэгцээ гадаад улс руу эрүүл мэндийн шалтгаанаар явахыг хатуу хязгаарласны улмаас урьдчилан сэргийлэх боломжтой нас баралтууд бүртгэгдсэн.

Гуравдугаар сарын 2-ноос тавдугаар сарын 19-ний хооронд Израил улс Газад бүрэн бүслэлт тогтоосон. Тавдугаар сарын 19-нөөс хойш энэхүү бүслэлтийг түр

хугацаагаар сулруулсан хэдий ч түлш, ахуйн хий зэрэг нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг оруулахыг хориглосон хэвээр байв. Гуравдугаар сарын 9-нд Израилын эрх баригчид Газ дахь хамгийн сүүлийн давсгүйжүүлэх үйлдвэрийн цахилгааныг тасалсан. Түлшгүй болсны улмаас цахилгаан үүсгүүрүүд зогсож, эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг ашиглах боломжгүй болсон. 5 дугаар сарын сүүл үеэс 8 дугаар сарын хооронд Газын Хүмүүнлэгийн Сангийн хэрэгжүүлсэн цэрэгжсэн тусламж түгээх хөтөлбөрөөс тусламж авахыг оролдож байсан дор хаяж 859 палестин иргэн Израилын зэвсэгт хүчин болон тэдний аюулгүй байдлын 0 гэрээт гүйцэтгэгчдийн гарт амь насаа алдсан.

Израил палестинчуудын соёл, шашин, эрүүл мэнд, боловсролын байгууламжуудыг өргөн хүрээнд сүйтгэсэн. Израилын арми Газ дахь бүх их, дээд сургуулиуд, олон зуун исламын сүм хийд, гурван христийн сүмийг устгасан. Ихэнх сургуулиудыг албадан нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүсийн түр хоргодох байр болгон ашигласан хэдий ч Израилын агаарын цохилт болон алсаас удирддаг тэслэгэний “робот”-ын довтолгоонд өртсөн байна. Израилын зэвсэгт хүчин эмэгтэйчүүдийн эрүүл мэнд болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн байгууллагуудыг устгаж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хаасан.

2025 оны эцсийн байдлаар Израилын цэргийн хүчин Газын зурвасын 58 хувийг эзлэн бүрэн хяналтдаа авсан. Эмнести Интернэшнлийн зүгээс “10 дугаар сарын гал зогсоох хэлэлцээрийн дараа Газад амьдрал хэвийн байдалдаа орж байна гэх ноцтой төөрөгдөл” байгааг анхааруулж, “дэлхий нийтээр хууртаж, итгэж болохгүй. Израилын геноцид хараахан зогсоогүй” хэмээн мэдэгдсэн.

**Израил улс хүмүүнлэгийн тусламжийг саадгүй нэвтрүүлэх хууль ёсны үүргээ биелүүлэх, хууль бус бүслэлтээ бүрэн цуцлах, Олон улсын шүүхийн зөвлөмж дүгнэлтүүдэд дурдсаны дагуу хууль бус цэргийн ажиллагаагаа татан буулгах зэргээр Газ дахь Палестинчуудын эсрэг үйлдэж буй төрлөөр устгах үйл ажиллагааг зогсоох шаардлагатай.**

## АПАРТЕЙД

Израил улс Палестинчуудын эрхийг хянаж, тэдний эсрэг дарлал, ноёрхлын апартеид тогтолцоог хэвээр үргэлжлүүлэв. Израилын хууль, бодлого, үйл ажиллагаа нь Палестинчуудыг газарзүйн болон улс төрийн хувьд салангид байлгаж, олонх нь ядууралд өртөж, байнгын айдас, аюултай байдалд амьдрахад хүргэсэн. 2025 онд НҮБ-ын Олон улсын Хүмүүнлэгийн асуудлыг зохицуулах албаны тооллогоор Палестинчуудын тосгон, хот хоорондын хөдөлгөөнийг саатуулж, яаралтай тусламжийн үйлчилгээ авахад саад учруулж байгаа Баруун Эргийн 849 зам хаалт, шалган нэвтрүүлэх цэг байв.

Израилын эрх баригчид байшин барилгуудыг нурааж, Палестинчуудыг орон гэргүй болгосон тоо 2009 оноос хойш хамгийн өндөр түвшинд хүрсэн болохыг Хүмүүнлэгийн асуудлыг зохицуулах алба мэдээлсэн. Израилын эзлэн түрэмгийллийг эсэргүүцдэг Еш Дин байгууллагын мэдээлснээр, хууль бус гэгдэх одоо байгаа 371 суурингаас гадна шинээр 86 хууль бус гэгдэх суурьшлын бүс нэмэгдсэн ба 54 шинэ сууринг баталжээ.

Израилын оршин суурьшигчдын Палестинчуудын эсрэг халдлага, зандалчлах үйлдлийг Израилын цэргийн хүчин, төрийн албан тушаалтнууд дэмжиж, хууль бус үйлдэлд хариуцлага хүлээлгээгүйн зэрэгцээ зарим тохиолдолд цэргүүд тэдний хууль бус хүчирхийлэлд оролцож, Израилын суурьшигчдыг хамгаалсан. Энэ мэт халдлага нь Баруун Эргийн 19 тосгоны ойролцоогоор 220 гэр бүл нутаг орноосоо дайжихад хүргэсэн талаар Израилын хүний эрхийн Бцелем байгууллага мэдээлжээ. Өмнөд Хеброны Жинба болон Ши'б аль-Бутум зэрэг тосгонд удаа дараа халдсан. 2025 оны эхний 10 сард Израилын оршин суугчид 1,600 гаруй хүчирхийллийн халдлага үйлдсэнийг Олон улсын Хүмүүнлэгийн асуудлыг зохицуулах алба тэмдэглэжээ.

Жилийн туршид Израилын цэргийн хүчний Баруун Эргийн хойд хэсэгт хийсэн

агаарын довтолгоо зэрэг эрчимжүүлсэн дайралт нь олон арван Палестинчуудын амь насанд аюул учруулж, гэр орон, дэд бүтэц сүйдэж, ялангуяа дүрвэгсдийн лагерьт амьдарч байсан олон мянган хүнийг орон гэргүй болгосон. Арван нэгдүгээр сарын сүүлээр цацагдсан дүрс бичлэгт Женин хотод Израилын цэргүүд бууж өгсөн хоёр Палестин эрэгтэйг шүүхээс гадуур цаазлан хороосон.

Израилын засгийн газрын өндөр албан тушаалтнууд Палестинчуудын эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг, тухайлбал дур зоргоор баривчлах, Израилын хорих газруудад хоригдож буй хүмүүсийг эрүүдэн шүүх, бусад зүй бусаар харьцах, тухайлбал хүчиндэх болон бэлгийн хүчирхийлэл үйлдэх, мөн хоол хүнс, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг суурь эрхийг нь хасах явдлыг магтан сайшааж, зөвтгөсөөр байв. “Израилын Хүний Эрхийн Төлөө Тэмцэгч Эмч” байгууллагын мэдээлснээр, 2023 оны 10 дугаар сараас 2025 оны 11 дүгээр сарын хооронд Израилын хорих ангид хамгийн багадаа 98 Палестин хүн нас баржээ.

Израилын өмнөд Негев/Накабын Бедуин тосгонд, Израилын эрх баригчид еврей иргэдийн суурьшлыг өргөжүүлэхийн тулд ойролцоогоор Палестинчуудын 5,000 орчим орон гэрийг нураасан. Израилын цагдаа нар Ал-Сир дахь Палестины Бедуин тосгонд 60 гаруй орон сууц бусад байгууламжийг нурааж, 1,500 гаруй оршин суугчийг нүүлгэн шилжүүлсэн. 11 дүгээр сард Дээд шүүхээс албан ёсны бүртгэлгүй гэх шалтгаанаар Рас Жрабахын Палестины Бедуин тосгоны 500 гаруй оршин суугчийг нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг баталгаажуулсан.

**Эмнести Интернэшл улс орнууд, олон улсын хамтын нийгэмлэг болон компаниудыг Израил улсад үзүүлэх шахалтаа нэмэгдүүлж, өөрийн хяналтад байгаа бүх Палестинчуудын эсрэг хэрэгжүүлж буй апартеидын тогтолцоог эцэс болгох, мөн Эзлэгдсэн Палестины нутаг дэвсгэрт явуулж буй хууль бус эзлэн түрэмгийлээ зогсоох зэрэг олон улсын эрх зүйн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг уриалж байна.**

## ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН ЗӨРЧИЛ

Израил улс Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэрт явуулж буй цэргийн ажиллагаанаас гадна Иран, Ливан, Катар, Сири болон Йемен улсад хийсэн халдлагын улмаас энгийн иргэдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан.

Израил улс 6 дугаар сарын 13-нд Ираны эсрэг 12 хоног үргэлжилсэн довтолгоо эхлүүлж, иргэний дэд бүтцийг сүйтгэж, 1,100 гаруй хүний амь насыг хохироосны дотор 45 хүүхэд байв. 6 дугаар сарын 23-нд Израилын цэргийн хүчнийхэн нийслэл Тегеран хот дахь Эвин хорих газрыг бөмбөгдсөний улмаас дор хаяж 80 энгийн иргэн амь үрэгдэж, хорих газрын байр их хэмжээгээр сүйдсэн. Энэхүү халдлага нь мөрдөн шалгах шаардлагатай олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчсөн дайны гэмт хэрэг байж болзошгүй. Үүний хариуд Иран улс Израил руу пуужин, дрон, хууль бусаар кластер зэвсэг ашигласны улмаас дор хаяж 29 хүн нас барсны зарим нь хүүхдүүд байв.

9 дүгээр сарын 9-нд Катар улсын нийслэл Доха хотод гал зогсоох хэлэлцээ явагдаж байсан орон сууцны цогцолборт Израил улс агаарын цохилт өгсний улмаас зургаан хүн амь үрэгдсэн.

2024 оны 11 дүгээр сард Израил болон Хезболла зэвсэгт бүлэглэл хооронд гал зогсоох хэлэлцээр байгуулсан хэдий ч Израил улс Ливанд цэргийн довтолгоогоо үргэлжлүүлэн их хэмжээний сүйрэл учруулсан. Гал зогсоох хэлэлцээрээс хойш 2024 оны 11 дүгээр сараас 2025 оны 9 дүгээр сарын хооронд 103 энгийн иргэн амь үрэгдсэн хэмээн НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын газраас мэдээлсэн.

Израилын зэвсэгт хүчин гал зогсоох хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө болон түүний дараа 2024 оны 10 дугаар сараас 2025 оны 1 дүгээр сарын хооронд Ливаны өмнөд хэсэгт 10,000 гаруй иргэний барилга байгууламж, хөдөө аж ахуйн газрыг өргөн хүрээтэйгээр сүйтгэж, хохирол учруулсан болохыг Эмнести Интернэшл судалгаагаар тогтоожээ.

3 дугаар сарын 18-нд Йемен дэх Хути зэвсэгт бүлэглэл Израилын эсрэг пуужин, дрон ашиглан дахин халдлага явуулж эхэлсэн. Израил улс 5-9 дүгээр сарын хооронд Йемений хойд хэсгийн томоохон дэд бүтцүүдэд цохилт өгсний улмаас хэдэн зуун энгийн иргэн амь үрэгдэж, шархаджээ.

Йеменд үргэлжилж буй мөргөлдөөн эдийн засаг, хүмүүнлэгийн ноцтой хямралыг улам гүнзгийрүүлэв. Эмнести Интернэшнлийн баримтжуулснаар Йемений баруун хойд хэсэгт орших Саада хотын цагаачдыг саатуулах төв рүү АНУ-ын хийсэн агаарын дайралт нь дайны гэмт хэрэг байж болзошгүй тул мөрдөн шалгах шаардлагатай. Энэхүү халдлагын улмаас Хутигийн дефакто эрх баригчдын хорьж байсан Африкийн олон арван цагаач амь үрэгдэж, шархадсан.

2025 оны турш Сирид зэвсэгт мөргөлдөөн үе үе дахин эрчимжсээр байв. Өмнөх засгийн газартай холбоотой зэвсэгт бүлэглэлүүд 3 дугаар сарын 6-нд Алавит шашинтнууд зонхилон амьдардаг эргийн мужуудын аюулгүй байдал болон цэргийн объектууд руу халдсан. Үүний хариуд засгийн газраас зэвсэгт бүлэглэлүүдийн дэмжлэгтэйгээр явуулсан сөрөг дайралтад ойролцоогоор энгийн иргэд голдуу 1,400 хүн амь үрэгдсэний дотор Засгийн газрыг дэмжигч хүчнүүдийн Алавит нийгмийн бүлгийг шашны үзэлд үндэслэн хөнөөсөн аллага багтжээ.

7 дугаар сард Сирийн өмнөд хэсэгт Друз болон Бедуин зэвсэгт бүлэглэлүүдийн хооронд мөргөлдөөн үссэн. Засгийн газар Сувейда мужид хөндлөнгөөс нөлөөлсний улмаас засгийн газар, тэдний хамаарал бүхий зэвсэгт хүчнүүд 7 дугаар сард хоёр хоногийн хугацаанд 46 Друз эрэгтэй, эмэгтэйг шүүхийн бус журмаар цаазаар авсан болохыг Эмнести Интернэшнл баримтжуулсан. Мөн энэ хугацаанд Израил улс Сувейда мужид цохилт өгсөн бөгөөд мөргөлдөөнд оролцсон бусад бүлгийн үйлдсэн хүний эрхийн зөрчлийн талаарх баттай мэдээллийг Эмнести Интернэшнл хүлээн авсан. Үүнд, Друзын зэвсэгт бүлэглэлүүд хүмүүнлэгийн ажилтныг хулгайлсан хэрэг багтсан. Ливи улсын Триполи хотын оршин суугчид ихтэй суурьшлын бүсэд 5 дугаар сарын 12-нд сөргөлдөгч зэвсэгт бүлэглэлүүд дайтаж, зенитийн буу зэрэг том калибрын зэвсгийг зохисгүй байдлаар ашигласан. Триполи хотод байрладаг нэгэн төрийн бус байгууллагын мэдээлснээр уг мөргөлдөөний улмаас 53 энгийн иргэн амь үрэгдсэн.

**Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч бүхий л талууд олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэх ёстой бөгөөд ялангуяа энгийн иргэд болон иргэний дэд бүтцийг онилсон шууд, ялгаваргүй болон хэт их хор уршигтай халдлагуудыг зогсоох ёстой. Мөн гадаад улсын засгийн газрууд төрлөөр устгах болон олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн эрх зүйн эсрэг ноцтой зөрчил үйлдэхэд ашиглагдах өндөр эрсдэл байгаа тохиолдолд зэвсгийн нийлүүлэлтийг зогсоох шаардлагатай.**

## **ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ, ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ**

2025 онд бүс нутгийн хэд хэдэн улсад эрх баригчид хүний эрхийг өргөн хүрээнд боомилж, эсэргүүцэл шүүмжлэлийг бүх орчинд, түүний дотор цахим орчинд нухчин дарах дарангуйллын үйл ажиллагааг улам эрчимжүүлсэн.

Тунис улсын эрх баригчид хүний эрх хамгаалагчид, төрийн бус байгууллагуудын ажилтнуудыг онилох зэргээр эсэргүүцэл, шүүмжлэлийг дарангуйлах ажиллагааг гүнзгийрүүлэв. Засгийн газрыг шүүмжлэгчдийг терроризм эсвэл цахим гэмт хэрэгт холбогдуулан улс төрийн зорилгоор олноор нь хариуцлагад татсан. Тунис улсын давж заалдах шүүхээс 11 дүгээр сард шударга ёсны шаардлагад нийцээгүй шүүх ажиллагаа явуулж “Хуйвалдаан зохион байгуулсан” хэрэгт холбогдсон сөрөг хүчний улс төрчид, хүний эрх хамгаалагчид, идэвхтнүүдэд оногдуулсан 45 хүртэлх жилийн хорих ялыг хэвээр үлдээв. Тушаалын тухай 54 дүгээр хуулийг сэтгүүлчид, нийгмийн сүлжээ хэрэглэгчид, хуульчид, уран бүтээлчид, идэвхтнүүдийн эсэргүүцэл,

шүүмжлэлийг нухчин дарах хэрэгсэл болгон ашигласан. Египет улсын эрх баригчид хараат бус иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагыг боомилж, засгийн газрыг шүүмжлэгчдийг шийтгэсээр байв. Аюулгүй байдлын хүчнийхэн сэтгүүлчид, судлаачид болон эсэргүүцэгчдийг дур зоргоор баривчилж, хүчээр алга болгож, тусгаарлан цагдан хорьж, эрүү шүүлт тулгаж, бусад зүй бусаар харьцсан.

Персийн булангийн улс орнуудад эсэргүүцэл, шүүмжлэлийг өргөн хүрээнд ноцтой нухчин дарангуйлах үйл ажиллагаа үргэлжилсэн. Саудын Арабт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлаж, засгийн газрыг шүүмжлэгчид, хүний эрх хамгаалагчдыг шударга бусаар шүүж, удаан хугацаагаар хорих ял оногдуулж, зорчих эрхийг дур зоргоор хязгаарласан бөгөөд цаазаар авах ялаар шийтгэх нь нэмэгдсэн. Зэргэлдээх Оман улс Оман болон Султаныг “доромжилсон” хүмүүс, эсвэл Оманы ашиг сонирхолд “хохирол учруулсан” зарчмыг дэмждэг бүлэг, нам, байгууллагад харьяалагддаг хүмүүсийн иргэний харьяаллыг хасах шинэ хуулийг баталсан. Түүнчлэн хэвлэл мэдээллийн эрх чөлөөг улам хязгаарласан.

Ирак улсад эрх баригчид “ёс зүйгүй контент” болон “нийтийн ёс суртахуун”-ы зөрчлийн талаарх тодорхой бус хуулийн заалтыг шүүмжлэгчид, идэвхтнүүд, бие даасан хэвлэл мэдээллийн байгууллагын эсрэг ашигласан. 5 дугаар сард Йорданы Мэдээллийн хороо “хор уршигтай мэдээллийг түгээсэн, Йордан болон Йорданы үндэсний бэлгэдлийг доромжилсон” гэх үндэслэлээр орон нутгийн болон гадаадын 12 хэвлэл мэдээллийн сайтыг хаасан. Палестины Хөгжил, Мэдээллийн эрх чөлөөний төвийн мэдээлснээр Палестины цагдаагийн газраас 12 сэтгүүлчийг хэдэн цаг, цаашлаад хоёр долоо хоногийн хугацаанд цагдан хорьсон бөгөөд энэ хугацаанд тэднийг мэргэжлийн ажил, үйл ажиллагаатай холбогдуулан байцаажээ.

Бүс нутаг даяар эрх баригчид эсэргүүцлийн тайван жагсаал цуглааныг хориглох, хүчээр тараах зэргээр дарангуйлсан.

Алжирт 1, 2 дугаар сард ажилтнуудын эрхийг шаардаж тайван журмаар өрнөсөн эсэргүүцлийн жагсаалын үеэр цагдаа нар жагсагчдыг дур зоргоор баривчилсан. Тегеран хотод 12 дугаар сарын 28-нд эхэлж, улмаар асар хурдацтай улс орон даяар тархсан эсэргүүцлийн жагсаалын үеэр Исламын Бүгд Найрамдах засаглалын тогтолцоог түлхэн унагаахыг шаардсан ихэвчлэн тайван жагсагчдыг тараахын тулд аюулгүй байдлын хүчнийхэн винтов, металл сумтай буу, нулимс асгаруулагч хий болон бороохойг хууль бусаар ашигласны улмаас хүний амь нас эрсдэж, хүнд ноцтой бэртэл учруулсан. Палестинд Хамасын удирддаг аюулгүй байдлын албаныхан 3, 4 дүгээр сард Бейт Лахид өрнөсөн эсэргүүцлийн тайван жагсаалд оролцогчдыг дур зоргоор баривчилж, эрүүдэн шүүсэн.

**Засгийн газрууд үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван хуран цуглах эрхийг хүндэтгэж, сэтгүүлчид, хүний эрх хамгаалагчид, идэвхтнүүд эрүүгийн хариуцлага, дарамт шахалтад өртөхгүйгээр эдгээр эрхээ эдлэх боломжийг хангах, эдгээр эрхээ хэрэгжүүлснийхээ төлөө хоригдсон хүмүүсийг суллах ёстой.**

## ШУДАРГА БУСААР ШҮҮХ

Шударга бусаар шүүх болон хүний эрхийн бусад зөрчлүүд нь бүс нутгийн улс орнуудын эрүүгийн шүүхийн тогтолцоонд ноцтой нөлөөлсөн. Египет болон Ливид, удаан хугацаанд хоригдсон зарим хүмүүсийг сулласан хэдий ч олон мянган хүнийг хууль зүйн хангалттай үндэслэлгүйгээр эсвэл шударга бус шүүхийн шийдвэрээр дур зоргоор хорьсны зэргэцээ хүчээр алга болгох, эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах, гадаад орчинтой харилцах боломжгүйгээр цагдан хорих зэрэг зөрчлүүд үргэлжилсээр байв. Иранд шүүх эрх мэдлийн хараат бус байдал алдагдаж, хүчээр алга болгох, эрүүдэн шүүх зөрчилд хамтран оролцсон.

Түүнчлэн Тунис улсад шүүх эрх мэдэл мөн хараат бус байж чадаагүй бөгөөд шүүхүүд иргэдийг олноор нь шударга бусаар шүүж хүнд ял шийтгэл оноосон. Хоёрдугаар сард Тунисын анхан шатны шүүхээс “терроризм”-ын хэрэгт холбогдох

яллагдагчдыг шүүх хуралд зайнаас буюу хорих ангиас оролцуулахаар шийдвэрлэсэн. Улс төрийн сөрөг хүчний гишүүд болон хүний эрхийн зөрчлийн хохирогчдын өмгөөлөгчдийг “худал мэдээлэл тараасан” гэх мэт хилс хэрэгт холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгасан.

Иракийн Курдистаны бус нутагт нэр хүнд бүхий сэтгүүлч Шерван Шерванийг суллагдах байсан өдрөөс нь хэдхэн хоногийн өмнө наймдугаар сард үндэслэлгүйгээр буруутган дахин 4.5 жил хорих ялаар шийтгэсэн. Ийнхүү түүнийг дахин ялласан нь сэтгүүлчид, идэвхтнүүд, шүүмжлэгчдийн эсрэг шинэ хэрэг үүсгэх замаар хорих, цагдан хорих хугацааг шүүхийн журмаар сунгадаг тогтсон хэв маягийн нэг хэсэг юм.

Египетийн эрх баригчид шүүхээс өмнө урт хугацаагаар цагдан хоригдож байсан сэтгүүлчид, өмгөөлөгчид, хүний эрх хамгаалагчид болон бусад хүмүүсийг терроризмтой холбоотой хэрэгт буруутган эрүүгийн хэргийн шүүхийн терроризмын тусгай танхимд шилжүүлэн шүүх ажиллагааг үргэлжлүүлсэн. Эдгээр хэргийн ихэнх нь зөвхөн хүний эрхээ хэрэгжүүлсэнтэй холбоотой байсан. Энэ мэт шүүхүүд нь шударгаар шүүлгэх эрхийн хэм хэмжээг системтэйгээр зөрчсөн.

Йорданы орон нутгийн эрх баригчид “хүмүүст аюултай” гэсэн үндэслэлээр олон мянган хүнийг захиргааны журмаар хорьсон хэвээр байв. Тэднийг ямар нэгэн хэрэгт холбогдуулан буруутгаагүй бөгөөд цагдан хорьсон шийдвэрийн хууль ёсны эсэхийг шүүхээр хянуулах боломж олгоогүй.

Алжир улсын шүүх үндэслэлгүйгээр шүүхээс өмнө цагдан хорих, яллагдагчдыг өмгөөлөгчдөд нь мэдэгдэлгүйгээр шүүхэд авчрах, хэргийг хэт яаравчилсан журмаар хэлэлцэх зэргээр шударгаар шүүлгэх эрхийг удаа дараа зөрчсөн.

Иранд шүүх ажиллагаа системтэйгээр шударга бус явагдаж, цагдан хорих болон цаазаар авах ялыг дур зоргоор хэрэглэсэн. Шинээр баталсан Тагнуулын тухай хуулиар шударгаар шүүлгэх эрхийг улам дордуулсан.

**Эрх баригчид шударгаар шүүлгэх эрхийг баталгаажуулж, шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хүндэтгэж, өөр үзэл бодол, эсэргүүцлийг нухчин дарах зорилгоор шүүхийн тогтолцоог урвуулан ашиглахаас татгалзах ёстой.**

## ЦААЗААР АВАХ ЯЛ

2025 онд бус нутгийн ихэнх улсад цаазаар авах ялыг оногдуулсан.

Иран улсад олон арван жилийн хугацаанд байгаагүйгээр хамгийн олон хүнийг цаазалсан. Цаазаар авах ялыг улс төрийн дарангуйллын хэрэгсэл болгон ашиглах явдал нэмэгдсэн, мансууруулах бодистой тэмцэх хатуу бодлого зэрэг нь дээрх өсөлтөд шууд нөлөөлсөн. Хүмүүсийг олноор цаазалсан нь хорих газруудад тайван суулт, өлсгөлөн зарлах зэрэг эсэргүүцлийн арга хэмжээг өдөөсөн. “Завхайрах” үйлдлийг гэмт хэрэгт тооцож чулуугаар шидэж цаазлах явдал хэвээр үлдэв. Угсаатны цөөнхүүд цаазаар авах ялаар шийтгэгдэх эрсдэлд илүүтэй өртсөөр байв.

Саудын Араб улс мансууруулах бодис, “терроризм” гэх зэрэг олон төрлийн гэмт хэрэгт холбогдуулан хэдэн зуун хүнийг цаазалсан. Мансууруулах бодистой холбоотой хэргээр цаазлуулсан хүмүүсийн ихэнх нь шударгаар шүүлгэхийн тулд нэмэлт бэрхшээлтэй тулгардаг гадаадын иргэд байсан. “Терроризм”-ын хэргээр цаазлагдсан хүмүүсийн дотор шийт шашинт хүмүүсийн эзлэх хувь хэмжээ өндөр байв. Хуульд тодорхой заасан ялгүй, шүүгчийн үзэмжээр оноодог таазир төрлийн гэмт хэргүүдэд цаазаар авах ялыг ногдуулжээ. Саудын Араб улс хүүхэд байхдаа үйлдсэн хэрэгт холбогдуулан хоёр залууг цаазаар авсан.

Цаазаар авах ялыг мөн Египет, Ирак, Кувейт болон Арабын Нэгдсэн Эмират улсад хэрэглэсэн. Алжир, Кувейт зэрэг улсад мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт цаазаар авах ялын хэрэглээг өргөжүүлсэн.

**Засгийн газрууд цаазаар авах ялыг халах зорилгоор ялын гүйцэтгэлийг албан ёсоор нэн даруй түдгэлзүүлэх шаардлагатай.**

## ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХ

Зөрчил мөргөлдөөн, санхүүгийн дарамт, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртсөн, нийтийг хамарсан нийгмийн хамгааллын тогтолцоо бүрдээгүй тус бүс нутагт нүүрлэсэн эдийн засаг, нийгмийн өргөн хүрээний ноцтой хямрал нь иргэдэд ноцтой сөргөөр нөлөөлсөн. Төрийн үйлчилгээ, дэмжлэгийг хангалттай авч чаддаггүй, эрүүл мэнд, ус, орон сууц, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх зэрэг эдийн засаг, нийгмийн эрх нь зөрчигдсөн нөхцөлд амьдарч байсан хүмүүс дээрх хямралд хамгийн ихээр хохирол амссан. Нийгэм, эдийн засгийн эрхийнхээ төлөө тэмцсэн иргэд ихэвчлэн дарамт шахалтад өртөв.

Египет улсад ядууралд өртөж буй олон сая хүн шинэ хүндрэл, бэрхшээлтэй тулгарсан. Наймдугаар сард Египетийн эрх баригчид удаан хугацааны түрээсийн гэрээг цуцлах хууль баталж, бага орлоготой иргэдийн орон сууцны хүртээмжтэй байдалд заналхийлэх бусад арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Нэгдүгээр сард ажил хаялт зохион байгуулсан оёдлын үйлдвэрийн ажилчдыг баривчилж, ажлаас нь халсан.

Персийн булангийн улс орнууд зэрэг хэд хэдэн улсын засгийн газрууд бага цалинтай цагаач ажилтнуудыг хөдөлмөрийн мөлжлөг, бусад хүчирхийллээс хамгаалж чадаагүй бөгөөд тэдэнд бие даасан үйлдвэрчний эвлэл байгуулах эрхийг олгохоос татгалзсан.

2025 оны эхээр АНУ-ын засгийн газар гадаад улс орнуудад үзүүлэх тусламжаа гэнэт, хариуцлагагүйгээр зогсоосон нь хүмүүнлэгийн тусламжаас хэт хамааралтай энэхүү бүс нутгийн сая сая хүний эрүүл мэнд, хүний эрхэд ноцтой эрсдэл учруулсан. АНУ тусламжийн санхүүжилтээ танах шийдвэр гаргасны улмаас амь аврах чухал тусламж болон хамгааллын үйлчилгээ, тухайлбал хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн тэжээлийн дутагдлын эмчилгээ, жендэрт суурилсан хүчирхийллээс амьд үлдсэн хүмүүст зориулсан аюулгүй байр, мөн холера болон бусад өвчнөөр өвчилсөн хүүхдүүдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ зогсоход хүрсэн талаар Йеменд байгаа тусламжийн ажилтнууд Эмнести Интернэшнлд мэдээлсэн.

**Засгийн газрууд нийгмийн эмзэг бүлгүүдийг оролцуулан хүн бүрийг хоол хүнс, ундны ус, орон сууц, түүнчлэн эрүүл мэнд, боловсрол зэрэг суурь үйлчилгээний хүртээмжийг хангасан амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх боломж олгох, бүх нийтийг хамарсан нийгмийн хамгааллын тогтолцоог бүрдүүлж, иргэдийн эдийн засаг, нийгмийн эрхийг хангах шаардлагатай. Засгийн газрууд мөн ажилтнууд бие даасан үйлдвэрчний эвлэлд нэгдэх, байгуулах, ажил хаях эрхийг хүндэтгэх ёстой бөгөөд хөдөлмөрийн хууль тогтоомжийн хамгаалалтыг бүх цагаач ажилтнуудад тэгш хэрэгжүүлэх шаардлагатай.**

## ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Бүс нутгийн улс орнууд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн амь насанд аюул учруулах хор хөнөөл, цаг агаарын эрс тэс үзэгдэл, усны хомсдол, мөн байгаль орчны буруу менежментийн улмаас үүсэх сөрөг нөлөөллийг үргэлжлүүлэн амссаар байв. Иордан, Ливан, Марокко, Сири зэрэг улсад нүүрлэсэн усны ноцтой хямрал нь ундны цэвэр ус, эрүүл мэнд, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийг доройтуулж, ялангуяа хөдөө орон нутгийн иргэд, дүрвэгсэд болон бага орлоготой өрхүүдэд илүү их сөргөөр нөлөөлсөн.

Иран улсын эрх баригчид байгаль орчны доройтлыг шийдвэрлэх талаар хангалттай арга хэмжээ авч чадаагүй бөгөөд энэ нь нийгмийн эмзэг бүлгүүдэд илүү ихээр сөргөөр нөлөөлсөн. Энэхүү хямрал нь экосистемийн алдагдал, газрын доорх усны нөөцийн хомсдол, усны бохирдол, ой мод устгах, газрын суулт, усны нөөц буурах, хөрсний чанар алдагдах болон мянга мянган хүний нас баралтад нөлөөлсөн агаарын бохирдол зэрэг олон асуудлаар илэрч байв.

Түүнчлэн бүс нутгийн газрын тос, байгалийн хийн баялаг ихтэй улс орнуудын засгийн газрууд уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох, түүний хор нөлөөллийг бууруулах, хамгийн ихээр нөлөөлөлд өртөж хохирсон хүмүүст зохистой дэмжлэг үзүүлэх чиглэлд хангалттай арга хэмжээ авч чадсангүй. Бахрейн улс газрын тос, байгалийн хийн олборлолтоо нэмэгдүүлсэн бол Кувейт улс нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгаруулалтаараа дэлхийд хамгийн өндөр орнуудын нэг хэвээр байв. Катар улс шингэрүүлсэн байгалийн хийн дэлхийн томоохон экспортлогчдын нэг хэвээр байв. Саудын Араб нэг хүнд ногдох нүүрстөрөгчийн ялгаруулалтаараа дэлхийн эхний 10 орны тоонд багтсаар байсан.

Израил улсын Газын зурвас дахь сүйтгэлээс үүдсэн хорт бодисууд усны системээр тархаж байнгын бохирдол үүсгэв.

**Засгийн газрууд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах, мөн чулуужсан түлшний олборлолт болон хэрэглээг зогсоох зэргээр уур амьсгалын хямралыг бууруулах яаралтай арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.**

## **ДОТООДОО ШИЛЖИН СУУРЬШИГЧИД, ДҮРВЭГСЭД БОЛОН ЦАГААЧДЫН ЭРХ**

2025 онд үүссэн улс төр, хүмүүнлэг, эдийн засгийн ноцтой хямралын улмаас аюулгүй байдал эрэлхийлэн гэр орноо орхих хүмүүсийн тоо нэмэгдсэн бөгөөд олонх нь хүний эрхийн зөрчилд өртсөн. Ирак, Израил, Ливан, Ливи, Палестин, Сири болон Йемен улсад сая сая хүн дотооддоо дүрвэж шилжин суурьшив. Зарим улсад төрийн болон төрийн бус зэвсэгт бүлэглэлүүд шилжин суурьшигчдын эрхийг тогтмол зөрчсөөр байв. Ливи улс даяар аюулгүй байдлын хүчнийхэн, зэвсэгт бүлэглэлүүд, бусад төрийн бус оролцогчид дүрвэгсэд болон цагаачдын эсрэг өргөн хүрээтэй, системтэй хүний эрхийн зөрчил, хүчирхийлэл үйлдсээр байсан хэдий ч эдгээр зөрчилд хариуцлага хүлээлгэсэнгүй. Ливийн баруун хэсэгт Европын Холбооны дэмжлэгтэй эргийн хамгаалалтын алба, мөн зүүн Ливид байрлах Ливийн Арабын Зэвсэгт хүчний харьяа Тусгай тэнгисийн цэргийн хүчин болон Тарик Бен Зейяд зэвсэгт бүлэглэлүүд 25,000 гаруй хүнийг саатуулж, хүчээр Ливи рүү буцаасан нь өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлт байв.

Иракт дотооддоо шилжин суурьшсан 1 сая гаруй хүн амьдрах газаргүй удаан хугацаанд байсны улмаас амьдралын нөхцөл нь улам доройтож, олонх нь эрүүл мэндийн үйлчилгээ, ус, орон сууц зэрэг амин чухал үйлчилгээ авахад хүндрэлтэй тулгарсан. Иракийн Курдистаны бүсийн дотооддоо шилжин суурьшигчдын хуарангийн нөхцөл улам дордсон.

1.8 сая гаруй Афган иргэн, түүний дотор хараа хяналтгүй болон эцэг эхээсээ тусгаарлагдсан хүүхдүүдийг хууль бусаар албадан гаргаж, Афганистан руу буцаасан. Дүрвэгсдийг олноор нь албадан гаргах кампанит ажлын хүрээнд гэрт нь хүч хэрэглэн нэвтэрч, нэгжлэг хийж, гудамжинд шалгаж, дур зоргоор баривчлав. Иранд үлдсэн Афган иргэд өргөн хүрээтэй хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтад өртсөн.

Тунис улсын цагаачлал, орогнолын бодлого нь өргөн хүрээтэй хүний эрхийн зөрчил, ялангуяа хар арьст дүрвэгсэд, орогнол хүсэгчид болон цагаачдад ихээхэн нөлөөлсөн. Парламентын болон засгийн газрын зарим албан тушаалтнуудын олон нийтэд хандсан тайлбар, мэдэгдэл нь хар арьст цагаачдын эсрэг арьс үндсээр ялгаварласан хүчирхийллийг улам өдөөсөн. Албан тушаалтнууд дүрвэгсдийг Ливи болон Алжир улс руу амь насанд аюултай нөхцөлд хууль бусаар, олноор нь албадан гаргах ажиллагааг тогтмол явуулсан бөгөөд ингэхдээ далайд саатуулах, арьс үндсээр ялгаварлан баривчлах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх зэргээр эрүүдэн шүүж, бусад зүй бусаар харьцаж байв. Засгийн газар орогнол хүсэх боломжийг үргэлжлүүлэн хаасаар байсан нь орогнол хүсэгчид, дүрвэгсдийн эсрэг зөрчлийг улам нэмэгдүүлсэн.

Дөрөвдүгээр сараас эхлэн Алжирын аюулгүй байдлын хүчнийхэн хар арьст болон арьс үндсээр ялгаварлан гадуурхалтад цагаачид, орогнол хүсэгчид, дүрвэгсдийг

олноор нь баривчилж, албадан гаргах ажиллагааг нэмэгдүүлсэн. Тунис, Алжирын эрх баригчид тэднийг олноор нь албадан гаргасны дараа Ливи улс олон зуун дүрвэгсэд, цагаачдыг дур зоргоор баривчилсан. Тэдгээр иргэд болон Ливид саатуулагдсан бусад мянга мянган дүрвэгсэд, цагаачдыг тодорхой хугацаагүйгээр харгис, хүнлэг бус нөхцөлд цагдан хорьж, эрүүдэн шүүж, бусад хэлбэрээр зүй бус харьцсан.

**Эрх баригчид дүрвэгсэд, орогнол хүсэгчид болон цагаачдыг хууль бусаар саатуулах, албадан гаргах ажиллагааг зогсоож, буцаан шилжүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмуудыг хүндэтгэж, дотооддоо шилжин суурьшигчдыг сайн дурын үндсэн дээр, аюулгүй нөхцөлд гэр оронд нь буцаах боломжийг бүрдүүлэх ёстой.**

## ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

### ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮД

Охид, эмэгтэйчүүд чөлөөтэй зорчих, үзэл бодлоо илэрхийлэх, бие махбодын бие даасан байдал, өв залгамжлал, гэрлэлт цуцлалт, улс төрийн албан тушаал эрхлэх болон хөдөлмөр эрхлэх харилцаанд хууль тогтоомж болон практикийн ялгаварлан гадуурхалтад өртсөөр байв. Эмэгтэйчүүдийн амь насыг нь хороох зэрэг жендэрт суурилсан хүчирхийлэл түгээмэл хэвээр байсан хэдий ч эрх баригчид эдгээр гэмт хэрэгт ял завших байдлыг арилгах талаар системтэй арга хэмжээ авч чадсангүй.

Ирак улсын парламент гэрлэлт, гэрлэлт цуцлалт зэрэг гэр бүлийн эрх зүйн харилцаанд шашны бүлгийн эрх мэдлийг нэмэгдүүлснээр шашин хоорондын хуваагдлыг гүнзгийрүүлж, эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөх эрсдэлийг нэмэгдүүлсэн. Мөн гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох, түүнчлэн Эрүүгийн хуулинд заасан ялгаварлан гадуурхсан заалтууд, тухайлбал “нэр төрийн” гэх аллагад ял хөнгөрүүлэх болон бие махбодын шийтгэлийг зөвшөөрсөн заалтуудыг хүчингүй болгох талаар арга хэмжээ авсангүй. Гэр бүлийн хүчирхийлэл болон жендэрт суурилсан хүчирхийллийн бусад хэлбэрүүд өргөн тархсан хэвээр байв.

Иран улсын эрх баригчид охид, эмэгтэйчүүдийг хоёрдугаар зэргийн иргэд мэт үзсээр байсан бөгөөд гэрлэлт, гэрлэлт цуцлалт, хүүхдийн харьяалал, асран хамгаалалт, хөдөлмөр эрхлэлт, өв залгамжлал болон улс төрийн албан тушаал эрхлэх зэрэг харилцаанд тэдний тэгш эрхийг үгүйсгэсэн. Охидын гэрлэх доод нас 13 хэвээр байв. Хижаб заавал өмсөх шаардлагыг өргөн хүрээнд эсэргүүцсэн нь өмнөх жилүүдэд гарч байсан хүчирхийлэл дагуулсан олныг хамарсан баривчилгааг зогсоох, шинэ хижабын хуулийн хэрэгжилтийг түр түдгэлзүүлэхэд хүргэсэн. Гэвч эрх баригчид одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийг ашиглан ажлын байр, их дээд сургууль болон төрийн байгууллагуудад хижаб заавал өмсөх шаардлагыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд, үүнийг эсэргүүцсэн охид, эмэгтэйчүүдийг дарамтлах, биед нь халдах, дур зоргоор баривчлах, торгох, ажлаас халах, сургуулиас хөөх зэргээр байнгын эрсдэлд оруулсан.

### ЛГБТИ ХҮМҮҮС

Бүс нутгийн олон улсад хүмүүсийг бэлгийн чиг баримжаа, жендэрийн илэрхийлэлд үндэслэн баривчилж, эрүүгийн хэрэгт ялласан бөгөөд зарим улсад ижил хүйстний харилцан зөвшөөрсөн бэлгийн харилцаанд хатуу ял шийтгэл оногдуулсан.

Йемен улсын эрүүгийн хуульд ижил хүйстний бэлгийн харилцааг гэмт хэрэгт тооцож, хорих ял болон чулуугаар шидэж цаазлах ял шийтгэсэн хэвээр байв. Алжир, Марокко улсын эрх баригчид насанд хүрсэн хүмүүсийн ижил хүйстний харилцан зөвшөөрсөн бэлгийн харилцааг эрүүгийн хэрэгт тооцсон хэвээр байсан бол Тунист ийм төрлийн хэрэгт ял шийтгэх нь нэмэгдсэн.

## УГСААТНЫ БОЛОН ШАШНЫ ЦӨӨНХ

Бүс нутаг даяар үндэсний, угсаатны болон шашны бүлгүүд, цөөнхийн гишүүд хууль тогтоомж, практикт гүн бат үндэслэсэн ялгаварлан гадуурхалтад өртсөөр байсан бөгөөд итгэл үнэмшилтэй байх, хүний эрхийн бусад ноцтой зөрчлөөс ангид амьдрах эрх нь ноцтой зөрчигдсөн.

Иран улсад угсаатны цөөнхүүд боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, шаардлагад нийцсэн орон байртай байх, улс төрийн албан тушаал эрхлэх зэрэг харилцаанд ялгаварлан гадуурхалтад өртөж, бусад хүний эрх нь зөрчигдсөн. Ираны шашны цөөнхийн гишүүдийг шашин шүтэх, эсхүл шашны зан үйл хийснийх нь төлөө дур зоргоор саатуулж, шударга бусаар яллаж, эрүү шүүлт тулгаж, бусад зүй бусаар харьцсан.

Ливи улсад наймдугаар сараас аравдугаар сарын хооронд Ливийн Арабын Зэвсэгт хүчний удирдлагад харьяалагддаг зэвсэгт бүлэг болох Субул аль-Салам батальон болон ЛАЗХ-тай холбоотой цагдаагийн байгууллагууд Куфра дүүрэгт Тебу үндэсний иргэдийг үндэс угсаагаар ялгаварлан хууль бусаар алах, дур зоргоор баривчлах, хүчээр алга болгох зэрэг зөрчил үйлдсэн.

**Засгийн газрууд арьс өнгө, үндэс угсаа, шашин, жендэр, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэл зэрэг шинжээр ялгаварлан гадуурхахыг эцэс болгох ёстой. Тэд ялгаварлан гадуурхалгүйгээр бүх хүнд тэгш эрх эдлүүлэх хууль, бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлж, үзэл бодол, үзэл санаа, шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрхийг хамгаалж, дэмжиж, баталгаажуулах шаардлагатай.**



[www.amnesty.org](http://www.amnesty.org)  
[www.amnesty.mn](http://www.amnesty.mn)

